

**Үйлдвэрийн хаягдал ус
урьдчилан цэвэрлэх байгууламж
суурилуулах үйлдвэр, аж ахуйн
нэгжүүдийг чиглүүлэх төрийн
захиргааны байгууллагын
ажилтнуудад зориулсан гарын
авлага**



**Улаанбаатар хотын
үйлдвэрийн хаягдал усны
хяналтын чадавхыг
бэхжүүлэх төсөл**

Өмнөх үг

Энэхүү гарын авлагыг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАИКА-гийн хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагуудын зөвлөх, зааварлах чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 онд боловсрууллаа. Гарын авлагын агуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (ХББОСЯ), Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), Нийслэлийн Засаг даргын тамгын газар (НЗДТГ), Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо (ХСУХАТАҮЗХ), “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (УСУГ) болон Барилгын хөгжлийн төв (БХТ) зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн төслийн Ажлын хэсгийн гишүүд ЖАИКА-гийн Зөвлөх баг буюу Ниппон Коэи компанийн дэмжлэгтэйгээр хамтран бэлтгэлээ.

<u>Тайлбар:</u> Энэ бичиг баримтад холбогдох хууль, тогтоомжийг дэлгэрэнгүй тусгах боломжгүй тул өөрсдийн хэрэгцээнд тохируулан ашиглана уу. Японы Засгийн газар, ЖАИКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон Ниппон Коэи компани нь тус бичиг баримтын агуулгад хариуцлага хүлээхгүй болно.

Агуулга

БҮЛЭГ 1 ТАНИЛЦУУЛГА.....	1-1
1. Үндэслэл	1-1
2. Зорилго	1-1
3. Гарын авлагын зорилтот хэрэглэгч.....	1-2
БҮЛЭГ 2 Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулах үндэслэл	2-1
1. Төв цэвэрлэх байгууламж болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрт үзүүлэх сөрөг нөлөө.....	2-1
2. Туул голын бохирдлыг бууруулах.....	2-1
3. Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах	2-1
4. Байгаль орчны чиглэлийн төрөл бүрийн хөнгөлөлтүүдийг ашиглах.....	2-1
5. Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн нэр хүндийг дээшлүүлэх	2-2
6. Ханган нийлүүлэх сүлжээний шаардлагыг хангаж, олон улсын түвшинд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх	2-2
БҮЛЭГ 3 Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахад тавигдах хууль эрхзүйн шаардлага	3-1
1. Танилцуулга.....	3-1
2. УЦБ-ийг байгуулахаасаа өмнө төлөвлөх	3-2
3. Тохирсон УЦБ-ийн зураг төслийг боловсруулах, суурилуулах	3-7
4. УЦБ-ийн ашиглалт болон засвар үйлчилгээ.....	3-10
БҮЛЭГ 4 Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахад авч үзэх техникийн асуудлууд	4-1
1. Танилцуулга.....	4-1
2. Хууль, эрхзүйн орчин болон ашиглалтанд тавигдах шаардлагууд	4-1
3. Ажлын даалгавар боловсруулах.....	4-2
4. Гарах хаягдал усны урьдчилсан тооцоолол	4-3
5. Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахгүйгээр хаягдал усны хэмжээ болон бохирдлыг бууруулах арга хэмжээ	4-4
6. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх.....	4-5
7. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах.....	4-7
8. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглах	4-8
БҮЛЭГ 5 Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо	5-1
1. Санхүүгийн дэмжлэгийн тогтолцоо.....	5-1
2. Мэдээллээр хангаж, дэмжих тогтолцоо.....	5-3
3. Төрийн захиргааны байгууллагуудтай холбогдох.....	5-7

ХАВСРАЛТ:

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламж: Хууль, тогтоомж, эрхзүйн бичиг баримтын судалгаа

БҮЛЭГ 1 ТАНИЛЦУУЛГА

1. Үндэслэл

Улаанбаатар хотын хүн ам 2040 он гэхэд 2 саяд хүрэх төсөөлөлтэй байгаа бөгөөд энэ хирээр усны хэрэглээ нэмэгдэж 2020 онд 181000м³ байсан бол 2040 он гэхэд 718000м³ болохоор байна. Үүнтэй холбогдуулан Монголын Мянганы сорилтын сан (ММСС)-гийн дэмжлэгтэйгээр ус хангамжийн баруун эс үүсвэрийг Биокомбинат, Шувуун фабрик орчимд байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мөн ариутгах татуургын системийг өсөн нэмэгдэж буй усны хэрэглээтэй уялдуулан өргөтгөж, шинэчлэх шаардлага тулгарч байна. Хоногт 230000м³ бохир ус хүлээн авах хүчин чадалтай одоогийн Төв цэвэрлэх байгууламж (ТЦБ) нь 1964 онд байгуулагдан ашиглалтад орсон бөгөөд хэдийнээ хуучирч өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байна. Тиймээс Улаанбаатар хотын хувьд хоногт 250000м³ бохир ус хүлээн авах хүчин чадалтай Шинэ ТЦБ-ийг байгуулах, мөн газрын гүний усны хэрэглээг бууруулах зорилгоор хоногт 50000м³ хаягдал ус дахин боловсруулж дулааны цахилгаан станцын хөргөлтийн технологийн ус болгон нийлүүлэх үйлдвэр байгуулах гэсэн чухал ач холбогдолтой 2 төсөл хэрэгжүүлж байна.

Гэсэн хэдий ч одоо ТЦБ-д ирж буй хаягдал усны бохирдол нь шинэ ТЦБ-д хүлээн авах хаягдал усны бохирдлын ачааллын тооцооллоос хэтэрсэн байгаа бөгөөд улмаар шинэ ТЦБ болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр (ХУДБҮ)-ийн ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл учруулах эрсдлийг бий болгоод байна. ТЦБ-д ирж буй хаягдал усны бохирдлын голлох эх үүсвэр нь үйлдвэрийн хаягдал ус бөгөөд зарим үйлдвэрийн хаягдал ус хүнд металлын агууламжтай байгаа нь шинэ ТЦБ-ийн ажиллагаанд, тухайлбал лаг боловсруулах ажиллагаанд хүндрэл учруулах төлөвтэй байна. Тиймээс “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө” (ҮХУУЦТ)-ний дагуу үйлдвэрүүд урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулан, үйлдвэрийн хаягдал усны бохирдлын түвшинг MNS6561:2024 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартад хүргэснээр бохирдлын ачааллыг бууруулах ёстой юм.

2. Зорилго

Энэхүү гарын авлагыг төрийн захиргааны байгууллагууд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламж төлөвлөх, суурилуулах, ашиглах талаар зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан болно. Уг гарын авлагад үйлдвэр, аж ахуйн нэгжүүд урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

үндэслэл, хууль эрх зүйн орчин, авч үзэх шаардлагатай техникийн асуудал, дэмжлэг үзүүлэх механизмын талаар тусгасан болно.

3. Гарын авлагын зорилтот хэрэглэгч

Гарын авлагын зорилтот хэрэглэгч нь Улаанбаатар хотын ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хаягдал усаа нийлүүлдэг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хянах, зөвлөх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын ажилтнууд буюу ХББОСЯ, ХХААХҮЯ, БОУАӨЯ, ЭМЯ, ХСУХАТАҮЗХ, УГ, БХТ, НЗДТГ, УБЗАА, НБОГ, НХШГ, НЭМГ, УСУГ, ОСНААУГ, дүүргийн ЗДТГ болон бусад холбогдох байгууллагуудын ажилтнууд байх юм.

БҮЛЭГ 2

Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулах үндэслэл

1. Төв цэвэрлэх байгууламж болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрт үзүүлэх сөрөг нөлөө

Шинэ ТЦБ-д ирэх хаягдал усны бохирдлын түвшин 2013 оныхтой ижил түвшинд байх тохиолдолд үйл ажиллагаа нь хэвийн байхаар төлөвлөгдсөн. Хэрэв энэ нөхцөл биелэхгүй бол одоогийн ТЦБ-аас ирэх хаягдал усыг хүлээн авах шинэ ТЦБ болон ХУДБҮ төлөвлөсний дагуу ажиллахад хүндрэл үүснэ. Дээрх 2 үйлдвэрийг барьж байгуулах төслүүд нь нийт 400 сая гаруй ам.долларын өртөгтэй бөгөөд Туул голын экосистемийн эрүүл байдлыг хадгалах, Улаанбаатар хотын усны салбарын нөөц болон аюулгүй байдалтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол улсын хувьд бохирдлын ачааллаа бууруулж чадаагүй тохиолдолд БНХАУ болон АНУ-тай байгуулсан гэрээний нөхцлүүд биелэхээргүй болох эрсдэл үүсээд байна.

2. Туул голын бохирдлыг бууруулах

Одоогийн байдлаар ТЦБ-д цэвэрлэгдээд гарч буй хаягдал усны чанарын зарим үндсэн үзүүлэлтүүд нь MNS4943:2015 стандартын шаардлагыг хангахгүй байгаа бөгөөд Туул голын бохирдол болоод түүнээс хамааралтай экосистем, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бий болгож байна. Нөхцөл байдал дээрдэхгүй бол Улаанбаатар хотын гүний ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд шинээр байгуулж буй ундны ус хангамжийн "Баруун эх үүсвэр"-ийн үйл ажиллагаанд ч сөрөг нөлөө үзүүлэх юм. Үүнээс гадна Туул голд хуримтлагдсан лагийг зайлуулж, арилгахад томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай болно.

3. Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд нь үйлдвэрийн хаягдал усны хяналттай холбоотой хууль эрхзүйн зохицуулалт буюу Усны тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль гэх мэт эрхзүйн бичиг баримтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай. Эдгээр хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Түүнчлэн хаягдал ус нь нийслэлийн харъяа УСУГ-ын ариутгах татуургын шугам сүлжээнд гэмтэл учруулсан тохиолдолд эрүүгийн болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болзошгүй юм. Ийм асуудал гаргахгүйн тулд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хууль тогтоомжид заасан шаардлагыг дагаж мөрддөг байх ёстой.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

4. Байгаль орчны чиглэлийн төрөл бүрийн хөнгөлөлтүүдийг ашиглах

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд нь байгаль орчны чиглэлийн төрөл бүрийн хөнгөлөлтөд хамрагдаж болно:

Төрөл	Хөнгөлөлт
Ус бохирдуулсны төлбөр	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8.1-д Ус бохирдуулагчийг дараах нөхцөлд төлбөрөөс чөлөөлнө гэж заасан байдаг: 8.1.1. хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр; 8.1.2. хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр. 8.1.3. хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдсон бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар.
Гаалийн татвар	Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолын хавсралтаар "18.Боловсруулах үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж"-ийн гаалийн албан татвараас хөнгөлөх тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталжээ.

5. Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн нэр хүндийг дээшлүүлэх

Урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулснаар тухайн үйлдвэр, аж ахуйн нэгж нь байгальд ээлтэй хэмээгдэн, нэр хүнд нь өсөх юм. Мөн байгаль орчны сайн менежменттэй байгууллага нь үйлдвэрлэлийн үйл явцын үр ашиг, зохицуулалтын хэрэгжилт, эрсдлийн удирдлага, ажилчдын оролцоо, ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулдаг тул бүтээгдэхүүнийхээ чанарын хяналтыг сайн хийдэг. Үйлчлүүлэгчид болон хэрэглэгчид байгаль орчны менежмент ба чанарын хяналтын хоорондын уялдаа холбоог сайн мэддэг.

6. Ханган нийлүүлэх сүлжээний шаардлагыг хангаж, олон улсын түвшинд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх

Олон улсын компаниудын хувьд хөрөнгө оруулагчид болон үйлчлүүлэгчид нь нийлүүлэлтийн бүх сүлжээнд гаргаж буй шийдвэрээ сайтар нягтлан үздэг тул хөрөнгө оруулалт, худалдан авалтын шийдвэрт нөлөөлөх байгаль орчны хариуцлага улам бүр чухал болж байна. Иймээс Монголд байгаль орчинд ээлтэй компаниуд олон улсын зах зээлд илүү өрсөлдөх чадвартай байдаг ч бүтээгдэхүүний чанар, үнэ нь чухал хүчин зүйл хэвээр байна.

Өөрийн бүтээгдэхүүн болон үйлчилгээг байгальд ээлтэй, мөн ханган нийлүүлэлтийн сүлжээний шаардлагад нийцсэн гэдгээ харуулахын тулд бизнесийн байгууллагууд эко шошго авах нь их үр дүнтэй байдаг. Арьс ширний болон ноос, ноолуурын үйлдвэрлэлийн баталгаажуулалтын системийг доор жишээ болгон үзүүллээ. Урьдчилан цэвэрлэх

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

байгууламж суурилуулсан байх, байгаль орчны ээлтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь эдгээр гэрчилгээг авахад тус нэмэр болдог.

■ **Арьс ширний үйлдвэрийн баталгаажуулалтын систем**

Олон улсын түвшинд арьс ширний үйлдвэрлэл дэх гэрчилгээжүүлэлт (сертификатжуулалт) буюу баталгаажуулалтын систем дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд:

Leather Working Group(LWG)

Дэлхийн арьс ширний зөвлөл (LWG) нь 2006 оноос эхлэн байгаль орчны аудитын протокол гэдэг нэр бүхий баримт бичгийг боловсруулсан бөгөөд компаниуд тухайн протоколын шалгуурыг хангаж байгаа эсэхийг шалгадаг байна. Дэлхийн дахинд ойролцоогоор 2000 орчим компани энэхүү сертификатыг авсан ба тухайн компанийн байгаль орчныг хамгаалахад оруулсан хувь нэмрийг нь харгалзан алт, мөнгө, хүрэл гэсэн ангилал бүхий үнэлгээ хийдэг. Сертификатыг арьс ширний үйлдвэрлэлийн зөвхөн тодорхой хэсгийг үйлдвэрлэдэг компаниуд ч авах боломжтой. Байгаль орчны аудит нь үйлдвэрлэлийн процесст хяналт хийх явцдаа магадлан шалгадаг хэд хэдэн үйл ажиллагаануудын нэг нь "Хаягдал ус цэвэрлэх" юм.

Холбоос <https://www.leatherworkinggroup.com/>

Istituto di Certificazione della Qualità per l'Industria Conciaria (ICEC)

Тус байгууллагыг Италийн арьс ширний үйлдвэрүүд анх байгуулсан бөгөөд "Байгаль орчны менежментийн систем (ISO 14001)", "Байгаль орчны менежмент ба аудитын тогтолцоо (EMAS)", "Эко-арьс" зэрэг холбоотой хэд хэдэн төрлийн сертификатыг олгодог. ICEC байгууллагаас олгосон сертификат нь нэг жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд зэрэглэлээр нь дөрвөн түвшинд эрэмбэлдэг байна. Энэ байгууллага нь сертификат олгохоос гадна гадаад улсын компаниудад техник мэдээлэл сурталчилгааны дэмжлэг үзүүлэх ажлуудыг зохион байгуулдаг.

Холбоос <https://www.icec.it/en>

Sustainable Textile and Leather Production (STeP)

Энэ нь Европ, АНУ, Азийн олон улс орнуудад мөрдвөл зохих зарим шаардлагыг дурдсан ОЕКО-ТЕХ байгууллагаас баталсан олон улсын аюулгүй байдлын стандарт юм. Стандарт үнэлгээний зургаан шалгуурын нэг болох Байгаль орчны гүйцэтгэл нь ус болон бусад нөөцийн ашиглалт, хэрэглээ, зайлуулах чиглэлийн арга барилыг тодорхойлдог. Энэ нь зөвхөн арьс ширний төдийгүй нэхмэлийн үйлдвэрлэлд ч хамаатай.

URL <https://www.oeko-tex.com/en/>

■ Нэхмэлийн үйлдвэрлэлийн баталгаажуулалтын систем

Олон улсын түвшинд нэхмэлийн үйлдвэрлэл дэх баталгаажуулалтын систем дараах байдлаар хэрэгжиж байдаг. Үүнд:

Bluesign

Энэ нь 2000 онд Швейцарын bluesign технологийн дагуу бүтээгдсэн систем юм. Байгаль орчинд ээлтэй байдлыг баталгаажуулдаг сертификатын систем бөгөөд нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шат бүрт байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг баталгаажуулдаг. Үйлдвэрлэлд ашигласан түүхий эд материал нь химийн хорт бодисын агууламжгүй, үйлдвэрлэлийн явцад хорт нэгдлийг ус, хөрс, агаарт ялгаруулахгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Холбоос <https://www.bluesign.com/en>

Global Organic Textile Standard (GOTS)

Глобал органик нэхмэлийн стандартыг Герман улсад төвтэй ашгийн бус хязгаарлагдмал хариуцлагатай компани олгодог ба органик нэхмэлийн үйлдвэрлэлд олгодог дэлхийн стандарт юм. Энэхүү стандарт нь байгаль орчин, нийгмийн хариуцлагын үүднээс нэхмэлийн үйлдвэрлэлд мөрдвөл зохих шаардлагыг үе шат бүрт биелүүлэхийг шаарддаг. Мөн өөрийн үндэсний болон олон улсын бүс нутгийн хэмжээнд байгаль орчны болон холбогдох хууль эрх зүйн шаардлагыг үйлдвэрийн бохир ус, лагийг боловсруулах, зайлуулах ажиллагаанд мөрдөж ажилласан байх ёстой гэсэн шаардлага тавьдаг.

Холбоос <https://global-standard.org/>

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХУВЬСАЛ БА

ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Олон улсын ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх байгаль орчны асуудлуудыг сонирхох байдал нь олон жилийн туршид ихээхэн өөрчлөгдсөөр ирсэн. Монголын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, бизнесийн байгууллагууд олон улсын хэрэглэгчдийнхээ нөхцөл байдлыг ойлгох нь чухал бөгөөд хэрэглэгч ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх байгаль орчны асуудлыг нэн тэргүүнд тавьж байгаа шалтгааныг ойлгох нь чухал юм.

Түүхэн нөхцөл байдал

Монголын бизнесийн байгууллагууд хаягдал усаа хянах үр дүнтэй арга хэмжээг хараахан авч амжаагүй байгаа бол Япон, Баруун Европ, АНУ зэрэг орнууд 1970-аад оны эхээр эдгээр санаачилгуудыг хэрэгжүүлж байжээ. 1950, 1960-аад онд эдийн засгийн хурдацтай тэлэлтийнхээ үеэр байгаль орчны бохирдол ихтэй байсан Япон улс бохирдуулагч компаниуд болон төрийн байгууллагын эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргах

давалгааг туулж өнгөрүүлсэн юм. Энэ олон нийтийн эсэргүүцэл нь 1970-д онд Усны бохирдлоос урьдчилан сэргийлэх хууль батлахад хүргэсэн бөгөөд 1975 он гэхэд ихэнх томоохон компаниуд урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулсан байжээ. Ийм чиг хандлага байгаль орчныг хамгаалах нь тэргүүлэх чиглэл болсон бусад аж үйлдвэржсэн орнуудад ч газар авсан байна. 1973 онд олон улсад газрын тосны үнэ огцом өссөнөөр компаниудыг эрчим хүч, нөөцийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэхэд түлхэц болсон байна. Өнөөдөр эдгээр бүс нутгийн ихэнх компаниуд хаягдал ус зайлуулах стандартыг дагаж мөрдөж байгаа нь энэ шаардлагыг хангахын тулд хүчин чармайлт гаргаж байгаа хөгжиж буй орнуудтай харьцуулахад эрс ялгаатай юм.

Дэлхий дахинд эдийн засаг, ялангуяа социалист дэглэм задран унасны дараа улам бүр харилцан уялдаатай болж байгаагийн хэрээр олон улсын олон компаниуд өндөр ашиг олох зорилгоор үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа Мексик, Зүүн Европ, Зүүн өмнөд Ази зэрэг орнууд руу нүүлгэн шилжүүлсэн. Үүний зэрэгцээ эдгээр компаниудыг байгаль орчныг хамгаалах зөөлөн зохицуулалттай улс орнууд буюу "бохирдлын диваажин" гэж нэрлэдэг улс орнуудыг мөлждөг гэж ихэвчлэн буруутгадаг.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, усны хомсдол, өргөн тархсан бохирдол, биологийн төрөл зүйлийн хомсдол, нөөцийн төлөөх өрсөлдөөн зэрэг дэлхийн хэмжээнд тулгамдаж буй сорилтууд эрчимжиж байна. Эдгээр асуудлууд нь олон улсын хамтын нийгэмлэгт олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нөлөөлж буй байгаль орчны менежментийн шинэ давалгааг эхлүүлэхэд түлхэц болсон юм.

Тогтвортой хөгжлийн зорилгууд (SDGs)

НҮБ-аас 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн зорилгууд нь хүн бүрт илүү сайн, тогтвортой ирээдүйг бий болгоход чиглэсэн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог төлөөлдөг. ТХЗ нь 2030 он гэхэд хүрэх ёстой 17 зорилго, 169 зорилтоос бүрдэж байгаа бөгөөд Монгол Улс эдгээр зорилгод гарын үсэг зурсан анхны орнуудын нэг юм.

Эдгээрийн дотроос "Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах" 6-р зорилго, тухайлбал, зорилт 6.3-т "2030 он гэхэд дэлхийн түвшинд бохирдлыг бууруулах, хог хаях ажиллагааг халах, аюултай химийн бодис, материалыг гаргах явдлыг хамгийн бага түвшинд хүргэх, цэвэрлэгдээгүй бохир ус хувь хэмжээг хоёр дахин бууруулах, усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн хэрэглэх явдлыг [х] хувиар нэмэгдүүлэх замаар усны чанарыг сайжруулах" гэсэн нь үйлдвэрийн хаягдал усны менежментэд хамгийн их хамааралтай. Зорилт 6.3 нь 2 үзүүлэлттэй бөгөөд 6.3.1 Дахин боловсруулж, сайтар ариутгасан бохир усны эзлэх хувь, 6.3.2 Хүний эрүүл мэндэд эрсдэлгүй байгалийн чанартай ус хүлээн авагчдын эзлэх хувь гэж тусгасан байдаг. Монгол Улс эдгээр

үзүүлэлтүүдийн төлөв байдлын талаар тогтмол мэдээлж, зорилгоо биелүүлэх төлөвтэй байна.

Компанийн нийгмийн хариуцлага (Corporate social responsibility)

Нийгмийн хариуцлага гэдэг нь компани нь байгаль орчин, нийгмийн асуудлыг бизнесийн үйл ажиллагаандаа хамруулан нэгтгэдэг бизнесийн загвар юм. Компанийн олон нийтийн дундах болон хөрөнгө оруулагчдын нэр хүндийг өсгөж, улмаар компанийн нэр хүндийг сайжруулах зорилгоор нийгмийн хариуцлагыг ихэвчлэн хэрэгжүүлдэг. Нийгмийн хариуцлагын гол элементүүд нь байгаль орчныг хамгаалах өндөр гүйцэтгэл, ёс суртахууны дадал зуршил, сайн дурын үйл ажиллагаа зэрэг орно. Үүнд байгальд ээлтэй бүтээгдэхүүн санал болгох, тогтвортой эх үүсвэр, шударга худалдааны туршлага, үйл ажиллагааны ил тод байдал, орон нутгийн иргэдийг дэмжих зэрэг орно.

Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)

Амжилттай, ашиг орлоготой компаниуд/төслүүд байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлагатай байдгийг хүлээн зөвшөөрч, байгаль орчин, нийгэм, засаглалын арвин туршлага бүхий компаниудад урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжийг тодорхойлох хүсэлтэй хөрөнгө оруулагчид ESG-ийн өсөлтөд голлон нөлөөлжээ.

Байгууллагын удирдлагын зүгээс ESG-ийн асуудалд тууштай хандах, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ, хог хаягдлын болон хаягдал усны менежмент, хөдөлмөрийн харилцаа, хүүхдийн хөдөлмөрийн ашиглалт, авлига гэх мэтийг багтаасан боловч үүгээр хязгаарлагдахгүй ESG-ийн талаарх мэдээллийг ил тод болгох нь ESG-ийн чухал тал юм. Ийм мэдээллийг компаниудын ESG гүйцэтгэлийг үнэлэх, компанийн хувьцааны үнэд нөлөөлөх хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашигладаг.

Үндэстэн дамнасан корпорациудын хувьд олон орнуудын ханган нийлүүлэгчдийг оролцуулаад бүхэл бүтэн нийлүүлэлтийн сүлжээнийхээ ESG гүйцэтгэлийг үнэлэх нь чухал байдаг. Энэ нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, тэр дундаа Монголын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд байгаль орчны гүйцэтгэлийг нэн тэргүүнд тавих нь чухал болж байна. Хятад зэрэг АСЕАН (Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг)-ы бүс нутаг болон бусад орнууд ч олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн учраас энэ чиг хандлагыг дагаж байна.

БҮЛЭГ 3


Урьдчилан байгуулахад шаардлага

цэвэрлэх тавигдах

байгууламж хууль, эрхзүйн

1. Танилцуулга

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулж, ашиглахын тулд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх шаардлагатай. Шинээр байгуулах эсвэл одоо байгаа урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглахтай холбоотой дүрэм, журмуудыг доорх зурагт нэгтгэн харууллаа.



Зураг 1 Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулах болон ашиглахтай холбоотой үе шатууд

Зураг 1-ийн дагуу энэ бүлэгт дараах алхмуудын үндсэн үе шатуудыг товч тоймлон харуулав.

- УЦБ-ийг төлөвлөх
- Тохирох УЦБ-ийн зураг төслийг боловсруулж, суурилуулах
- Ашиглалт болон засвар үйлчилгээ

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Зураг 1-т заасан дүрэм, журмуудын ихэнх нь MNS6561 стандартыг 2024 онд шинэчлэгдэхээс өмнө мөрдөгдөж байсан тул хувийн хэвслүүд болон төрийн захиргааны байгууллагууд энэ талаар ойлголт, мэдээлэлтэй байгаа. Гэсэн хэдий ч эдгээр дүрэм, журмууд нь нэлээд төвөгтэй бөгөөд ихэнх нь бүрэн хэрэгждэггүй. Үүнээс болж үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, тэр байтугай зарим төрийн албан хаагчид ч тавигдаж буй шаардлагыг бүрэн ойлгохгүй байх магадлалтай.

Нэмж дурдахад үйлдвэр, аж ахуйн нэгжүүд болон холбогдох төрийн байгууллагуудын ихэнх нь эдгээр зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай нөөцгүй, мөн бэлтгэгдээгүй байдаг. Тиймээс төрийн захиргааны байгууллагууд бохирдлын ачааллыг дорвитой бууруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

2. УЦБ-ийг төлөвлөх

Төлөвлөлтийн шатанд тавигдах хууль эрхзүйн шаардлагуудыг энэ хэсэгт авч үзлээ. Тухайн салбарын гол хууль тогтоомж, дүрэм журам болон тэдгээрийн шаардлагуудын талаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө өгч, чиглүүлэхийн тулд төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнууд эдгээр хууль, дүрэм журам, стандартын уялдаа холбоо, харилцан хамаарлыг ойлгож мэддэг байх нь чухал. Үүнд доор дурдсан хуулиуд багтах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүйг анхаарна уу.

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Усны тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Байгаль хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Бусад

Гол хууль тогтоомж, дүрэм журмуудын нэгдсэн мэдээллийг Хавсралтаас харна уу.

Мөн урьдчилан цэвэрлэх байгууламжтай эсэхээс үл хамааран ариутгах татуургын сүлжээнд хаягдал ус нийлүүлэхэд шаардагдах зөвшөөрлүүдийг авч, гэрээ байгуулсан эсэхээ магадлах ёстой. Илүү чухал зөвшөөрлүүд болон гэрээний талаар доор тайлбарлалаа. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнууд шинэчлэгдэн батлагдсан MNS6561:2024 стандартын шаардлагуудын талаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд заавар өгч, чиглүүлэх ёстой.

■ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэг нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас улбаалан байгаль орчинд нөлөөлж болзошгүй асуудлуудыг үнэлэх, байгаль орчинд

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, бууруулах зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу) боловсруулж хэрэгжүүлэхтэй холбоотой чухал процедур бөгөөд Барилгын тухай хуулийн дагуу барилга байгууламжид тавигдах шаардлагуудын нэг юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн Хавсралтад заасны дагуу төслийн ангиллаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтээ гаргах бөгөөд жишээлбэл, жижиг, дунд үйлдвэрүүд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах хүсэлтээ Нийслэлийн байгаль орчны газарт хандан илгээнэ.

■ Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл

Усны тухай хуулийн 24.2-р зүйл болон 30.1.3-р заалтын дагуу үйлдвэр, аж ахуйн нэгж нь хаягдал усаа ариутгах татуургын сүлжээнд (MNS6561:2024 стандартын дагуу) эсвэл байгальд (MNS4943:2015 стандартын дагуу) нийлүүлэхээс үл хамааран Туул голын сав газрын захиргаа (хаягдал усны хэмжээ $50\text{м}^3/\text{хоног}$ -с бага үед)-наас, эсвэл сум, дүүргийн Засаг дарга ($50\text{м}^3/\text{хоног}$ -с их үед)-аас зөвшөөрөл авна. Үүний зэрэгцээ өөрийн худгаас гүний ус ашигладаг тохиолдолд холбогдох зөвшөөрлүүдийг авсан эсэхийг магадлах хэрэгтэй, учир нь MNS6561:2024 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг хоногт зайлуулах хаягдал усны хэмжээтэй уялдуулсан бөгөөд УСУГ хаягдал усны хэмжээг цэвэр усны хэрэглээгээр тооцоолдог.

■ Хаягдал ус зайлуулахдаа хангагч байгууллагатай гэрээ хийх

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13-р зүйлд заасны дагуу үйлдвэр, аж ахуйн нэгжүүд нь үйлдвэрийн хаягдал усаа ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэхдээ хангагч байгууллага (УСУГ болон ОСНААУГ гэх мэт)-тай гэрээ байгуулсан байх ёстой. Ариутгах татуургын систем нь нийслэлийн нэн чухал өмч хөрөнгө гэдгийг тухайн хэрэглэгч буюу аж ахуйн нэгжид ойлгуулах нь зүйтэй бөгөөд хэт хүчиллэг/шүлтлэг болон/эсвэл идэмхий хаягдал ус хаях, хатуу хог хаягдал, их хэмжээний лаг, хүнд металл болон бусад хорт бодис агуулсан бохирдол бүхий хаягдал ус зайлуулах зэрэг үйлдэл нь ариутгах татуургын шугамыг гэмтээх болон үйл ажиллагаанд нь саад учруулах тохиолдолд тухайн аж ахуйн нэгж хохирлыг нөхөн төлөх бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болзошгүй байдаг. Гүний худагтай, хаягдал усаа зөөврөөр ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг үйлдвэр, аж ахуйн нэгж нь MNS6561:2024 стандартыг зөрчсөн тохиолдолд гүний ус ашиглалтын зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэж, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээс сэргийлэх үүднээс ус ашиглалтыг хязгаарлах арга хэмжээ авах нь зүйтэй.

■ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль

Ус бохирдуулсны төлбөрийг тооцох, төлөх гэх зэргийг автоматжуулсан “e-Water” цахим системийг нэвтрүүлснээр Ус бохирдуулсны төлбөрийг тухай хуультай холбогдох

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

процедурт нилээдгүй өөрчлөлт орсон тул эдгээрийн талаар төрийн захиргааны байгууллагын ажилтнууд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд таниулах шаардлагатай. Мөн ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөх боломжийн талаар Бүлэг 1 болон Бүлэг 5-с харна уу.

■ Шинэчлэгдэн батлагдсан MNS6561 стандарт

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжтай холбоотой хууль тогтоомжид 2024 оны 11-р сард шинэчлэгдсэн MNS6561:2024 стандартыг хангасан байх нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах урьдчилсан нөхцөл гэж үздэг. Иймд төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнууд MNS6561:2024 стандартын шаардлагыг сайтар ойлгосноор үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тус стандартыг хэрхэн мөрдөх талаар зөвлөгөө өгөх чадвартай болно. Энэ хэсэгт тус стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим чухал асуудлуудыг товч тайлбарласан болно.

Хүснэгт 1-д MNS6561:2024 стандартын ерөнхий шаардлагыг харууллаа. Үйлдвэрлэлийн салбар болон хоногт зайлуулах хаягдал усны хэмжээнд үндэслэн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг хэрхэн тогтоосныг Зураг 2-т харууллаа.

Хүснэгт 1 MNS6561:2024 стандартын ерөнхий шаардлага

№		Хоногт нийлүүлэх хаягдал усны хэмжээ, м³ (1-р тайлбарыг харах)	Ангилал	Цэвэрлэгээний түвшин	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Ариутгах татуургад холбогдох эсэх
1	1.1	0-15 (3-р тайлбарыг харах)	Ангилал 0,8,12	Механик цэвэрлэгээ	А хавсралт А.1-р хүснэгт	Зөвшөөрнө
	1.2	0-15	Ангилал 1-7, 9-11	Өөрийн талбайд түр хадгалж цэвэрлэх байгууламжид нийлүүлэх (2-р тайлбарыг харах)	Хамааралгүй	Хориглоно
	1.3	0-15		Механик, физик-химийн цэвэрлэгээ	А хавсралт А.1-ээс А.5-р хүснэгт	Зөвшөөрнө
2		15-240	Ангилал 1-12	Механик, физик-химийн цэвэрлэгээ	А хавсралт А.1-ээс А.5-р хүснэгт	Зөвшөөрнө
3		240 -ээс их	Ангилал 1-12	Механик, физик-химийн, биологийн цэвэрлэгээ	А хавсралт А.1-ээс А.5-р хүснэгт	Зөвшөөрнө

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

1- Р ТАЙЛБАР: Ахуйн хэрэглээнээс гарсан зөөврийн хаягдал ус болон хоногт 15 м³-ээс бага хаягдал ус нийлүүлдэг 0, 8, 12 ангиллын үйлдвэрүүдийн хаягдал усанд механик цэвэрлэгээ хийж, А хавсралтын А.1-р хүснэгтэд заасан стандартын шаардлагад нийцүүлэн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлнэ. Хэрэв үйлдвэрүүдийн хаягдал ус нь механик цэвэрлэгээний дараа А.1-р хүснэгтэд заасан стандартын шаардлагыг хангахгүй бол физик химийн түвшний цэвэрлэгээг зайлшгүй хийнэ.

- Үйлдвэрээс хоногт гарах хаягдал усны хэмжээг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн ачаалалтай явагдаж байх үед тогтооно. Зогсолт хийсэн хугацаа нь хаягдал усны эзлэхүүнийг бууруулах тул тооцоололд оруулахгүй;


- Хоногт 240 м³-ээс бага хаягдал ус нийлүүлдэг бол тухайн үйлдвэр механик, физик химийн түвшний цэвэрлэгээ хийнэ;

- Хоногт 240 м³-ээс их хаягдал ус гаргадаг бол тухайн үйлдвэр биологийн түвшний цэвэрлэгээ хийнэ.

Хаягдал усны гаргалгааны шугам дээр хаягдал усны тоолуураар бодит хэмжилт хийдэггүй тохиолдолд хаягдал усны эзлэхүүнийг Усны тухай хуульд заасны дагуу хангагч байгууллагатай байгуулсан гэрээ, эрх бүхий байгууллагаар баталгаажсан тухайн үйлдвэрийн цэвэр усны тоолуурын заалтыг үндэслэн тооцно.

2- Р ТАЙЛБАР: Тухайн үйлдвэр нь өөрийн ангилалд тохирох түвшний цэвэрлэх байгууламжгүй бол хаягдал усыг зөөвөрлөн физик химийн эсхүл биологийн түвшний цэвэрлэх байгууламжид нийлүүлж цэвэрлэнэ.

3- Р ТАЙЛБАР: Эрх бүхий байгууллагаас тусгайлан зааварчлаагүй бол ахуйн хаягдал ус энэ стандартын А хавсралтын А.1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд хаягдал усаа урьдчилан цэвэрлэх үүргээс чөлөөлөгдөнө. 0,8,12-р ангиллын хэрэглэгч нь хоногт 15 м³-ээс их хэмжээтэй хаягдал ус зайлуулдаг бол А хавсралтын А.1-р хүснэгтийн шаардлагыг хангахуйц хаягдал ус цэвэрлэх урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулна.



Эх сурвалж: MNS6561:2024

Зураг 2 Үйлдвэрлэлийн ангилал болон хаягдал усны урсацад тохируулан зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох шалгуур

Хоногийн урсац буюу хоногт зайлуулах хаягдал усны хэмжээ

Тухайн үйлдвэрийн хоногт зайлуулах хаягдал усны хэмжээнээс шаардагдах урьдчилан цэвэрлэх байгууламж, улмаар анхны хөрөнгө оруулалт, ашиглалт, засвар үйлчилгээний зардал нь ихээхэн хамаардаг. Хоногт зайлуулах хаягдал усны хэмжээ 15 м^3 -с дээш байвал механик цэвэрлэгээ (жишээ нь, сараалж гэх мэт) -ээс гадна физик, химийн цэвэрлэгээ (жишээ нь, флокуляци, тунгаах сан газар эсвэл ууссан агаарын флотаци(DAF)) хийх шаардлагатай болно. Хэрэв хаягдал усны 240 м^3 -с дээш байвал тухайн үйлдвэр, аж ахуйн нэгж механик, физик, химийн цэвэрлэгээнээс гадна биологийн цэвэрлэгээ бүхий урьдчилан цэвэрлэх байгууламж ашиглах шаардлагатай болно.

Тиймээс төрийн захиргааны байгууллагын ажилтнууд тухайн үйлдвэрийн хоногт зайлуулах хаягдал усны хэмжээг тодорхой мэдэж байх ёстой бөгөөд энэ нь хаягдал усны хэмжээ нь хэлбэлзэл ихтэй, үйлдвэрлэлийн хэмжээ зах зээлээс ихээхэн хамаардаг үйлдвэрүүдийн хувьд тодорхойлоход хүндрэлтэй юм. Нийт 431 үйлдвэр, аж ахуйн нэгжийн усны хэрэглээний мэдээллээс харахад ойролцоогоор 50 орчим хувь нь хоногт 15 м^3 -аас бага, 48 хувь нь $15\text{-}240 \text{ м}^3$ /хон зарцуулалттай, 2 хувь нь 240 м^3 /хон-оос дээш урсацтай гэсэн тооцоо гарсан.

Цэвэрлэгээний түвшин болон зөвшөөрөгдөх дээд хэмжээ

MNS6561:2024 стандартад цэвэрлэгээний түвшин (механик цэвэрлэгээ, физик химийн цэвэрлэгээ болон биологийн цэвэрлэгээ) болон зөвшөөрөгдөх дээд хэмжээ (агууламж) аль аль нь дурдагддаг. Тус стандартын 6.3-т зааснаар цэвэрлэгээний түвшин буюу технологийг санал болгож (үүрэг хүлээлгээгүй) байна. Гэсэн хэдий ч зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл цэвэрлэх технологи бүхий урьдчилан цэвэрлэх байгууламжтай байх нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хүлээх үүрэг юм. Зарим тохиолдолд тус стандартын Хүснэгт 1-т тусгасан цэвэрлэгээний түвшин нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнд нийцтэл цэвэрлэх боломжгүй бөгөөд зарим үзүүлэлт (жишээлбэл азот)-ийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг стандартыг батлах эцсийн шатанд чангаруулсан байна.

Цэвэрлэх байгууламж

Өөр нэг чухал асуудал бол үйлдвэрүүдийн ихэнх (Ангилал 1-7, 9-11) нь хаягдал усны хэмжээ нь 15 м^3 /хон-оос бага хэмжээтэй байсан ч механик болон физик химийн цэвэрлэгээтэй байхаас өөр аргагүйд хүрч байна, учир нь эдгээр үйлдвэрүүдийн хаягдал ус харьцангуй бохирдол өндөр байдаг. Энэ нь жижиг болон дунд үйлдвэрүүдэд хүндрэлтэй. Тиймээс MNS6561:2024 нь хаягдал усыг өөрийн талбайд түр хадгалах, ижил төстэй үйлдвэрүүдийн хаягдал усыг хамтран цэвэрлэх зориулалттай дундын цэвэрлэх байгууламж руу зөөвөрлөж цэвэрлэхийг санал болгож байгаа ч одоогоор ийм зориулалттай цэвэрлэх байгууламж байхгүй. Тиймээс холбогдох төрийн захиргааны байгууллагуудын ажилтнууд ижил төстэй үйлдвэрүүдийн хаягдал усыг цэвэрлэх

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

зориулалттай дундын цэвэрлэх байгууламжийг ашиглах хувилбарыг хэлэлцэхийг дэмжиж, дундын цэвэрлэх байгууламжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой.

MNS6561:2024 стандарт нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг дагаж мөрдөхийг шаарддаг. Хэдийгээр тус стандартад цэвэрлэгээний түвшин (механик, физик-химийн болон биологийн цэвэрлэгээ)-г санал болгож байгаа ч тухайн цэвэрлэгээний түвшин бүхий урьдчилан цэвэрлэх байгууламжтай болсноор хаягдал ус нь стандартын шаардлага баараггүй хангана гэсэн үг биш юм.

Дотоод хяналт шинжилгээ

MNS6561:2024 стандарт нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүд нь өөрсдийн хаягдал усыг хянах шаардлага тавьдаг. Ихэнх үйлдвэрүүд ($240\text{м}^3/\text{хон-оос}$ бага хаягдал устай) хаягдал усны урсац, физик болон химийн үзүүлэлтүүдээ улирал тутам хянаж, хүнд метал болон микро элементүүдийг улирал болон жил тутам хянах хэрэгтэй болж байна.

Баталгаажуулсан хаягдал усны тоолуур

Олон үйлдвэр ялангуяа хүнс, ус ундааны үйлдвэрүүдийн хэрэглээний цэвэр усны тодорхой хэсэг нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд шингэдэг. Тиймээс ханган нийлүүлсэн цэвэр усны хэмжээ нь хаягдал усны хэмжээтэй тэнцүү биш юм. Хаягдал усны хэмжээг нарийн хэмжихийн тулд үйлдвэрүүд хаягдал усны тоолуур суурилуулах хэрэгтэй. Гэвч одоогоор Монголд Стандарт хэмжил зүйн газраас баталгаажуулсан бохир усны тоолуур байхгүй бөгөөд зөвхөн цэвэр усны тоолуур ашиглаж байна. Тиймээс төрийн захиргааны байгууллагууд бохир усны тоолуурыг ашиглах тогтолцоог бий болгох шаардлагатай. Ийм тогтолцоо бий болтол холбогдох албан тушаалтнууд дээрх үйлдвэрүүдэд зориулсан түр хэрэглэх шийдэл гаргах нь зүйтэй юм.

3. Тохирсон урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, суурилуулах

Энэ хэсэгт урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах болон суурилуулахтай холбоотой процедурыг тоймлолоо. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг [БҮЛЭГ 4-с](#) харна уу.


■ Барилгын тухай хуулийн дагуу зураг төсөлд магадлал хийлгэх, барилгын ажлын зөвшөөрөл авах болон улсын комисс ажиллуулах нь

Дийлэнх үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн дунд “Урьдчилан цэвэрлэх байгууламж гэдэг нь хөргөгч худалдан авахтай ижил, дэлгүүрээс худалдаж аваад угсрахад л хаягдал усыг стандартын шаардлага хангахуйц хэмжээнд хүртэл цэвэрлэнэ, ямар нэгэн төвөгтэй ажиллагаа, засвар үйлчилгээ хийх шаардлагагүй” гэсэн буруу ойлголт байдаг. Тиймээс зарим үйлдвэрүүд Барилгын тухай хуульд заасан үе шатуудыг дамжилгүйгээр алгасан

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

өөрсдөө урьдчилан цэвэрлэх байгууламж худалдан авч суурилуулсан ч цэвэрлэсэн хаягдал ус нь стандартын шаардлага хангаж чадахгүй байна.

Үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг Барилгын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн байгууллагаар төлөвлөж, суурилуулсны дараа ч тогтмол засвар үйлчилгээ шаардлагатай байдаг. Процедурьг Зураг 3-т харууллаа.



Зураг 3 Урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, суурилуулах

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хувьд өөрийн үйлдвэрт тохирсон урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгуулахын тулд хаягдал усны чиглэлийн мэргэжилтнүүд болон зураг төсөл боловсруулах, суурилуулах ажлыг гүйцэтгэх Гүйцэтгэгчтэй нягт хамтран ажиллах нь чухал юм. Гэсэн хэдий ч Монголд хаягдал усны чиглэлийн инженерүүд тун цөөн байна. Иймээс зарим үйлдвэрүүд хэдийнээ ихээхэн хэмжээний зардал гаргаж, хөрөнгө оруулалт хийсэн ч урьдчилан цэвэрлэх байгууламжаа зөв төлөвлөж, суурилуулж чадаагүй тул зохис ёсоор ажиллуулж, ашиглаж чадахгүй байгаа юм.

Барилгын хөгжлийн төв болон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор доорх 2 бичиг баримтыг боловсрууллаа.

Хүснэгт 2 Урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, суурилуулахтай холбоотой бичиг баримтууд

Бичиг баримтын нэр	Агуулга
Үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг зохистой суурилуулах нь	Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд зориулан боловсруулсан энэхүү баримт бичиг нь хаягдал усны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг зөвлөх компаниуд болон гүйцэтгэгчтэй хамтран ажиллахдаа анхаарах ёстой чухал асуудлуудыг онцолсон болно.
Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийн суурилуулалтыг хянах процедурын гарын авлага	БХТ болон бусад холбогдох байгууллагуудад зориулагдсан энэхүү баримт бичигт үйлдвэр, аж ахуйн нэгжийн (мөн тэдний зөвлөх компани, гүйцэтгэгч) бөглөж, ирүүлэх маягтуудыг хавсаргасан болно. Эдгээр маягтыг бөглөснөөр үйлдвэр, аж ахуйн нэгж нь төлөвлөлтөө зохих ёсоор харуулж, эрх бүхий байгууллагад шаардлагатай мэдээллийг стандартын дагуу өгөх боломжтой.

Урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах болон суурилуулах явцад анхаарах техникийн асуудлуудын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү гарын авлагын БҮЛЭГ 4-с харна уу.

■ Газар ашиглалтын асуудлыг шийдвэрлэх

Зарим үйлдвэр, аж ахуйн нэгжүүд урьдчилан цэвэрлэх байгууламж барих зай талбай буюу газар ашиглалтай холбоотой асуудлууд, тухайлбал цэвэр усны нөөцийн бүс, тухайн орон нутгийн газар өмчлөх төлөвлөгөөнд багтсан байх гэх мэттэй тулгарч байна. Тиймээс УЦБ байгуулахдаа аль болох эхний үе шатанд газартай холбоотой асуудлаа Барилгын хуулийн дагуу шийдвэрлэсэн байхыг хичээх нь зүйтэй.

■ Хаягдал ус хадгалах сантай холбоотой бичиг баримтын төсөл

Үйлдвэрийн хаягдал ус хадгалах сан (цооног)-гийн техникийн шаардлагын төслийг боловсруулсан бөгөөд агуулгад хаягдал усны санг хэрхэн байрлуулах, ямар материалаар хийх, багтаамжийг яаж тооцоолох талаар болон газрын гүн рүү хаягдал ус нэвчиж бохирдуулахгүйн тулд ямар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэргийг багтаасан.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Тус төсөл нь эрхзүйн бичиг баримт болж батлагдсаны дараа хаягдал усны сан байгуулахад дагаж мөрдөх юм.

4. Ашиглалт болон засвар үйлчилгээ

Ашиглалтын үе шатанд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд зарим зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай байдаг. Гол чухал зөвшөөрлүүдийг дор дурдлаа. Төрийн захиргааны байгууллагын ажилтнууд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд энэ талаар зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, тухайлбал Зөрчлийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудийн талаар таниулах шаардлагатай бөгөөд тухайн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагатай холбоо барихыг зөвлөх хэрэгтэй.

■ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос олгодог тусгай зөвшөөрөл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12-р зүйлийн дагуу үйлдвэр, аж ахуйн нэгжүүд нь урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглахдаа Хот, суурины ус, хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Хэрвээ мэргэжлийн байгууллагаар угсралт, суурилуулалтыг гүйцэтгүүлэх бол тухайн Гүйцэтгэгч компани нь мөн дээр дурдсан тусгай зөвшөөрлийг эзэмшдэг байх ёстой. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын талаар тус байгууллагын вэб хуудаснаас мэдээлэл авч болно:

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”

Холбоос: http://api.wsrc.gov.mn/media/editor/TZNSH-shine_togtool.pdf

■ Химийн бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд химийн бодисыг импортлох, ашиглахдаа БОУАӨЯ-аас зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг доорх холбоосоор орж харна уу. Мөн бусад холбогдох мэдээллийг тус яамны вэб хуудсаас авч болно.

Холбоос: <https://mecc.gov.mn/documents/b-rd-leh-bichig-barimt?sort=date&order=desc&show=39>

■ Эрх бүхий бохир ус тээвэрлэгчтэй гэрээ байгуулах

Хэрэв үйлдвэр, аж ахуйн нэгж нь ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй, хаягдал усаа хаягдлын сан буюу цооногт хадгалдаг бол ХСУХАТАҮЗХ-оос “Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх” тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий бохир ус зөөвөрлөгч байгууллагатай гэрээ хийж өөрийн хаягдал усаа тээвэрлүүлнэ.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Хүнд метал гэх мэт бохирдуулагчид усанд уусдаггүй бөгөөд хаягдал усны сангийн ёроолд лаг болон тунаж үлддэг. Энэ лагийг соруулж ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх нь ТЦБ-ийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх төдийгүй хүнд металын агууламжтай лаг маш ихээр бий болно. Мөн ариутгах татуургын сүлжээд хатуу хог хаягдал орсноор ТЦБ-ийн үйл ажиллагаанд хүндрэл учруулна. Тиймээс эдгээрийг төвлөрсөн сүлжээнд нийлүүлэхээс аль болох зайлсхийхийг уриалдаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг ХСУХАТАҮЗХ-ны вэб хуудаснаас буюу доорх холбоосоор авч болно:

Холбоос: https://api.wsrc.gov.mn/media/editor/Bohir_mashin.pdf

■ Эрх бүхий хог хаягдал тээвэрлэгчтэй гэрээ байгуулах

Үйлдвэр, аж ахуйн нэгж энгийн хог хаягдлаа эрх бүхий байгууллага буюу дүүргийн Засаг даргатай гэрээ хийсэн байгууллагаар тээвэрлүүлэх бөгөөд аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тусад нь гэрээ хийж тээвэрлүүлнэ. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг БОУАӨЯ-ны вэб хуудаснаас доорх холбоосоор авч болно.

Холбоос: <https://mecc.gov.mn/storage/library-items/April2023/0pWDIdIj4sEr45GK4tMK.pdf>


Урьдчилан цэвэрлэх байгууламжаас гарах лаг болон хатуу хаягдлын зохицуулалттай холбоотой бичиг баримтын төслийг боловсруулсан бөгөөд тун удалгүй албан ёсоор эрхзүйн бичиг баримт болж батлагдах төлөвтэй байна. Мөн ММСС “Лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж байна.

БҮЛЭГ 4

Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахад авч үзэх техникийн асуудлууд

1. Танилцуулга

Энэ хэсэгт урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгуулахдаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн ойлгох ёстой, авч үзэх шаардлагатай техникийн асуудлуудыг хураангуйлан тусгалаа. Олон үйлдвэрүүд урьдчилан цэвэрлэх байгууламжийн талаар ойлголт, мэдлэгтэй өөрийн гэсэн мэргэжилтэнгүй байдаг. Тиймээс ийм үйлдвэрүүдийн хувьд урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, байгуулах, ашиглалт болон засвар үйлчилгээг хариуцах хөндлөнгийн хаягдал усны мэргэжилтнүүд болон гэрээт гүйцэтгэгч байгууллагууд (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-тай хэрхэн хамтран ажиллахаас зохистой урьдчилан цэвэрлэх байгуулж чадах эсэх нь хамаардаг. Гэсэн хэдий ч Монголд энэ чиглэлийн чадварлаг мэргэжилтэнг олох нь хүндрэлтэй. Зураг 4 -т урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, суурилуулах болон ашиглах ерөнхий үйл явцыг харууллаа.



Зураг 4 Урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгуулах үе шат

2. Хууль, эрхзүйн орчны болон ашиглалтанд тавигдах шаардлагууд

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд аливаа ажлыг эхлэхийн өмнө холбогдох хууль, эрхзүйн шаардлагуудыг сайтар судлан үзэх хэрэгтэй. БҮЛЭГ 3-т голлох хууль, эрхзүйн шаардлагуудын талаар дэлгэрэнгүй тусгасан тул энд давтан оруулаагүй. Дүрэм, журмын хувьд тодорхойгүй зүйлс дээр төрийн захиргааны байгууллагууд зөвлөж тайлбарлах шаардлагатай. Тухайлбал 15 м³/хон-оос бага урсацтай олон жижиг үйлдвэрүүдийн хувьд хаягдал ус хадгалах сан байгуулах, хаягдал усыг зөөвөрлөн дундын цэвэрлэх

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

байгууламжид цэвэрлэх боломжийг бүрдүүлвэл урьдчилан цэвэрлэх байгууламж заавал байгуулах шаардлагагүй болно.

Мөн үйлдвэрүүд ирээдүйд үйлдвэрлэлийн хэмжээ нь өөрчлөгдөнө гэдгийг заавал бодолцох хэрэгтэй. Зах зээлийн нөхцөл байдлаас үйлдвэрлэлийн хэмжээ хамаардаг үйлдвэрүүдийн хувьд энэ нь бэрхшээлтэй байж магадгүй. Иймд төрийн байгууллагын албан тушаалтнууд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн дунд мэдээлэл солилцох (мэргэжлийн холбоодоор дамжуулан) үйл ажиллагааг дэмжиж, ирээдүйн чиг хандлагыг тооцоолсон төлөвлөгөө гаргахад нь туслалцаа үзүүлж болох юм.

3. Ажлын даалгавар боловсруулах

Урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, суурилуулах нь Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага боловч үйлдвэр, аж ахуйн нэгжүүд Гүйцэтгэгчтэй үр дүнтэй хамтран ажиллахын тулд холбогдох бичиг баримтуудыг судлан үзэж, өөрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг үнэлж дүгнэх чадвартай байх шаардлагатай байдаг. 2024 онд Монголын Мянганы сорилтын сангийн боловсруулсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага” нь техникийн шаардлагуудын талаар ойлголттой болоход ихээхэн нэмэр болох бөгөөд тус гарын авлагаас салбарын онцлогыг агуулсан жишээ, кэйсүүд, мөн хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын талаар олж мэдэж болно.


Энэ үе шатанд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд ажлын даалгавар боловсруулснаар Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг тодорхойлж өгнө. Ажлын даалгаварт дор хаяж дараах зүйлсийг тусгах хэрэгтэй бөгөөд зөвхөн үүгээр ч хязгаарлагдахгүй:

- Одоогийн/ирээдүйд гарах хаягдал усны урсгалыг судлан, хэмжээ болон бохирдлын ачааллыг бууруулах талаар зөвлөх
- Гарах хаягдал усны чанар нь MNS6561:2024 шаардлага болон бусад шаардлагуудыг хангах, үүндээ баталгаа шаардах
- Зураг төсөл боловсруулах, худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн шаардлагыг тодорхойлох, урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, туршилт тохируулга хийх болон ашиглах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа болон бусад шаардлагууд
- Боломжит зай талбай, цаг хугацаа, төсөв болон бусад нөхцөл
- Ажилчдыг сургалтанд хамруулах
- Ашиглалтын үеийн засвар үйлчилгээ
- Хууль, эрхзүйн шаардлагуудыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх (жишээ нь, БХТ-өөр магадлал хийлгэх бичиг баримтуудыг бэлтгэх, тоног төхөөрөмж импортоор оруулж ирэхэд гаалийн татварын хөнгөлөлт эдлэх, ХСҮХАТАҮЗХ-оос тусгай зөвшөөрөл авах гэх мэт)

4. Гарах хаягдал усны урьдчилсан тооцоолол

Гүйцэтгэгчтэй ярилцаж, газар дээр нь нөхцөл байдлыг танилцуулсны дараа үйлдвэр, аж ахуйн нэгж болон Гүйцэтгэгч гэрээгээ эцэслэн байгуулж, ажлыг эхлүүлнэ. Гүйцэтгэгчийн зүгээс нэмэлт мэдээлэл буюу үйлдвэрийн схем зураг, үйлдвэрлэлийн процесс, ашигладаг түүхий эдийн төрөл болон хэмжээ, өдөр тутмын болон улирлын усны хэрэглээ, хаягдал усны чанар болон урсацын хэмжээ, мөн ус хангамжийн болон ариутгах татуургын системтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллүүдийг шаардаж болох бөгөөд эдгээр мэдээллээр хангах нь үйлдвэр, аж ахуйн нэгжийн үүрэг юм.

Хаягдал усны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд үйлдвэр, аж ахуйн нэгж болон Гүйцэтгэгч хамтран ирээдүйд гарах хаягдал усны тооцоолол болон дүн шинжилгээг эхлээд хийх ёстой. Ингэснээр хаягдал усны аль урсгалыг урьдчилан цэвэрлэх шаардлагатайг тодорхойлох, мөн хаягдал усны хэмжээ болон бохирдлыг бууруулахын тулд авч болох арга хэмжээний талаар судалж мэдэх юм. Дараах зурагт хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэлийн процессыг жишээ болгон харууллаа. Хаягдал усыг хаана үүсч буйгаас хамааран дор үзүүлснээр ангилж болох юм.



Зураг 5 Төрөл бүрийн хаягдал ус бий болох явц

Энэ тохиолдолд хаягдал ус тус бүрийн ерөнхий шинж чанарыг доорх хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3 Өөр процессуудаас бий болох хаягдал усны төрлүүд

Хаягдал усны төрөл	Хаягдал усны шинж чанар
Түүхий эд угаасан хаягдал ус	Энэ төрлийн хаягдал ус түүхий эдийг цэвэрлэх явцад бий болно. 2 төрлийн бохирдуулах бодис агуулагдах бөгөөд нэг нь түүхий эдээс гарсан бохирдол, нөгөө нь цэвэрлэхэд ашигласан угаах бодис.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Боловсруулалтаас гарах хаягдал ус	Хаягдал ус нь үндсэн боловсруулалтын шатнаас бий болно. Агуулагдах бохирдуулагч нь түүхий эдээс гарах бохирдол, боловсруулалтанд ашиглах хоёрдогч материал эсвэл химийн бодис байдаг. Энэ шатанд гарах хаягдал усны хэмжээ бага байж болох ч бохирдлын агууламж нь их байдаг.
Боловсруулалтын дараах процессоос гарах хаягдал ус	Боловсруулалтын дараа буюу угаах гэх мэт эцсийн шат дамжлагын үед мөн хаягдал ус гарна. Бүтээгдэхүүний бохирдол хаягдал усанд орох бөгөөд энэ шатны хаягдал усны бохирдол болон хэмжээ нь харьцангуй бага.
Тоног төхөөрөмж угаасан хаягдал ус	Ашиглаж буй машин, тоног төхөөрөмжийг угаах үед, мөн ажлын талбарыг цэвэрлэхэд ихээхэн хэмжээний хаягдал ус бий болдог. Боловсруулалтын эцсийн шатанд хаягдал ус их бий болох бөгөөд бохирдлын агууламж ч өндөр байх талтай.
Ахуйн хаягдал ус	Ариун цэврийн өрөө, цайны газар, угаалгын газраас гарах хаягдал ус энэ төрөлд багтана. Ариун цэврийн өрөөний бохир усыг ихэвчлэн септик танканд цэвэрлэдэг.

Хаягдал усны хэмжээ болон чанарыг маш сайн тогтоох хэрэгтэй. Хэрэв урсгал бүрийн Хэрэв боломжтой бол хаягдал усны урсгал тус бүрийн гол үзүүлэлтүүд буюу pH, умбуур бодис, БХХ болон ХХХ гэх мэтийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлох ёстой. Хэрэв үйлдвэр, аж ахуйн нэгж шинэ боловсруулах шугам нэмэх болон өөр бусад томоохон өөрчлөлт төлөвлөж байгаа тохиолдолд бодит хаягдал ус байхгүй бол Гүйцэтгэгчтэй хамтран тус төлөвлөгөөндөө үндэслэн, ижил төстэй үйл ажиллагаатай үйлдвэрийн жишгээр гарах хаягдал усны хэмжээ болон чанарыг тооцоолно.

5. Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахгүйгээр хаягдал усны хэмжээ болон бохирдлыг бууруулах арга хэмжээ

Гүйцэтгэгч ба үйлдвэр, аж ахуйн нэгж нь хаягдал усны хэмжээ болон бохирдлын агууламжийг хэрхэн бууруулах талаар авч үзэн, судлах шаардлагатай. Ингэснээр байгууламжид шаардагдах зай талбайн хэмжээг бууруулаад зогсохгүй суурилуулалтын зардлаа ч танаж болдог. Хүснэгт 4-т авч болох арга хэмжээнүүдийг дурдлаа.

Хүснэгт 4 Үйлдвэрлэлийн процессын явцад авах арга хэмжээ

Үйлдвэрлэлийн процесс	Процессын явцад авах арга хэмжээ
Цэвэрлэх болон урьдчилан цэвэрлэх процесс	– Тодорхой түвшний урьдчилсан боловсруулалт хийсэн түүхий эдийг ашиглах (жишээлбэл, угаасан мах) – Усгүйгээр цэвэрлэх аргад шилжих – Усны хэрэглээг бууруулах (ус хэмнэх) – Хоёрдогч орцыг хэт их хэмжээгээр хэрэглэж байгаа бол багасгахыг зорих.
Үндсэн процесс/Боловсруулалт	– Усанд буцалгах процессийг уурын процессоор солих – Боловсруулах явцад ашигласан машин, савнаас аль болох их хэмжээний хаягдал цуглуулах.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Боловсруулалтын дараах процесс	– Бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулахын тулд олон удаа угаалга хийсэн бол угаалтын давтамжийг хянах хэрэгтэй
Машин, тоног төхөөрөмжийг цэвэрлэх ус	– Машин, сав зэргийг нэг усаар угааж болохгүй бөгөөд эхлээд хатуу биет, бодисыг зайлуулж угаана. – Ажлын байран дах машин, сав, шалыг тогтоосон хэмжээнээс илүү олон удаа угааж байгаа бол давтамжийг сайтар нягтлах хэрэгтэй. – Хатуу биет, бохирдол, тос зэргийн өндөр агууламжтай бохир усыг зайлж болохгүй, тэдгээрийг тусад нь цуглуулж, устгалд оруулна.
Ерөнхий зүйл	– Хуучин байгууламжийг шинэчлэхтэй уялдуулан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сайжруулах – Үйл явцдаа түүхий эд, химийн бодисыг дахин боловсруулах – Цэвэрлэсэн бохир усыг дахин ашиглах

6. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх

Үйлдвэрлэлийн процессын явцад авч болох арга хэмжээг судалж үзээд, цэвэрлэх хаягдал усны хэмжээ болон чанарыг тодорхойлсны дараа үйлдвэр, аж ахуйн нэгж нь Гүйцэтгэгчтэй хамтран урьдчилан цэвэрлэх байгууламжийг Барилгын тухай хуулийн дагуу төлөвлөх ажлыг эхлүүлнэ.

ММСС-ийн боловсруулсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага” (2024)-д цэвэрлэх байгууламжийн технологийн талаар тусгасан тул энд дурдаагүй. Ерөнхийдөө ихэнх үйлдвэрүүд механик цэвэрлэгээ буюу сараалж суурилуулж том хаягдлыг зайлуулна. Мөн физик химийн цэвэрлэгээ буюу коагуляци/тунгаагуур эсвэл ууссан агаарын флотаци (ДАФ) технологитой урьдчилан цэвэрлэх байгууламжид хаягдал уснаас умбуур бохирдуулагчийг зайлуулна. Бохирдол ихтэй хаягдал ус гаргадаг том үйлдвэрүүдэд биологийн цэвэрлэгээ шаардлагатай бөгөөд энэ технологи нь органик бохирдуулагч болон азотот нэгдлүүд ($\text{NH}_4\text{-N}$, NOx-N , org-N)-ийг бууруулдаг. Арьс шир боловсруулах үйлдвэрийн хүхэрт устөрөгч (H_2S)-ийн ялгарал гэх мэт онцгой нөхцлөөс шалтгаалан тусгай технологиуд шаардлагатай байж болно.

Цэвэрлэгээний технологи сонгохдоо дараа зүйлсийг авч үзэх хэрэгтэй.

■ Хууль, эрхзүйн шаардлагуудыг үр дүнтэй хангах

Цэвэрлэсэн хаягдал усны чанар MNS6561:2024 стандартын шаардлагыг хангах ёстой бөгөөд ингэснээр хөрөнгө, оруулалт болон ашиглалтын зардлыг хамгийн бага байлгаж, урьдчилан цэвэрлэх байгууламжийн шаардагдах зай талбайг бууруулах боломж бүрдэнэ.

Умбуур бохирдуулагчийг бууруулахад коагуляци/тунгаагуур эсвэл ДАФ гэх мэт физик химийн цэвэрлэгээний технологи нь үр дүнтэй гэдгийг дурдах нь зүйтэй. Гэсэн хэдий ч дээрх аргууд нь ууссан бохирдуулагчийг бууруулахад үр дүнгүй тул зарим нэг салбарын

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

хувьд бэрхшээлтэй байдаг. Стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг хангасан урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах нь техникийн хувьд хүндрэлтэй байгаа нь тогтоогдсон тохиолдолд эрх бүхий байгууллага нь тухайн үйлдвэр, аж ахуйн нэгжээс тухайн асуудлыг тодорхойлсон баримт бичгийг ирүүлэхийг хүсч, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцах ёстой.

■ Аюулгүй байдал ба онцгой байдал

Аюулгүй байдлын тухайд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай:

- Аюулгүйн тэмдгүүд байрлуулах
- Цэвэрлэгээний явцад хортой хий ялгарахыг хянах
- Хүчил, шүлт, шатамхай болон идэмхий бодисуудыг аюулгүй хадгалах
- Байгууламж руу ажилтан унахаас сэргийлэх
- Үнэр болон дуу чимээний бохирдлыг бууруулах

Мөн тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл, гал түймэр, дэлбэрэлт болон бусад урьдчилан тооцоолоогүй нөхцөлд ашиглах ослын үеийн зааварчилгааг боловсруулах шаардлагатай.

■ Үйлдвэрлэлийн янз бүрийн нөхцөлд ажиллах нь

Хаягдал усны чанар/хэмжээ нь үйлдвэрлэлийн процессоос шалтгаалан ихээхэн хэлбэлздэг бөгөөд үйлдвэрийн оператор химийн бодисын тун, цэвэрлэгээний давтамжийг тохируулах хэрэгтэй болдог. Монголд олон үйлдвэрт шаардлагатай мэргэшсэн инженерүүд дутмаг байдаг тул эдгээр тохируулгыг хийхэд бэрхшээлтэй тулгардаг. Тиймээс үйлдвэр, аж ахуйн нэгж нь Гүйцэтгэгчээс хаягдал усны төрөл бүрийн нөхцлийг тооцон урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөхийг шаардах нь зүйтэй. Үүнд тогтворжуулалтын сангийн тохиромжтой хэмжээг тодорхойлох, рН хянагч болон автомат дозлогч суурилуулах гэх зэрэг багтана. Түүнчлэн Гүйцэтгэгч нь дадлага, сургалт явуулж, үйл ажиллагааны дэлгэрэнгүй гарын авлагаар хангах ёстой.

■ Хяналт болон бүртгэл хөтлөх

Тоног төхөөрөмжийг үр дүнтэй ажиллуулж, гарсан эвдрэл доголдлыг засахад байнгын хяналт болон гол үзүүлэлтүүдийн талаар бүртгэл хөтлөдөг байх нь их чухал юм. Үүнд хаягдал усны хэмжээ, чанар, химийн бодисын тун, рН түвшин болон бусад үзүүлэлтүүд орно.

■ Бичиг баримт

Үйлдвэр, аж ахуйн нэгж нь Гүйцэтгэгчтэй хамтран БХТ-өөр зураг төслөө магадлуулах, барилгын ажлын зөвшөөрөл авах болон улсын комиссоор оруулах зэрэгт шаардлагатай бичиг баримтуудыг бэлтгэх ёстой. Холбогдох байгууллагуудын ажилтнууд дээрх процедурын талаар зөвлөгөө өгдөг.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

Хүснэгт 5-д урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төслийг БХТ-өөр магадлуулахад шаардагдах бичиг баримтуудын жагсаалтыг харууллаа. Эдгээр бичиг баримт нь үйлдвэр, аж ахуйн нэгж болон төрийн захиргааны байгууллагуудын хувьд чухал хэрэгцээтэй мэдээллийг агуулдаг. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг төслийн АХ 3-ийн хүрээнд боловсруулж буй УЦБ-ийн суурилуулалтыг хянах процедуртай холбоотой гарын авлагад тусгасан.

Хүснэгт 5 Урьдчилан цэвэрлэх байгууламжтай холбоотой санал болгож буй баримт бичиг

Бичиг баримт	Баримт бичгийг бүрдүүлэх шалтгаан
Суурилуулах тухай мэдэгдэл	Эрх бүхий байгууллагад үйлдвэрийн нэр, байршил болон суурилуулах зорилгын тухай мэдээлэл хүргэх
Гэрээ	Зураг төсөл боловсруулах, суурилуулах, ашиглахад хүлээх хариуцлагыг тодорхойлох, үл нийцлийг тодорхойлох
Процессын урсгалын схем болон байгууламжийн жагсаалт	Уг байгууламж нь шаардлагыг хангахын тулд хэрхэн зохион байгуулагдсаныг харуулах процессын урсгалын схем болон бусад баримт бичгийг танилцуулах
Байгууламжийн хүчин чадлын тооцоолол	Шаардлага хангахуйц хангалттай хүчин чадалтайг харуулах
Туршилт болон засвар үйлчилгээний төлөвлөгөө	Туршилтын, засвар үйлчилгээний болон онцгой байдлын төлөвлөлтийн талаар мэдээллэх
Суурилуулалт дууссан тухай мэдэгдэл	Зураг төслийн дагуу угсралт, суурилуулалтын ажил дууссан тухай мэдээлэл хүргэх
Туршилтын тайлан	Суурилуулсан байгууламжийн үйл ажиллагааг шалгах

7. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах

Гүйцэтгэгч нь урьдчилан цэвэрлэх байгууламжийг зураг төслийн дагуу суурилуулна. Энэ шатанд анхаарах зүйлсийг дор жагсаалаа:

■ Зөв материал ашиглах

Гүйцэтгэгчийн сонгож буй материал нь үүсч болох эрсдлүүдэд тэсвэртэй эсэхийг магадлаарай. Хаягдал усанд хүчил, шүлт болон хүхэрт устөрөгч гэх мэт идэмхий бодис агуулагддаг. Эдгээрт тэсвэргүй материал ашигласан тохиолдолд байгууламжийн гадаргуу хурдан элэгдэж муудах болно.

■ Туршилт

Энэ үе шатанд хаа нэгтээ ус алдагдал байгаа эсэхийг шалгахын тулд цэвэр ус болон хаягдал ус аль алийг нь туршиж үзэж байгууламжийн найдвартай үйл ажиллагааг магадлана. Үйл ажиллагааны гүйцэтгэл нь гэрээнд Гүйцэтгэгчийн тусгасан дагуу байгаа эсэхийг нягтлаарай.

■ Сургалт, дадлага

Үйлдвэрийн ажилтнууд байгууламжаа хэрхэн ашиглах, засвар үйлчилгээ яаж хийх талаар дадлага, сургалтанд хамрагдах нь чухал. Энэхүү сургалтаар ашиглалтын нөхцөл, системийн доголдлыг хэрхэн оношлох, урсац болон бохир усны чанарын ялгаатай нөхцөлд тоног төхөөрөмж, химийн бодисын тунг тохируулах, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй орчныг хангах, онцгой байдлын үед хэрхэн хариу арга хэмжээ авах талаарх мэдлэгийг олж авах ёстой. Дадлагажуулсан ажилтнууд ажлаас гарах эрсдэл бий тул бүх процедурыг гарын авлагад тусгаж багтаасан эсэхийг сайтар нягтлаарай.

8. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглах

Доорх хүснэгтэд хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээ, менежментэд анхаарах ёстой ерөнхий зүйлсийг жагсаав.

Хүснэгт 6 Урьдчилан цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээ, менежментэд анхаарах ёстой ерөнхий зүйлс

Зүйл	Агуулга
Байгууламжийн ашиглалт болон ашиглалтын байдал	Байгууламж гарын авлагад заасны дагуу ажиллаж байгааг магадлаарай. Орж ирж буй усны чанар, байгууламж дах усны чанар болон цэвэрлэгдээд гарч байгаа усны чанар, мөн ууссан агаар, pH, усны температур гэх мэтийг шалгаж, тэмдэглээрэй.
Шугам хоолой, тэдгээрийн холболтын байдал, гадны биет наалдсан эсэх	Шугам хоолой, сараалж зэрэгт хог байгаа эсэхийг шалгана. Шаардлагатай бол цэвэрлэнэ.
Механик болон цахилгаан тоног төхөөрөмж	Хэрэглээний материалыг тогтмол сольж, нөхөж байх. Ямар нэгэн хэвийн бус байдал илэрвэл хэрэглээний материалыг нөхөх. Онцгой байдалд ашиглах гарын авлагыг бэлтгэх
Хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг авч үзэх	Үнэр, дуу чимээ, доргион, чичиргээ зэргийг шалгаж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авна.

БҮЛЭГ 5

Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо

Урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, БҮЛЭГ 3-т заасан шаардлагыг дагаж мөрдөх нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үүрэг боловч санхүүгийн эх үүсвэр, зай талбай, мэргэжлийн ур чадварын боломж хязгаарлагдмал олон үйлдвэрүүд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Энэ тохиолдолд стандарт, хязгаарлалт, тушаал, шийтгэл гэх мэт уламжлалт менежмент зохицуулалтын арга нь үргэлж үр дүнтэй, оновчтой байдаггүй. Тиймээс энэ хэсэгт урьдчилан цэвэрлэх байгууламжийг бий болгоход чиглэсэн төрөл бүрийн дэмжлэгийн тогтолцоог танилцуулж байна.

1. Санхүүгийн дэмжлэгийн тогтолцоо

Холбогдох хууль тогтоомжоос гадна санхүүгийн хөшүүрэг болон урамшууллаар дамжуулан эдийн засгийн оновчтой байдал бий болгох, тогтолцоог бүрдүүлэх зах зээлийн зарчимд тулгуурласан эдийн засгийн арга зам бий болгох нь чухал байдаг. Жишээлбэл, Монголд ус бохирдуулсны төлбөр нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд бохирдлоо бууруулахад чиглэсэн эдийн засгийн хөшүүрэг болж байна. Нөгөөтэйгүүр, урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахыг дэмжсэн санхүүгийн урамшууллуудын талаар дор дурдлаа.

■ Ногоон санхүүжилт

Ногоон зээл болон бусад зээл нь компаниуд болон хотын захиргаанаас Япон болон гадаад улсуудад байгаль орчныг хамгаалах, сайжруулах зорилго бүхий төслийг санхүүжүүлэхэд ашигладаг зээлийн төрөл юм. Энэ төрлийн зээлийг ашигласнаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүд урьдчилан цэвэрлэх байгууламжийг барьж байгуулаад зогсохгүй байгаль орчныг хамгаалах санаачилгыг сурталчилж, ESG санхүүжилтийг илүүд үздэг санхүүгийн байгууллагуудтай шинэ харилцаа тогтоох замаар санхүүжилтийн эх үүсвэрээ бэхжүүлэх боломжтой. Олон тооны хандивлагчид нь Монгол улсад ногоон зээлийг хөгжүүлж байна. Тухайлбал, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТОСК)-оос Монгол Улсад олгох ногоон зээлийн жагсаалтыг салбараар нь гаргажээ.

Холбоос <https://www.toc.mn/en>

■ Японы хоёр үе шаттай зээл

Японы 2 үе шаттай зээл нь жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд зориулагдсан бөгөөд байгаль орчны менежментийн асуудалд ач холбогдол өгдөг. Шаардлага хангасан үйлдвэр,

аж ахуйн нэгжүүд хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтээ шийдэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг арилжааны банкуудаас авч болно.

■ Урьдчилан цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх

Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор хүнсний бүтээгдэхүүн, газар тариалангийн үйлдвэрлэлийн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд, үйлдвэрт шинээр суурилуулах импортын тоног төхөөрөмж зэргийг гаалийн албан татвараас чөлөөлөгдөнө. Дараах жагсаалтад харуулсан хаягдал ус цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх болно.

Хүснэгт 7 Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх УЦБ-ийн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	БТКУС-ийн код	Тоног төхөөрөмжийн нэр
1.	3926.90.00	Агааржуулалтын диффузер
2.	8413.19.00	Химийн бодис шахах насос (Дозлогч)
3.	8413.50.00	Лагийн насос
4.	8413.60.00	Лагийн шураган насос
5.	8413.70.00	Концентрацийг холих насос (Nitrification reflux pump)
6.	8413.70.00	Бохир усны насос (өргөх насос)
7.	8413.81.00	Дамжуулах босоо хоолойн насос
8.	8414.10.00	Вентури насос (Агааржуулагч)
9.	8414.59.00	Салхилуур, үндсэн үлээгүүр
10.	8414.80.00	Цэвэрлэх байгууламжийн агаар үлээгч, диффузер
11.	8414 80.00	Хий сорох, зайлуулах цамхаг
12.	8421.21.00	Мембран биореактор
13.	8421.29.00	Лаг усгүйжүүлэгч, лаг өтгөрүүлэгч, механик сараалж
14.	8421.29.00	Бохир усны нарийн бохирдлыг шүүх төхөөрөмж, ультра, микро шүүгч, бүдүүн ширхэгт шүүх төхөөрөмж; бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж
15.	8421.29.00	Усан доторх умбуур бодисыг тунгаах зориулалттай нүхтэй налуу хавтан
16.	8428.20.00	Цэвэрлэх байгууламжийн хийн шахуургат элеватор
17.	8428.39.00	Шурган дамжуулагч
18.	8479.82.00	Цэвэрлэх байгууламжийн дүүжин холигч
19.	8479.82.00	Усан сангийн босоо холигч, хэвтээ холигч
20.	8479.89.00	Төвийн хөтөч шавар хусах төхөөрөмж
21.	8479.89.00	Лаг шахах пресс
22.	8479.89.00	Бохир ус цэвэршүүлэх химийн бодис нэмэх автомат төхөөрөмж
23.	8479.89.00	Усан сангийн дээд түвшинд хөвж буй зүйлсийг хусах хөдөлгөөнт төхөөрөмж; хөвж байгаа бохирдлыг цэвэрлэх төхөөрөмж (Гинжит хусуур)
24.	8481.40.00	Цэвэр усны автомат хавхлага
25.	8481.80.00	Ус зайлуулах автомат хавхлага
26.	9026.10.00	Шингэний урсгал хэмжигч, бохир усны урсгал хэмжигч, уусмалын түвшин хэмжигч

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

27.	9026.10.00	Шингэний урсгалын хурдыг хэт авиагаар хэмжигч (Parshall хэмжих сав)
28.	9026.80.00	Лагийн түвшинг тодорхойлох багаж (Лагийн интерфейсийн багаж)
29.	9027.89.00	Усны үлдэгдэл хлор илрүүлэгч
30.	9027.89.00	"Химийн хүчилтөрөгчийн шаардлага" параметрийг тодорхойлох багаж
31.	9027.89.00	Хүчиллэг, шүлтлэгийг хэмжих багаж (pH-метр)
32.	9027.89.00	Хөвөгч хатуу хэсгүүдийг илрүүлэх төхөөрөмж (SS илрүүлэгч)
33.	9027.89.00	Азотын нийт хэмжээг тодорхойлох багаж

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоол

■ Ногоон сертификат

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас байгальд ээлтэй, байгалийн нөөцийн хэмнэлттэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, оновчтой урамшуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолын хавсралтад "Ногоон гэрчилгээ" "Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн байгууллага"-аар батлагдсан аж ахуйн нэгж, байгууллагад "Байгаль орчинд ээлтэй арга, технологи ашигласан байгууллага"-аар батлагдсан аж ахуйн нэгж, байгууллагад "ногоон гэрчилгээ" олгож, бүтээгдэхүүн үйлчилгээ байгаль орчинд ээлтэй арга, технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд "Эко тэмдэг" зэргийг тус тус олгож байна. "Ногоон гэрчилгээ" авсан аж ахуйн нэгж, байгууллагууд дараах дэмжлэгт хамрагдах боломжтой. Үүнд:

- Байгальд ээлтэй дэвшилтэт арга, технологийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, дотоод, гадаадын үзэсгэлэнд оролцох;
- Байгаль орчны үндэсний болон олон улсын шагналд нэр дэвшүүлэх;
- Ногоон зээлийн сан болон бусад дотоод, гадаадын хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтад хамрагдах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу давуу эрхтэйгээр оролцох;
- Ижил төрлийн дэвшилтэт технологи бүхий олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад зуучлах;
- Үндэсний стандарт боловсруулах, олон улсын стандартыг үндэсний стандарт болгоход мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;

2. Мэдээллээр хангаж, дэмжих тогтолцоо

Урьдчилан цэвэрлэх байгууламжийг бий болгоход оролцож буй холбогдох эрх бүхий байгууллага болон бусад ажилтнуудын техникийн мэдээлэл, мэдээллийн хүртээмжийг сайжруулснаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүд өөрийн нөхцөл шаардлагад тохирсон урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахад дэмжлэг болох юм.

■ **Урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл болон барилга угсралтын ажил гүйцэтгэх компаниуд**

ХСУХАТАҮЗХ-ны вэб хуудсанд тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагуудын тухай мэдээлэл, мөн урьдчилан цэвэрлэх байгууламж, бохир ус тээвэрлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын жагсаалт байдаг.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”

Холбоос: http://api.wsrc.gov.mn/media/editor/TZNSH-shine_togtool.pdf

Бохир ус цэвэрлэх байгууламжийн болон ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд

Холбоос: http://api.wsrc.gov.mn/media/editor/Tseverleh_baiguulamj_turshilt_tohruulga.pdf

Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд

Холбоос: http://api.wsrc.gov.mn/media/editor/Bohir_mashin.pdf

Жагсаалтад дурдагдсан байгууллагуудын дийлэнх нь үйлдвэрийн хаягдал ус биш ахуйн бохир усны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэх технологи нь ахуйн бохир усны технологиос ихээхэн ялгаатай бөгөөд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд үйлдвэрийн хаягдал усны чиглэлд тодорхой туршлагатай компанийг УЦБ суурилуулсан үйлдвэр эсвэл интернет орчны мэдээллээс хайж олж болох юм.

■ **Химийн бодис импортоор оруулж ирэх тусгай зөвшөөрөлтэй компаниудын жагсаалт**

БОУАӨЯ-аас химийн хортой болон аюултай бодисыг импортоор оруулж ирэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг доорх холбоосоор орж харна уу.

Холбоос: https://mecc.gov.mn/storage/library_items/April2023/krUdDqpswkgGeSCWBZxi.pdf

■ **Холбогдох гарын авлагууд**

Төрийн захиргааны байгууллагууд болон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахыг дэмжих, мөн байгуулахдаа дараах гарын авлагуудыг ашиглах боломжтой:

Хүснэгт 8 Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахыг дэмжих зорилгоор боловсруулсан гарын авлагууд

Боловсруулсан (Хэвлэсэн он)	Бичиг баримтын нэр	Агуулга
ЖАИКА (2025)	Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийн лавлагаа гарын авлага (Техникийн лавлахын хамт)	Энэхүү гарын авлагыг үйлдвэрийн хаягдал усны зөв зохистой менежмент бий болгох, хууль тогтоомжийг дагаж мөрдөх чадавхыг бэхжүүлэх, засаг захиргааны тогтолцоо, ойлголтыг нэмэгдүүлэх, усны чанарын менежмент, зааварчилгаа, зохицуулалтын талаарх мэдлэг олгох, үр дүнтэй захиргааны менежментийн талаарх мэдээллийг тайлбарлах замаар төрийн захиргааны зүгээс үр дүнтэй менежмент хийх зорилгоор бэлтгэсэн болно.
ММСС (2024)	Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага	Энэ гарын авлага нь үйлдвэрүүд болон бусад оролцогч талуудад үйлдвэрийн бохирдлын менежментийг сайжруулахад гол зааварчилгааны бичиг баримт болох юм. Тус гарын авлагад үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг төлөвлөх, сонгох болон ашиглахад MNS 6561:2024 стандарттай хэрхэн уялдуулах талаарх цогц мэдээллийг багтаасан байна.
ЖАИКА (2025)	Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийн суурилуулалтыг хянах процедурын гарын авлага	Энэ процедурын гарын авлага нь урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахаар төлөвлөж буй үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, мөн урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төслөө магадлуулах гэж буй үйлдвэрүүдэд зориулагдсан бөгөөд урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахтай холбоотой процессын дарааллыг тайлбарласан. Мөн хаягдал ус цэвэрлэх түвшинг хэрхэн тодорхойлох болон зураг төсөлд магадлал хийлгэхэд анхаарах асуудлууд гэх мэтийг багтаасан.
ЖАИКА (2025)	Үйлдвэрийн хаягдал усны хяналт шалгалтын гарын авлага	Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хаягдал усаа нийлүүлдэг үйлдвэрүүдэд хяналт шалгалт хэрхэн явуулахыг тайлбарласан бичиг баримт бөгөөд төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт хийдэг ажилтнууд, хяналтын байцаагч нарт зориулан боловсруулсан.
ЖАИКА (2025)	Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг	Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах болон ашиглахтай холбоотой заавар, зөвлөгөөг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд өгдөг төрийн захиргааны ажилтнуудад

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага

	чиглүүлэх төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага	дэмжлэг болгон боловсруулсан гарын авлага. Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд зориулсан УЦБ байгуулах сонголтууд, хууль эрхзүйн шаардлага, техникийн асуудлууд болон дэмжлэгийн тогтолцоог тайлбарласан.
--	---	---

Мөн олон улсад ашигладаг гарын авлагуудыг доор жагсаалаа:

Хүснэгт 9 Үйлдвэрийн хаягдал усны менежменттэй холбоотой олон улсын гарын авлагууд

Боловсруулсан (Он)	Нэр	Агуулга
IFC (2007)	Мах боловсруулах үйлдвэрлэлийн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын заавар	Махны үйлдвэрлэлийн техникийн жишиг бичиг баримт. 1-р бүлэгт мах боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлуудыг тоймлон, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зөвлөмжийг тусгасан болно. 2-р бүлэгт гүйцэтгэлийн үзүүлэлт ба хяналт-шинжилгээг тайлбарласан.
IFC (2007)	Арьс ширний болон арьс өнгөлгөөний үйлдвэрлэлийн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын заавар	Арьс шир боловсруулах техникийн лавлагааны баримт бичиг. 1-р бүлэгт салбарын нөлөөлөл ба менежментийг тайлбарласан. 2-р бүлэгт гүйцэтгэлийн үзүүлэлт ба хяналтыг тайлбарласан болно.
USEPA (2011)	Урьдчилан цэвэрлэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга	Хөтөлбөрийг бүрдүүлэх үндсэн ойлголтуудыг тайлбарлаж, хөтөлбөрийн өнөөгийн байдал, хөтөлбөрийн удирдамжийн талаар авч үзэн, урьдчилан цэвэрлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг дурдсан бичиг баримт.
USEPA (1986)	Арьс ширний болон өнгөлгөөний үйлдвэрлэлийн урьдчилан цэвэрлэгээний жишиг гарын авлага	Арьс шир боловсруулах үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх арга техник, бохир усны хууль тогтоомжийг тайлбарласан гарын авлага.
EU (2020)	Хамгийн сайн боломжит технологи (BAT) Хүнс, ундаа, сүүний үйлдвэрүүдийн лавлах баримт бичиг	Хүнс, ундаа, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ялангуяа хэрэглээний технологи, ялгарал, хэрэглээ, шинэ технологийн талаарх лавлагаа мэдээлэл

3. Төрийн захиргааны байгууллагуудтай холбогдох

Холбогдох төрийн захиргааны байгууллагуудын жагсаалт:

Хүснэгт 10 Төрийн захиргааны байгууллагуудын жагсаалт

Байгууллага	Алба, хэлтэс	Хаяг
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (УБЗАА)	Хотын инженерийн дэд бүтцийн газар	Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Наадамчдын зам, Хангарди ордон Б блок
Барилгын хөгжлийн төв (БХТ)	Орон сууц нийтийн аж ахуйн хэлтэс	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баруун 4 зам, өөрийн байр
Усны газар (УГ)	Усны хяналт шинжилгээний хэлтэс	Баянгол дүүрэг, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Усны газрын байр
Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо (ХСУХАТАҮЗХ)	Тусгай зөвшөөрөл хэрэглэгчийн газар Үнэ тариф, судалгааны газар	Сүхбаатар дүүрэг, 8 –р хороо, Их тойруу 81/1, “Монгол Ньюс” тауэрын 6 давхар, 601 тоот.
Ус сувгийн удирдах газар (УСУГ)	Бохирдол бууруулах нэгж	Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Токиогийн гудамж-5, Ус сувгийн удирдах газар
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)	Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр Г корпус.
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Дархан-Уул аймаг 45059, Дархан сум, 14 дүгээр баг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр

Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламж: Монгол Улсын хууль, дүрэм журмын судалгааны үр дүн

“Судалгааны тайлан: төсөл_1, Огноо: 2024 оны 8-р сарын 31
Бэлтгэсэн: Доктор / Равсал.Оюун, ЖЭМР ХХК, Монгол улс”

Агуулга

ТОВЧ ТАЙЛБАР	5
1. ТАНИЛЦУУЛГА	10
2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА ҮР ДҮН.....	10
3. АЖЛЫН ХҮРЭЭ	10
4. АРГА ЗҮЙ	11
5. ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ СУУРИЛУУЛАХ, АЖИЛЛУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЖУРАМ.....	12
5.1. Хаягдал ус цэвэрлэх / урьдчилан цэвэрлэх байгууламжууд	12
5.2. Зөвшөөрөл ба лицензийн олголт	13
5.3. Байгаль орчны хариуцлага.....	14
5.4. Эрүүл мэнд болон Аюулгүй байдал	16
5.5. Бохирдолыг урьдчилан сэргийлэх ба хяналт тавих	16
5.6. Татвар ба хураамжийн төлбөр	18
5.7. Хэрэгжилт ба торгууль.....	20
5.8. Хуулийн судалгааны тойм.....	22
6. ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС УРЬДЧИЛСАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ СУУРИЛУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛЫН ДИАГРАММ.....	26
6.1. Хаягдал ус цэвэрлэх байгууламжийн үйл явц ба шаардлагууд	26
6.2. Барилга/барилгын зураг төсөл боловсруулах, баталгаажуулах, болон зөвшөөрөл авах.....	27
6.3. Дахин ашиглах зориулалтаар цэвэрлэсэн усны шаардлагууд	29
6.4. Бохир ус цэвэрлэхэд Засгийн газрын үүрэг	30
6.5. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам	31
6.6. Бохир усны хураамж ба төлбөрийн журам	33
6.6.1. Усны бохирдлын төлбөрийг бүртгэх болон гэрээ байгуулах процесс	34
6.6.2. Ус ашиглалтын зөвшөөрөл, гэрээний талаарх үйл явц ба оролцогч талууд.....	37
6.6.3. Бохир усны чанарын хяналт ба ус бохирдуулсны төлбөрийн төлөлтийн мониторинг.....	38
6.6.4. Усны бохирдлын төлбөр болон хэтэрсэн агууламжид ноогдох нөхөн төлбөрийг тооцох	38
7. ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСНЫ УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ СУУРИЛУУЛАХ ЕРӨНХИЙ ЖУРМЫН ЗУРАГЛАЛ.....	42
8. УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	44
9. ҮЙЛ ЯВЦ БҮРИЙН ХУУЛИЙН ШААРДЛАГЫГ ХОЛБОГДОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЛБАН ХААГЧДААС ЯРИЛЦЛАГА АВАХ ЗАМААР БАТАЛГААЖУУЛСАН БАЙДАЛ.....	47
10. УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ БАРИХ, АШИГЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗАМЫН ЗУРАГ БОЛОН ҮЙЛ ЯВЦ БҮРИЙН НАРИЙВЧИЛСАН СХЕМ	62
11. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХУУДАСТ ӨГСӨН САНАЛ.....	87

12. УСНЫ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН.....	88
13. ДҮГНЭЛТ.....	100
14. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	100
A. Хууль, журам.....	100
B. МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТУУД.....	100
C. ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРҮҮД:	100
D. САЙД НАРЫН ТУШААЛУУД.....	101
15. ХАВСРАЛТ	

Зураг болон хүснэгтийн жагсаалт

Үр дүнгийн хураангуй хүснэгт 1: Хууль эрх зүйн шаардлагын судалгаа.....	6
Үр дүнгийн хураангуй хүснэгт 2: Шаардлага, үйл явцын диаграмм ба процессууд	8
Зураг 1. Тайлангийн зургуудад ашигласан дүрсүүдийн тайлбар.....	12
Хүснэгт 1. Хаягдал ус урьдчилсан цэвэрлэх байгууламжийн суурилуулалт болон үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм журам	22
Зураг 2. Цэвэрлэх байгууламжид тавигдах шаардлагууд	26
Зураг 3. Хангагч, хэрэглэгчийн харилцаа, гэрээ, эрх үүрэг	27
Зураг 4. Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, хянах, баталгаажуулах үе шат	28
Зураг 5. Барилгын зураг төслийг хянах болон батлах үйл явц	28
Зураг 6. Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах инженерийн судалгааны ажлын үйл явц	29
Зураг 7. Цэвэрлэсэн усыг дахин ашиглахад тавигдах техникийн шаардлага	30
Зураг 8. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх: Бодлого боловсруулах	31
Зураг 9. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх: Ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хороог байгуулах	31
Зураг 10. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний төрөл	32
Зураг 11. Байгаль орчны ерөнхий үнэлгээ	33
Зураг 12. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үр дүн	33
Зураг 13. Ус бохирдуулж, хаягдал ус гарган төлбөр төлөх эдтгээдийг бүртгэх үйл явц	35
Зураг 14. Бохир усыг байгальд хаях төлбөр төлөх гэрээ байгуулах үйл явц	36
Зураг 15. Ус бохирдуулсны төлбөр тооцох үзүүлэлтүүд	36
Зураг 16. Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл.....	37
Зураг 17. Ус хэрэглэх зөвшөөрөл олгох	39
Зураг 18. Ус ашиглах зөвшөөрөл олгох	39
Зураг 19. Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах	40
Зураг 20. Хаягдал усны чанарын хяналт-шинжлэлийн үйл явц, тавигдах шаардлага ..	40
Хүснэгт 2. Хаях, зайлуулах усан дахь бохирдуулагч бодисын хэмжээг тооцоолох	41
Зураг 21. Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг тооцох болон төлөхөд тавигдах шаардлага	41
Хүснэгт 3. Зураг төсөл боловсруулалт, барилга угсралт, ашиглалтын үе шатуудын үйл ажиллагааны жагсаалт	42
Хүснэгт 4. Хаягдал усыг цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламжийн төлөвлөлт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагааны замын зураг (1-р хэсэг).....	43
Хүснэгт 5. Хаягдал усыг цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламжийн төлөвлөлт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагааны замын зураг (2-р хэсэг).....	44
Хүснэгт 6. Уулзалт хийсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын мэдээлэл	44
Зураг 22. Уулзалт, ярилцлагын үеийн фото зураг	46
Хүснэгт 7. Ярилцлагын судалгааны үр дүн	47
Зураг 23. Үйлдвэрийн газрын урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, батлуулах, барих, ашиглах, холбогдох зөвшөөрөл авах үе шат.....	85
Зураг 24. Усны мэдээллийн нэгдсэн сангийн вэб сайт	90
Зураг 25. Усны мэдээллийн нэгдсэн сангийн вэб сайтын агуулга.....	91
Зураг 26. Усны нөөц, ус ашиглах, хаягдал усны талаар дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх баримт бичиг.....	92
Зураг 27. Усны мэдээллийн нэгдсэн сангийн үйлчилгээний нэгдсэн мэдээлэл.....	92

Зураг 28. Албан тоот.....	93
Зураг 29. Улсын бүртгэлийн гэрчилгээ болон Тусгай зөвшөөрөл.....	94
Зураг 30. Ус ашиглах дүгнэлт.....	96
Зураг 31. Технологийн схемийн танилцуулга.....	97
Зураг 32. Лабораторийн шинжилгээний хариу.....	98
Зураг 33. УСУГ-тай хийсэн тооцооны хуудас.....	99

Товч тайлбар

Товч тайлбар

Энэхүү судалгаа нь Монгол улсад үйлдвэрийн хаягдал усны урьдчилсан цэвэрлэх байгууламжуудтай холбогдох өнөөгийн хууль тогтоомж, дүрэм журамд хяналт хийж, эдгээр байгууламжуудын суурилуулалт болон үйл ажиллагааг тайлбарласан. Үр дүнд нь үйлдвэрийн болон төрийн албан хаагчдын боловсролын материал, гарын авлагуудыг боловсруулахад туслах зорилготой юм.

Үүнд 12 хууль, 6 стандарт, 3 засгийн газрын тогтоол, 11 сайдын тушаалыг хянасан. Үр дүнг гурван гол хэсэг болгон танилцуулсан бөгөөд эдгээр нь хууль эрх зүйн шаардлага, үйл явц болон ажиллагааны дадлага зэрэг нийтлэг зааврыг өгнө.

- Үр дүн 1: Хаягдал ус цэвэрлэх байгууламж, урьдчилан цэвэрлэх байгууламжийн эрх зүйн шаардлагыг долоон чухал салбарт ангилан тодорхойлсон. Үүнд: зөвшөөрөл, лиценз, байгаль орчны хариуцлага, бохирдлоос урьдчилан сэргийлэх ба хяналт, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хэрэгжилт ба хариуцлага, татвар, хураамж, бохирдуулагчийн төлбөрийн үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл багтана.
- Үр дүн 2: Хаягдал ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд шаардлагатай гол процесс болон шаардлагуудыг тодорхойлоход 21 ширхэг урсгал диаграмм гаргасан. Үүнд загвар зөвшөөрөл авах, дахин ашиглах стандарт, засгийн газрын үйл ажиллагаа, Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээний (БОНУ) журам, Ус ашиглалтын зөвшөөрөл (УАЗ), Ус бохирдуулсны төлбөр (УБТ) ба торгуулийн журмууд багтана. Эдгээр урсгал диаграммууд нь холбогдох дүрэм журмыг ойлгоход хялбар, алхам алхмаар зааварчилгаа өгөх болно. Мөн татвар, хураамж зэрэг санхүүгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд туслах юм.
- Үр дүн 3: Хаягдал ус цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламжийг хөгжүүлэх үе шаттай замын зураглал нь урьдчилсан үнэлгээ, төлөвлөлтөөс эхлээд ашиглалт, засвар үйлчилгээ хүртэлх олон үе шатыг хамардаг. Тусгайлан анхаарах зүйл бол зураг төсөл, инженерчлэлийн үе шат бөгөөд барилга угсралтын ажлын чухал хэсгүүд, тухайлбал, барилгын зөвшөөрөл авах, суурилуулалт, ашиглалтад оруулах зэрэг үйл явцыг хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагад нийцүүлэх явдал юм. Замын зураглалд тодорхой үе шатанд ямар шаардлага тавигдаж буйг тусгасан бөгөөд үүнд зөвшөөрөл авах, байгаль орчинд үзүүлэх нөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал, татвар, хураамжийн төлбөр зэрэг багтана.

Илүү ойлгомжтой болгох үүднээс үр дүн 1 ба 2-ын гол мэдээллийг агуулсан хоёр хүснэгтийг энэхүү хураангуйд багтаасан.

Энэхүү тайланд танилцуулсан Монгол Улсын үйлдвэрийн хаягдал усны урьдчилсан цэвэрлэх байгууламжуудын хууль, дүрмийн дэлгэрэнгүй судалгаа нь төрийн болон үйлдвэрийн оролцогчдод чухал ойлголтуудыг өгнө. Нарийн зохицуулалтуудыг хэрэгжүүлж болох, ойлгомжтой үр дүнгүүдэд шилжүүлснээр, хууль эрх зүйн шаардлагууд, үйл явцын процедурын урсгал диаграмм болон хөгжлийн үе шатны төлөвлөгөөг багтаасан энэ судалгаа нь үйлдвэрүүд болон зохицуулах байгууллагуудад хуулийг ойлгож, хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэгслийг олгох юм. Үр дүн нь зохицуулалтын дагаж мөрдөх байдлыг сайжруулах, хаягдал усны менежментийн үр ашгийг нэмэгдүүлэх, мөн Монгол Улсын үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой. Эдгээр үр дүн нь ирээдүйн сургалт, үйл ажиллагааны заавар, бодлого боловсруулахад үндэс суурь болж чадна.

Үр дүнгийн хураангуй хүснэгт 1: Хууль эрх зүйн шаардлагын судалгаа

No.	Хэсгийн гарчиг	Дүрэм журам ба тэмдэглэл
1	Хаягдал ус цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламж	Хот, суурины ус хангамж, ариутгах татуурганы тухай хуулиар (2011) цэвэрлэх байгууламжуудад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон байна. Энэхүү хууль нь урьдчилан цэвэрлэх байгууламжийн суурилуулалт болон үйл ажиллагаатай холбогдох нэмэлт шаардлагуудыг зохицуулдаггүй.
2	Зөвшөөрөл ба лиценз олголт	- Хаягдал ус цэвэрлэх болон урьдчилан цэвэрлэх үйл ажиллагаа, байгууламжуудад шаардлагатай гол зөвшөөрлүүдийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуурганы тухай хуулиар (2011) тодорхойлсон байна. Эдгээр зөвшөөрлүүдийг олгох, сунгах, эсвэл цуцлах үүрэг хариуцлагыг зохицуулах хороонд олгосон. - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан А/719/189 дугаар тушаал (2019) нь хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн загварыг баталсан. Энэ загвар нь байршил, зайлуулах усны хэмжээ, усны чанарын стандарт (MNS 4943:2015 эсвэл MNS 6561:2015), мөн зөвшөөрлийн хүчинтэй хугацааг хамардаг. - Зөвшөөрлийн тухай хууль (2022) нь дээр дурдсан зөвшөөрлүүдийг тодорхойлсон бөгөөд зөвшөөрлийг олгох байгууллага нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг зохицуулах зөвлөл юм. - Барилгын тухай хууль (2016)-д “инженерийн шугам сүлжээ” гэж нийтийн ариутгах татуурга болон цэвэрлэх байгууламжийг ангилсан. Барилга болон цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлагууд нь: стандартын шаардлагыг биелүүлэх, үр ашигтай байх, байгаль орчин болон хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах явдал юм.
3	Байгаль орчны хариуцлага	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2012) нь аж ахуйн нэгж, байгууллагууд байгаль орчныг хамгаалах талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлдог. - Байгаль, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөө, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн хэрэгсэл бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) юм. БОНБУ-ийн тухай хууль (2012) нь үнэлгээ хийх үйл явц болон түүний агуулгыг тодорхойлсон байдаг. Үнэлгээний үйл явцад суурь нөхцөл байдлыг судлах, төслийн нийгэм-эдийн засаг, соёл, хүний эрүүл мэндэд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөг үнэлэх, сөрөг нөлөөг багасгах шийдэл, арга хэмжээ санал болгох, байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хяналтын хөтөлбөр боловсруулах зэрэг багтдаг. - Банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагуудыг байгаль орчин, нийгэм болон хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээнд санхүүжилт эсвэл зээл олгохыг хориглодог.
4	Эрүүл мэнд ба аюулгүй байдал	Эрүүл ахуйн тухай хууль (2016) нь аж ахуйн нэгж, байгууллагуудын хүмүүсийн эрүүл мэнд ба аюулгүй байдалтай холбоотой эрх, үүргийг тодорхойлдог.
5	Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба хяналт	- Усны тухай хууль (2012) нь ус хэрэглэгчдэд усны бохирдол болон хаягдал устай холбоотой үүрэг хариуцлагыг тогтоосон. - Хог хаягдлын тухай хууль (2017) нь иргэд, аж ахуйн нэгжүүд болон байгууллагуудын хог хаягдалтай холбоотой эрх, үүрэг хариуцлагыг тогтоосон. - Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)-д заасны дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд байгаль орчныг хамгаалах дэвшилтэт арга хэрэгжүүлсэн тохиолдолд Байгаль орчин, уур амьсгалын сангаас дэмжлэг авах боломжтой. Энэ нь байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд

No.	Хэсгийн гарчиг	Дүрэм журам ба тэмдэглэл
		үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, мөн хортой бодис хэрэглэхээс татгалзаж, бохирдолгүй, хаягдал багатай, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилготой юм.
6	Татвар болон хураамжийн төлбөр	- Усны бохирдлын хураамжийн тухай хууль (2012) нь усны бохирдол болон хаягдал ус ялгаруулдаг байгууллагуудыг бүртгэх журмыг тодорхойлдог. Энэхүү хууль нь эдгээр хураамжийг тооцоолох үзүүлэлтүүд, чөлөөлөлт болон бууруулалтын нөхцлүүд, төлбөр тооцооны болон тайлангийн журмууд, ус бохирдуулагч байгууллагуудын дагаж мөрдөх үүрэг хариуцлагыг тодорхойлдог. - Төрийн тогтоол Дугаар 107 (2023 оны 3-р сарын 22) нь татварын хөнгөлөлт буюу чөлөөлөлт авах эрхтэй хүнс, хөдөө аж ахуйн салбарын тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргажээ. Жагсаалтанд нийт 33 зүйл багтсан бөгөөд үүнд үйлдвэрүүдийн хаягдал ус цэвэрлэх болон хэмжих тоног төхөөрөмж, мах боловсруулах үйлдвэрүүдийн хаягдал ус шүүх тоног төхөөрөмж, сүү, ундаа, жимсний боловсруулах үйлдвэрүүдийн ус цэвэрлэх, угаах, зөөлрүүлэх тоног төхөөрөмж болон хэмжих хэрэгслүүд орсон байна.
7	Хэрэгжилт ба Торгууль	- Эрүүгийн тухай хууль (2017) нь дүрэм журам зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах нөхцлийг тогтоосон. Хаягдал ус болон цэвэрлэх байгууламжтай холбоотой торгууль ногдуулах нөхцлүүд нь: - Цэвэрлэгээгүй хаягдал ус нь зөвшөөрөгдсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд ариутгах татуургын сүлжээнд хаягдсан; - Ус бохирдуулагчдын талаархи мэдээлэл, хаягдал усны хэмжээ, найрлага эсвэл бохирдуулагчдын талаарх мэдээлэл нууж, худал мэдээлсэн; - Хот, суурин газруудад ус хангах болон ариутгах татуургын тухай хуулийг зөрчсөн: Зөвшөөрөгдсөн хаягдал усны найрлагыг хангаагүй цэвэрлэгээгүй хаягдал ус; Ус хэрэглэж, хаягдал усны бүртгэл, судалгаа, хяналт, шинжилгээ хийх, хугацаанд нь бичиг баримт хадгалах үүргийг биелүүлээгүй; - Ус бохирдуулах хураамжийн тухай хуулийг зөрчсөн: Ус бохирдуулагчдын талаархи мэдээлэл, хаягдал усны хэмжээ, найрлага эсвэл бохирдуулагчдын талаарх мэдээлэл нууж, худал мэдээлсэн - Газрын тухай хуулийг зөрчсөн: Байгаль орчин, хүн амын эрүүл мэнд, мал амьтан, ан амьтан, агаар, ойн сан, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлсэн барилга байгууламж барих эсвэл тоног төхөөрөмж суурилуулах; Үйлдвэрийн хог хаягдал, бохирдсон ус, хорт бодисыг зөвшөөрөлгүйгээр устгах - Төрийн хяналтын тухай хууль нь төрийн хяналтын ажилтнуудын зохицуулалтын зөрчилтэй холбоотой эрх, үүргийг тодорхойлж, зөрчил, үр дагавар, шалтгаан болон торгууль зэрэг зүйлсийг хамардаг - Усны тухай хууль, ус хангах, ариутгах татуургын хууль, байгаль орчин, барилга, хог хаягдал, бохирдлын хураамж, зөвшөөрөл болон төрийн тусгай сангийн хуульд торгууль тогтоосон: Хэрэв төрийн албан хаагчдын зөрчил гэмт хэргийн шинжтэй биш бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ; Энэхүү хуулийг зөрчсөн хүн болон хуулийн этгээд нь Эрүүгийн хууль эсвэл Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээнэ. - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль нь хохирлыг нөхөн төлбөрөөр нөхөж олгохыг тодорхойлдог.

Үр дүнгийн хураангуй хүснэгт 2: Шаардлага, үйл явцын диаграмм ба процессууд

No.	Хэсгийн гарчиг	Дүрэм журам, стандарт	Урсгал диаграмм ба хүснэгт
1	Хаягдал ус цэвэрлэх байгууламжийн процесс болон шаардлагууд	- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль (2011) - MNS 4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага	- Цэвэрлэгээний байгууламжийн шаардлага - Нийлүүлэгч болон хэрэглэгч, тэдгээрийн хоорондох гэрээ
2	Барилга/барилгын дизайныг боловсруулах, баталгаажуулах, болон зөвшөөрөх процесс	Төрийн захирамж No. 107 (2019)	- Барилга, бүтээн байгуулалтын дизайныг боловсруулах, баталгаажуулах, зөвшөөрөх үе шатнууд - Барилга, бүтээн байгуулалтын дизайны инженерийн судалгааны үйл явц - Барилгын дизайныг хянах болон батлах үйл явц
3	Дахин ашиглахад зориулсан цэвэрлэсэн усны шаардлагууд	MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага.	Цэвэрлэсэн усны дахин ашиглахад тавигдах техникийн шаардлагууд
4	Бохир ус цэвэрлэхэд Засгийн газрын үүрэг	Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хууль (2011)	- Ус хангамж, ариутгах татуургаас хамаарах төрийн үүрэг: Бодлогын боловсруулалт - Ус хангамж, ариутгах татуургаас хамаарах төрийн үүрэг: Зохицуулах хорооны байгууламж
5	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам	- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль (2012) - Төрийн захиргааны тогтоол No. 58 (2024)	- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний төрөл - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ - Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
6	Усны бохирдлын хураамж ба төлбөрийн журам	Сайдын захирамжууд: - A/406/226 дугаар - A/635 (2019) дугаар - A/356/396 (2015) дугаар - A/356/396 (2015) дугаар Ус бохирдуулагч хураамжийн тухай хууль	- Ус бохирдуулах хураамжид бүртгүүлэх журам - Байгальд хаях хаягдал усны төлбөрийн гэрээ байгуулах журам - Ус бохирдуулах хураамжийн усны хэмжих нэгжүүд - Ус бохирдуулах хураамжийн чөлөөлөлт болон хөнгөлөлт
6.1	Усны бохирдлын хураамжийн бүртгэл, гэрээ байгуулах журам		
6.2	Усны хэрэглээний зөвшөөрөл болон гэрээ байгуулах журам ба оролцогч талууд	- Усны тухай хууль (2012) - Иргэний болон эрүүгийн хууль	- Үйлдвэрлэлийн бус ус ашиглах зөвшөөрөл - Үйлдвэрлэлийн ус ашиглах зөвшөөрөл - Үйлдвэрлэлийн ус ашиглах гэрээ

6.3	Хаягдал усны чанарын хяналт болон ус бохирдуулсны хураамжийн төлбөр	Сайд нарын захирамж: А/406/226 (2021) дугаар	19. Хаягдал усны чанарыг хянах үйл ажиллагаа болон шаардлага Хүснэгт 2. Бохирдуулагч бодисын тоо хэмжээ тооцох шаардалагууд
6.4	Ус бохирдуулсны хураамжийг тооцоолох болон хэт бохирдлын нөхөн төлбөр	Сайдын тушаалууд: • А/406/226, (2021) дугаар • А/543 (2019) дугаар • А/816/218 (2019) дугаар MNS ISO 6060: 2001 Байгаль орчин – Усны чанар: Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох	20. Ус бохирдуулагч төлбөрийг тооцоолох, төлөх болон хохирлыг нөхөх шаардлагууд

Судалгааны тайлан

1. Танилцуулга

Үйлдвэрийн бохир усыг зохих ёсоор цэвэрлэж, боловсруулалгүйгээр хаягдвал байгаль орчинд ихээхэн хохирол учруулах эрсдэлтэй. Урьдчилан цэвэрлэх байгууламжууд нь хортой бохирдлыг цэвэрлэж, эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү судалгаа нь Монгол Улсад эдгээр байгууламжийг зохицуулах хууль, журмуудын өнөөгийн байдлыг судлах зорилготойгоор хийгдсэн. Мөн байгууламжуудыг суурилуулах, ажиллуулах талаарх мэдээллийг цуглуулж, үйлдвэрүүд болон төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага, сургалтын материал боловсруулахад ашиглахыг зорьсон болно.

2. Судалгааны зорилго ба үр дүн

Судалгааны зорилго нь дараах холбогдолтой мэдээлэл цуглуулахад оршино (1) Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах; (2) Үйлдвэрт урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, ажиллуулахад мөрдөх ёстой журам болон авах шаардлагатай зөвшөөрлүүд.

Энэхүү судалгааны хүрээнд гарах үр дүнгүүд гарсан:

- 1) Үйлдвэрүүдийн биелүүлэх шаардлагатай хууль, журамд тавигдах шаардлагуудын жагсаалт;
- 2) Үйлдвэрийн хаягдал усны урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, ажиллуулах тус бүрийн алхамыг харуулсан урсгалын диаграмм;
- 3) Үйлдвэрийн бохир усны урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, ажиллуулах нийт үйл явцын зураглал.

3. Ажлын хүрээ

Мэдээлэл цуглуулж, материалыг бэлтгэх ажлын хүрээ нь дараах байдлаар тодорхойлогдсон:

- 1) Үйлдвэрүүдийн биелүүлэх ёстой хууль, журам:
 - a. Хууль, журмуудыг шалгах;
 - b. 3 баганатай хүснэгтэд шинжилгээ хийж, дараах мэдээллүүдийг оруулах:
(А) Хууль, журам (В) Эрх зүйн шаардлага; (С) Торгууль;
- 2) Үйлдвэрийн хаягдал усны урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, ажиллуулах тус бүрийн алхамыг харуулсан урсгалын диаграмм:
 - a. Үйлдвэрийн болон төрийн журмуудыг урсгалын диаграмм эсвэл текст хэлбэрээр тайлбарлах;
 - b. Мэдээлэлд дараах зүйлсийг оруулах шаардлагатай:
 - i. Шаардлагыг тогтоосон хууль/тушаал/журмууд/стандарт;
 - ii. Үйлдвэр (горилоч) хэзээ журмыг эхлэх буюу дуусгах шаардлагатай вэ?
 - iii. Бүх журмыг дуусгах болон тус бүрийн алхамыг хэр удаан хугацаанд гүйцэтгэх вэ?
 - iv. Шаардлагын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - v. Холбогдох баримт бичиг эсвэл өргөдлийг хүлээн авах төрийн байгууллага (нэр, хаяг, утасны дугаар, хариуцсан хүн)?
 - vi. Журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичиг эсвэл мэдээлэл (баримт бичгийн агуулга, баримт бичгийн жагсаалт, загвар формат гэх мэт.);
 - vii. Баримт бичгийг хэрхэн гаргаж, журмыг хэрхэн үргэлжлүүлэх вэ?
(Баримт бичгийг биечлэн өгөх эсвэл онлайн хүлээн авах

- боломжтой, уулзалт хийх эсвэл судалгаа хийх шаардлагатай гэх мэт.);
- viii. Үйлдвэрийн зүгээс шаардлагыг биелүүлэхтэй холбоотой асуудлууд
- ix. Төрийн байгууллагын зүгээс шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд.
- 3) Үйлдвэрийн хаягдал усны урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах, ажиллуулах нийт үйл явцын зураглал:
- a. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулах болон ажиллуулах үе шат бүрт шаардлагатай эрх зүйн шаардлагуудыг харуулсан нийт журмын зураглал бэлтгэх. Үүнд:
- i. "Төлөвлөлт",
- ii. "Төсөл боловсруулах",
- iii. "Барилга барих",
- iv. "Шалгалт ба туршилт"
- v. "Ажиллагаа".
- b. Бусад шаардлагуудыг биелүүлэхэд шаардлагатай урьдчилан тавигдах нөхцлүүдийг тодорхойлон, тэдгээрийн холбоог зураглалд оруулах.

4. Арга зүй

Судалгаа нь чанарын аргаар хийгдсэн бөгөөд энэ нь одоо мөрдөгдөж буй хууль, журам, зохицуулалтын баримт бичгүүдийг судалж, тэдгээрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжид холбогдох ач холбогдлыг шинжилсэн. Шаардлага, журам, үйл явцын дараалал, оролт, гаралт, мөн байгууллагууд, хувь хүмүүс болон шийдвэр гаргагч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон урсгалын диаграммуудыг онцгойлон анхаарч үзсэн. Мэдээллийг Интернэт дэх нээлттэй эх сурвалжаас цуглуулсан.

Хууль, журмуудыг шинжилж, олон улсын шилдэг практикт түгээмэл хэрэглэгддэг шаардлагын ангилалтай нийцүүлэн харьцуулсан бөгөөд энэ нь үйлдвэрийн байгууллагууд болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн асуудлуудад онцгой анхаарал хандуулсан. Эдгээр хууль, журмуудын холбогдох заалтуудыг тодорхой, ойлгомжтой гарчигтай жагсаалт болон дугаарласан жагсаалтаар танилцуулсан.

Ус бохирдуулагч этгээд, хаягдал усны найрлага дахь бохирдуулах бодисын агууламжийн хэмжээнд тавигдах стандартын шаардлагыг хангах үүрэгтэй ба үүнийг хангахын тулд ус бохирдуулагч нь хаягдал усны найрлага дахь бохирдуулах бодисын агууламжийг үе шаттай бууруулах, стандартын шаардлагыг хангах арга хэмжээ авах, цэвэрлэх байгууламжийн чанар, үр ашгийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, усыг эргүүлэн ашиглах зэрэг үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, хэвийн найдвартай ажиллагааг хангах, хаягдал усны найрлага, түүнд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээг тогтмол хянаж, холбогдох байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

Процессыг дараах 4 бүлэг дээр үзүүлэлтүүдийг схемийн тусламжтайгаар харуулна.

- Ус бохирдуулсны төлбөрийг бүртгэх, гэрээ байгуулах процессын дарааллыг;
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах, гэрээ байгуулах процессын дарааллыг;
- Ус бохирдуулсны төлбөр ногдуулах, төлбөр төлөх процессын дарааллыг;
- Ус бохирдуулсны нөхөн төлбөр ногдуулах, төлбөр төлөх процессын дарааллыг.

6.6.1. Усны бохирдлын төлбөрийг бүртгэх болон гэрээ байгуулах процесс

Бүртгэл хийх болон гэрээ байгуулахад оролцогч талууд, тэдний үүрэгтэй холбоотой мэдээллийг (Зураг 13,14)-д үзүүлсэн. Аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдон хаягдал усаа зайлуулдаг бол заавал гэрээ байгуулах ёстой. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөрийг хариуцах этгээд болох усны сав газрын захиргаа, Татварын ерөнхий газар, сумын засаг даргатай гэрээ байгуулан төлбөр төлнө.

Аж үйлдвэрийн болон үйлчилгээний байгууллагууд төв ус бохирдуулах сүлжээнд бохир ус хаях гэрээтэй байх ёстой. Усны сав газрын захиргаа, Татварын алба, Сум/Дүүргийн Засаг дарга нар бохир ус боловсруулдаг байгууллагуудтай гэрээ байгуулж, усны бохирдлын төлбөрийг тооцоолно. Татварын ерөнхий газар нь ус бохирдуулсны төлбөр төлөгчийг бүртгэж, төлбөрийн мэдээллийг оруулна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын яам хамтран хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоож, цэвэрлэх байгууламжийн стандартыг шинэчлэн тогтооно. Байгаль орчны сайдын А/635 тоот тушаалаар батлагдсан “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ”-ний хавсралтаар батлагдсан загварыг ашиглана.

Усны бохирдлын төлбөрийн тухай хуульд ус бохирдуулсны төлбөрийн хувь хэмжээг тодорхойлоход баримтлах зарчмыг тусгасан бөгөөд хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн тооцдог. Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ ялгаатай байна (Зураг 15). Мөн хуулийн дагуу чөлөөлөлт, хөнгөлөлтийг хэрхэн авах талаар зааж өгсөн. Хаягдал ус цэвэрлэх байгууламжид холбогдсон, биологийн цэвэрлэгээ хийдэг бол ус бохирдуулсны төлбөрөөс 30 хувь хөнгөлнө. Харин хаягдал усыг цэвэршүүлж, дахин ашигладаг бол ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөнө.

Хаягдал ус цэвэрлэх байгууламж суурилуулж, ашиглалтад оруулснаас хойш 3 жилийн хугацаанд ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлнө (Зураг 16).


Байгаль орчны яамны А/18 дугаар тушаал (2018 оны 1-р сарын 30) аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, журмыг баталсан.

Хортой бодис, аюултай хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох тухай жагсаалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/356/396 дугаартай хамтарсан тушаалаар баталсан (2015 оны 10-р сарын 8). Уг тушаалын нэгдүгээр хавсралтаар хортой бодис, аюултай хаягдлын ангиллыг тодорхойлж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөө үзүүлэх, физик, хими, биологийн хувьд аюултай шинж чанартай бодис, хаягдлыг тодорхойлон заасан.

Тушаалын гуравдугаар хавсралтад нийт 3155 хортой бодисын жагсаалтыг гаргасан бөгөөд ихэнх нь шингэн орчинд хурдан задарч хортой болон аюултай шинж чанартай бодис ялгаруулдаг. Жишээлбэл, хөнгөн цагааны литийн гидрид, натрийн гидрид, калийн гидрид зэрэг бодисууд усанд маш хурдан урвалд орж, шатамхай хий ялгаруулдаг.

Хаягдал усны цэвэрлэгээний технологич нар уг тушаалын хавсралтуудаар ангилсан хортой бодис, аюултай хаягдлуудын нөлөөллийг сайтар судалж, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, санамж, кодыг зөв ашиглаж, ажилчдадаа таниулж, сургах шаардлагатай. Ингэснээр осол аваараас урьдчилан сэргийлж, хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах боломжтой юм.

Зураг 13. Ус бохирдуулж, хаягдал ус гарган төлбөр төлөх эдтгээдийг бүртгэх үйл явц




Эх сурвалж: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012)

Зураг 14. Бохир усыг байгальд хаях төлбөр төлөх гэрээ байгуулах үйл явц



Эх сурвалж: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012,
Бохир усыг байгальд хаях төлбөр төлөх гэрээний загвар,
Байгаль орчны сайдын тушаалын хавсралт, А/635, 2019


Зураг 15. Ус бохирдуулсны төлбөр тооцох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012

Зураг 16. Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл

8 дугаар зүйл. Төлбөрөөс
чөлөөлөх, хөнгөлөх



Эх сурвалж: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012

6.6.2. Ус ашиглалтын зөвшөөрөл, гэрээний талаарх үйл явц ба оролцогч талууд

Усны тухай хууль (2012) нь усны хэрэглээний зөвшөөрөл болон гэрээ авах үйл явцыг тодорхойлдог. Энэ үйл явц нь бизнесийн болон бизнесийн бус хэрэглэгчдэд өөр өөр байдаг. Бизнесийн бус хэрэглэгчид нь аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хандаж өргөдлөө өгөх шаардлагатай (Зураг 17), харин бизнесийн хэрэглэгчид нь Усны удирдлага, Аймаг, нийслэлийн захиргаа болон Аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хандах шаардлагатай. Бохир ус цэвэршүүлэх болон урьдчилан цэвэршүүлэх байгууламжууд нь бизнесийн усны хэрэглэгчдэд хамаарагддаг бөгөөд тэдгээр нь Зураг 18 болон 19-д заасан зөвшөөрөл болон гэрээг авах шаардлагатай.

Усны тухай хууль (2012)-иар ус ашиглалтын зөвшөөрөл авах, гэрээ байгуулах журмыг тодорхой зааж өгсөн байдаг. Энэ нь арилжааны болон арилжааны бус зориулалтаар ус ашиглагчдын хувьд ялгаатай үйл явцаар явагддаг. Арилжааны бус зориулалтаар ус ашиглагчид аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт хандаж, харин арилжааны зориулалтаар ус ашиглагчид Усны газар, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт хандаж зөвшөөрөл авах ёстой (Зураг 17). Хаягдал ус зайлуулах, цэвэрлэх байгууламжийг ашиглагч этгээд нь арилжааны зориулалтаар ус ашиглагчид тооцогдон, зөвшөөрөл, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулна (Зураг 18, Зураг 19).

Хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зөвшөөрөл, лиценз, гэрээг цуцлах, **Иргэний болон Эрүүгийн хуулийн** дагуу торгох шийтгэл ногдуулах зэрэг арга хэмжээ авна.

6.6.3. Бохир усны чанарын хяналт ба ус бохирдуулсны төлбөрийн төлөлтийн мониторинг

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан А/406/226 тоот тушаалаар (2021 оны 12-р сарын 23) батлагдсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" журмаар ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг тодорхойлох, төлбөр ногдуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулдаг. Ус бохирдуулагч нь төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаас хамаарахгүйгээр энэхүү журмыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

Хаягдал усны чанарт хяналт тавихад долоон гол үйл ажиллагаа багтдаг. Хаягдал ус цэвэрлэх байгууламж нь ус ашиглалтыг хянах менежерийг ажиллуулах, хаягдал усны дээж авах цэгүүдийг тогтоох, дээж авахдаа гар болон автомат төхөөрөмж ашиглах, лабораторид дээжийг шинжлэх, үр дүнг тайлагнах, шаардлагатай бохирдуулагчийн хураамжийг төлөх зэрэг үндсэн үүргүүдийг хариуцдаг. Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд нь эдгээр журам, стандартын биелэлтэд хяналт тавьж, зохицуулалт хийх үүрэгтэй. Зураг 20-д үйл ажиллагаанууд болон тэдгээрийн шаардлагуудыг харуулсан.

Зураг 20-д үйл ажиллагаанууд болон тэдгээрийн шаардлагуудыг харуулсан байдаг. Шаардлага 2.6-ийн дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 2-т харуулсан бөгөөд энэ нь зайлуулсан болон зайлуулсан хаягдал усанд агуулагдах бохирдуулагчдын тоо хэмжээг тооцоолох талаар заасан.

6.6.4. Усны бохирдлын төлбөр болон хэтэрсэн агууламжид ноогдох нөхөн төлбөрийг тооцох

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар (А/406/226, 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр) усны бохирдлын төлбөр тооцоход баримтлах журам, шаардлагыг тодорхойлсон байдаг.

Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд эдгээр төлбөр, нөхөн төлбөрийг тооцоолох, бүртгэх, хянах, тайлагнах, төвлөрүүлэх үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Ус бохирдуулагч этгээд болон цэвэрлэх байгууламжийн оператор компаниуд төлбөр, нөхөн төлбөрийг цаг тухайд нь бүрэн төлж барагдуулах, усны чанарын мэдээллийг үнэн зөв, бодитойгоор өгөх үүрэгтэй байдаг (Зураг 21).

Хавсралт No. 2-т усны бохирдлыг хянахад шаардлагатай долоон ангиллын параметруудыг жагсаасан байдаг. Үүнд физик, жинлэгдэх бодис, органик бодис, эрдэс бодис, хүнд металл, аюултай бохирдуулагч бодис, биологийн үзүүлэлт зэрэг багтана. Мөн 26 төрлийн аж үйлдвэрийн параметруудыг тодорхойлсон. Эдгээр параметруудад физик болон биологийн үзүүлэлтүүд, мөн жинлэгдэх бодис, органик бодис, эрдэс бодис, хүнд металл, аюултай бохирдуулагч бодисууд багтана.

Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын А/543 2019 оны 9-р сарын 27-ны өдрийн А/543 тушаал нь ус бохирдуулдаг аюултай бодисуудын жагсаалтыг баталсан.


Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан А/816/А/192 дугаар тушаалаар (2019 он) үйлдвэрлэлийн 22 салбарт, үйлчилгээний 7 салбарт, нийгмийн 2 салбарт хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тус тус баталсан байна.

Монголын улсын стандарт **"MNS ISO 6060: 2001 Байгаль орчин – Усны чанар: COD (Химийн хэрэгцээт хүчилтөрөгч) тодорхойлох"** нь дээж авах, шинжилгээ хийх зарчмууд, урвалж бодисууд, аргачлалууд болон багаж төхөөрөмжийг тодорхойлдог.

Ус бохирдуулагч болон/эсвэл цэвэрлэх байгууламжийн эзэмшигч, ашиглагч нар нь өөрсдийн үйл ажиллагааны онцлогт тохирсон үзүүлэлтүүдийг тодорхойлж, хяналт тавих замаар хаягдал усны чанарын стандартад нийцүүлэн ажиллах ёстой.

Зураг 17. Ус хэрэглэх зөвшөөрөл олгох


27 дугаар зүйл. Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл



Эх сурвалж: Усны тухай хууль, 2012

Зураг 18. Ус ашиглах зөвшөөрөл олгох

28 дугаар зүйл. Ус ашиглагчид олгох зөвшөөрөл



Эх сурвалж: Усны тухай хууль, 2012


Зураг 19. Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах

29 дүгээр зүйл. Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах



Эх сурвалж: Усны тухай хууль, 2012

Зураг 20. Хаягдал усны чанарын хяналт-шинжлэлийн үйл явц, тавигдах шаардлага




Эх сурвалж: Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал, No. А/406/226, 2021.12.23

Хүснэгт 2. Хаях, зайлуулах усан дахь бохирдуулагч бодисын хэмжээг тооцоолох

№	Шаардлага	Тайлбар
1	Тооцоо хийж, дүгнэлт гаргах байгууллагын хариуцлага	- Бохир усны хэмжээ, бохирдуулагчийн агууламжаас хамааран бохирдуулагч бодисын хэмжээ, ус бохирдуулах төлбөрийг тооцоолох "Хаягдал усны бохирдуулагч бодисын хэмжээг тооцоолох аргачлал"-ыг хэрэглэх - Бохир ус зайлуулах, зайлуулах зөвшөөрөл олгосон байгууллага, ус бохирдуулагчид ажлын 10 хоногийн дотор дүгнэлт гаргах.
2	Бохир усны хэмжээ, хэмжих хэрэгсэл	- Бохир усны шугам дээр суурилуулсан хэмжих төхөөрөмжөөс бохир усны хэмжээг тодорхойлно - Байгальд хаягдсан бохир усыг Сав газрын захиргааны ажилтан, сум, дүүргийн Байгаль орчны байцаагч сар бүр хэмжих хэрэгсэл, хэмжилтийг хянаж актаар баталгаажуулна.
3	Хэмжих төхөөрөмжгүй буюу эвдэрсэн тохилдолд бохир усны хэмжээг тооцоолох	- Тооцоолох томъёо: Хаягдал ус = Цэвэр ус – Бүтээгдэхүүн / үйлчилгээнд шингэсэн ус - Цэвэр усыг технологийн цэвэр усны шугамд суурилуулсан төхөөрөмжөөр хэмждэг - Үйлдвэрлэл, үйлчилгээнд шингэсэн усыг "Үйлдвэрлэл, ажил, үйлчилгээнд хэрэглэх бүтээгдэхүүний усны норм"-д заасан байдаг.
4	Хаягдал усан сангийн болон цэвэрлэх, дахин ашиглах бохир усны хэмжээг тооцоолох	- Wastewater is equal to the volume of recycled water, or - If recycled water is not measured then calculate basing on the capacity of the water intake pump, or the conclusion of water use for the current year, or the water consumption norm
5	Газрын тосны үйлдвэрийн хаягдал усыг тодорхойлох	Газрын тосны үйлдвэрийн хаягдал усыг өрөмдлөгийн шингэн хаягдлын усан сан (зүмп) - гийн хэмжээгээр тодорхойлно.
6	Ус бохирдуулсны төлбөр, илүүдэл бохирдлын нөхөн төлбөрийн тооцоо	Төвлөрсөн бохир усны шугам сүлжээнд нийлүүлэх, байгальд хаях бохир усны зөвшөөрөгдөх дээд хэмжээг үндэслэн ус бохирдуулсны болон илүүдэл бохирдлын нөхөн төлбөрийн тооцоог хийнэ
7	Бохир усны эзэлхүүний хэмжилтийн мэдээг өгөх, төлбөр төлөлтөд хяналт тавих	- Хэмжилт хийснээс хойш ажлын 5 хоногийн дотор - Сав газрын захиргаа ус бохирдуулсны төлбөр төлөлтөд хяналт тавина.

Эх сурвалж: Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал, No. А/406/226, 2021.12.23

Зураг 21. Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг тооцох болон төлөхөд тавигдах шаардлага



Эх сурвалж: Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал, No. А/406/226, 2021.12.23

7. Үйлдвэрийн хаягдал усны урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах ерөнхий журмын зураглал

Хаягдал усны цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламж барих үйл явц нь урьдчилсан үнэлгээ, төлөвлөлтөөс эхлээд ашиглалт, засвар үйлчилгээ хүртэлх олон үе шатыг хамардаг. Зураг төсөл боловсруулах, барилгын ажлын үед холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудыг мөрдөх шаардлагатай бөгөөд суурилуулалт, ашиглалтад оруулах үйл явцыг удирдан чиглүүлэх ёстой. Замын зураглал нь зөвшөөрөл авах, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэх, татвар, хураамжийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай алхмуудыг тодорхой зааварчилгаатайгаар хэрэгжүүлэхэд тусалдаг.


Монгол Улсын хувьд үйлдвэрийн хаягдал усны урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны журмын замын зургийг Хүснэгт 4-т харуулсан бөгөөд зураг төсөл боловсруулах, барилгын ажлын үе шат, ашиглалтын үе шатанд хамаарах үйл ажиллагааны жагсаалтуудыг интернетээс цуглуулсан бөгөөд доор харуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Зураг төсөл боловсруулалт, барилга угсралт, ашиглалтын үе шатуудын үйл ажиллагааны жагсаалт


1-р үе шат: Урьдчилсан үнэлгээ, төлөвлөлт	2-р шат: Зураг төсөл, инженерчлэл
- Хэрэгцээт байдлын үнэлгээ - Үүсэх бохир усны төрөл, хэмжээг тодорхойлох. - Одоо байгаа бохирдуулагч бодис, тэдгээрийн агуулгыг үнэлэх - Дагаж мөрдөх хууль, журам, байгаль орчны стандартыг тодорхойлох. - ТЭЗҮ - Ус цэвэрлэх янз бүрийн технологийг (жишээлбэл, физик, хими, биологийн) судлах, үнэлэх. - Зардлыг тооцоолох, шинжих (хөрөнгө, ашиглалтын болон засвар үйлчилгээ). - Суурилуулалтын талбайн тохиромжтой байдлыг үнэлэх. - Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн судалгаа, үнэлгээ хийх. - Төсөв, санхүүжилт - Бүх үе шатыг хамарсан нарийвчилсан төсөв боловсруулах. - Санхүүжилтийн боломжит эх үүсвэрүүдийг (буцалтгүй тусламж, эзэл, дотоод сан) тодорхойлох. - Санхүүгийн үндэслэл, ROI шинжилгээг бэлтгэх. - Талуудын оролцоо - Гол оролцогч талуудыг (зохицуулах байгууллага, орон нутгийн иргэд, дотоод багууд) тодорхойлох. - Санал хүсэлтийг цуглуулж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд зөвлөгөөн, семинар зохион байгуулах. - Шаардлагатай зөвшөөрөл авах, баталгаажуулалт хийлгэх	- Концепцийн дизайн - Урьдчилан цэвэрлэх байгууламжийн концепцийн загварыг бий болгох. - Хүчин чадал, зохион байгуулалт, үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох. - Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох. - Нарийвчилсан инженерчлэл - Нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах. - Материал, тоног төхөөрөмжийг сонгох. - Хяналт ба автоматжуулалтын системийг тодорхойлох. - Аюулгүй байдал, байгаль орчны дүрэм журмыг дагаж мөрдөх. - Худалдан авалт - Тоног төхөөрөмж, материалын борлуулагчдыг тодорхойлж, сонгох. - Худалдан авах ажиллагаа - Тоног төхөөрөмж, материалын ханган нийлүүлэгчийг тодорхойлох, сонгох - Худалдан авалтын баримт бичгийг (RFP, гэрээ) бэлтгэх. - Борлуулагчийн үнэлгээг хийж, ханган нийлүүлэгчдийг сонгох. - Худалдан авалт, ложистикийн төлөвлөлтийг эцэслэх.
3-р үе шат: Барилга угсралтын ажил	4-р үе шат: Үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ
- Барилга байгууламжийн талбайг бэлтгэх - Талбайг бэлтгэх (цэвэрлэх, ангилах, хэрэгслүүдийг суурилуулах). - Барилгын байгууламж, агуулахын талбайг бий болгох. - Байгаль орчин, аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх. - Барилга байгууламж барих - Иргэний барилга байгууламж (суурь, барилга) барих. - Механик, цахилгаан, сантехникийн системийг суурилуулах. - Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах. - Барилга хүлээн авах, ашиглалтанд оруулах - бүрэлдэхүүн хэсгүүдийг тус тусад нь болон системээр нь турших. - Барилга байгууламжийг бүхэлд нь эхлүүлэх, ашиглалтад оруулах. - Оператор, засвар үйлчилгээний ажилтнуудыг сургах. - Чанарын баталгаа ба дагаж мөрдөх - Бүх суурилуулалтанд чанарын шалгалт хийх. - Хууль, журамд, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах. - Шаардлагатай гэрчилгээ, зөвшөөрлийг авах.	- Үйл ажиллагааны бэлэн байдал - Стандарт үйл ажиллагааны журам (SOP) боловсруулах. - Урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх. - Хяналт, тайлагнах протоколыг бий болгох. - Сургалт, хүлээлгэн өгөх - Ажилчдыг ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургах. - Эцсийн шалгалтыг хийж, үйл ажиллагааны багт хүлээлгэн өгнө. - Байгууламжийг баримтжуулж, өгөгдлийг боловсруулах. - Гүйцэтгэлийн хяналт - Байгууламжийн гүйцэтгэлийг дизайны параметрийн дагуу хянах. - Байгаль орчин, аюулгүй байдлын шалгалтыг тогтмол хийх. - Үйл ажиллагааны стратегийг оновчтой болгох тохируулгыг хийх - Тасралтгүй сайжруулалт - Ус цэвэрлэх үйл явцыг хянаж, оновчтой болгох. - Технологи хөгжихийн хэрээр шинэчлэлт, сайжруулалт хийх - Талуудын оролцоон хангах

Интернэтийн эх сурвалжаас

Хүснэгт 4. Хаягдал усыг цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламжийн төлөвлөлт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагааны замын зураг (1-р хэсэг)



Хүснэгт 5. Хаягдал усыг цэвэрлэх/урьдчилан цэвэрлэх байгууламжийн төлөвлөлт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагааны замын зураг (2-р хэсэг)



Мэдээллийн эх сурвалж: Монгол улсын хууль, журам

8. Уулзалт, ярилцлага хийсэн байгууллагын ерөнхий мэдээлэл



Захиалагчаас өгсөн нэрсийн дагуу холбогдох төрийн байгууллагын албан хаагчидтай ярилцлагын цаг товлож, уулзалт хийсэн ба ярилцлагын явцад тодорхойгүй мэдээллийг олж авахын тулд нэмэлтээр зарим байгууллагууд (Хот байгуулалт, хотын стандартын газар, Туул голын сав газрын захиргаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар)-ын тухайн асуудлыг хариуцсан албан хаагчидтай холбогдож, уулзалт ярилцлага хийсэн.

Хүснэгт 2. Уулзалт хийсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын мэдээлэл

№	Албан тушаалтны нэр	Байгууллагын нэр	Хэлтэс, нэгж	Албан тушаал
2024.10.15				
1	Г.Нарантуяа	Хот, суурины ус хангамж, ариутгах	Тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газар	Газрын дарга

		татуургын ашиглалт, үйлчилгээг, зохицуулах хороо		
2	Л.Хишигдулам	Усны газар	Усны хяналт шинжилгээний хэлтэс	Хаягдал усны зөвшөөрөл, төлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн
3	П.Ганбаатар	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Хот, суурины ус хангамжийн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч
4	П.Мөнгөнтуул	Барилгын хөгжлийн төв	Барилга байгууламжийн зураг төсөл, магадлалын хэлтэс	Ахлах мэргэжилтэн
5	Б.Билгүүн	Туул голын сав газрын захиргаа	-	Дарга
6	Д.Уранчимэг		Үйлдвэр хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан	Ахлах мэргэжилтэн
2024.10.18				
7	Т.Давааням	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар	Ахлах шинжээч
8	С.Нямжав		Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс	Шинжээч
9	н.Өсөхбат	Хот байгуулалт, хотын стандартын газар	Барилга хот байгуулалтын хэлтэс	Хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн
2024.11.04				
10	Ж.Дагвасүрэн	Ус сувгийн удирдах газар	-	Ерөнхий инженер
11	Ц.Баянзул		Хэрэглэгчдэд үйлчлэх алба	Албаны дарга
12	Б.Урнаа		Инженерийн бодлогын хэлтэс	Усны аюулгүй байдал хариуцсан инженер
13	Д.Жавхлан			Бохир усны горим тооцооны инженер
14	н.Баясгалан	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Мэргэжилтэн
2024.11.05				
15	О.Цэндхүү	Нийслэлийн байгаль орчны газар	Удирдлага	Газрын дарга
16	Н.Наранцэцэг		Хяналтын хэлтэс	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
17	М.Батсайхан		Хяналтын хэлтэс	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
18	П.Даваатөмөр	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын ахлах байцаагч
19	н.Тэмүүлэн	Нийслэлийн хяналт шалгалтын газар	Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс	Ариутгах татуургын улсын хяналтын ахлах байцаагч

Зураг 22. Уулзалт, ярилцлагын үеийн фото зураг

		
Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг, зохицуулах хороо	Усны газар	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
		
Барилгын хөгжлийн төв	Туул голын сав газрын захиргаа	
		
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Хот байгуулалт, хотын стандартын газар	
		
Ус сувгийн удирдах газар		
		

Нийслэлийн байгаль орчны газар	Нийслэлийн эрүүл мэндийн газар
--------------------------------	--------------------------------

9. Үйл явц бүрийн хуулийн шаардлагыг холбогдох төрийн байгууллагуудын албан хаагчдаас ярилцлага авах замаар баталгаажуулсан байдал

Ярилцлагын судалгаагаар тодорхойлсон үйлдвэрлэлийн бохир үс, түүний заалттай холбоотой үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Ярилцлагын судалгааны үр дүн

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
Хот, суурин газрын үс хангамж, ариутгах татуургын тухай хууль (2011)				
1	Хот, суурины үс хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны Тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газрын дарга Г.Нарантуяа	Аж ахуйн нэгжид урьдчилан цэвэрлэх байгууламж ашиглах тусгай зөвшөөрөл (12-р зүйл)	- Бизнес эрхлэгчдэд ямар лиценз шаардлагатай вэ? - Аж ахуйн нэгжүүд хэзээ зөвшөөрөл авах ёстой вэ? - Тусгай зөвшөөрөл авахад урьдчилсан нөхцөл бий юу ? (тусгай зөвшөөрөл олгохоос өмнө шаардлагатай журам/зөвшөөрөл гэх мэт) - Өргөдөл гаргаснаас хойш зөвшөөрөл хэр хугацаа шаардагдах вэ?	- Үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллага нь урьдчилан цэвэрлэх байгууламжийг барьж, ашиглахад 12.2.9-11 дүгээр заалтуудаад тусгагдсан тусгай зөвшөөрлүүдийг авах эсвэл тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулах боломжтой. - Тусгай зөвшөөрлийг барилга байгууламжийг барьж ашиглалтад орсны дараа авна. - Тусгай зөвшөөрлийг “Тусгай зөвшөөрлийн цахим систем” болох www.license.mn вэбсайтаар нэвтэрч орж хүсэлтээ өгнө. - Тусгай зөвшөөрлийн авахад шаардагдах материалаас өөр нэмэлт шаардлага байхгүй. - Зөвшөөрлийн тухай хуулинд өргөдөл хүлээн авснаас хойш 10 хоногт хянан магадлах ёстой боловч “Хот, суурины үс хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо”-ны хурал 20-25 хоногт нэг удаа хуралдаж шийдвэр гаргадаг. Гэхдээ зарим тохиолдолд сард 2 удаа хуралддаг. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалаа “Хот, суурины үс хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо”-ны

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				“Түсгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газар”-ын мэргэжилтэнд үзүүлж хянуулах боломжтой.
		Ус ашиглах, бохир ус зайлуулах гэрээ (13.2-р зүйл)	Энэ гэрээ Усны тухай хуулийн 28.11-д заасан “Ус ашиглах гэрээ”-тэй ижил үү?	Хот, хөдөөгийн суурингийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.2-д заасан гэрээ нь Усаар хангагч байгууллагатай буюу Ус сувгийн удирдах газартай “Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ”-г хэлнэ. Энэ гэрээг хийснээр төвийн төвлөрсөн шугамаар цэвэр усаар хангагдах, бохир усаа зайлуулах юм. Усны тухай хуульд заасан “Ус ашиглах гэрээ” нь худгаас буюу байгалиас ус ашиглахтай холбоотой асуудал тул ялгаатай ойлголт юм. Ус ашиглах гэрээг Байгаль орчин, үүр амьсгалын өөрчлөлтийн яам болон Усны газартай холбоотой юм.
2	УСУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга – Ц.Баянзул , Инженерийн бодлогын хэлтсийн Усны аюулгүй байдал хариуцсан инженер – Б.Урнаа , Бохир усны горим тооцооны инженер- Д.Жавхлан	- Цэвэр усаар хангах бохир ус татан зайлуулах гэрээ (13.2-р зүйл) - Техникийн нөхцөл (11 дүгээр зүйл)	- Энэ гэрээ Усны тухай хуулийн 28.11-д заасан “Ус ашиглах гэрээ”-тэй ижил үү? - Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ ямар байгууллагатай хийх вэ? - Усаар хангагч байгууллага гэдэг нь ямар байгууллагуудыг хэлж байгаа вэ? - Усны тухай хуулийн 28.7-д Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах	“Ус ашиглах гэрээ” нь УСУГ-тай хийж байгаа гэрээнээс өөр юм. УСУГ нь “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” буюу аж ахуйн гэрээг хийдэг. Энэ гэрээ нь нь төвийн төвлөрсөн цэвэр, бохир усанд холбогдсон үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагатай хийдэг. Энэ гэрээгээр стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах үүргийн дагуу үйлчилгээний төлбөрийг авдаг. “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г 1 жилийн хугацаатай хийх ба хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө сунгах хүсэлтээ өгч, гэрээгээ дүгнэнэ. Гэхдээ гэрээг дүгнээд гэрээг цуцалж байсан байсан тохиолдол байхгүй. Манай зүгээс төлбөрөө хугацаандаа төлөөгүй, стандартаас давсан бохир ус шугамд

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
			зөвшөөрөл авна гэж заасан байна. Хангагч байгууллага нь Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай “ус ашиглах гэрээ” байгуулдаг үү? • Хангагч байгууллагатай байгуулах гэрээг аль үе шатанд хийх вэ? • Түс гэрээг хэдэн жилийн хугацаатай байгуулдаг вэ? Гэрээг хэзээ, хэрхэн дүгнэдэг вэ? • Хангагч байгууллагатай хийсэн гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахад бусад холбогдох төрийн байгууллагуудаас ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг гаргуулах, гэрээ байгуулах шаардлагатай эсэх? Мөн хаягдал усны дүгнэлт, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн авах шаардлагатай эсэх? • Техникийн нөхцөлийг аль үе шатанд авах вэ? /барилга угсралт, засвар үйлчилгээний ажлын өмнө, явцад, дараа нь гэх мэт/ • Техникийн нөхцөлийг авахад шаардлагатай баримт бичгийн жагсаалт бий юу?	нийлүүлж байвал усыг нь хаах л арга хэмжээ авдаг. • Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээр хангаж байгаа байгууллага буюу “Усаар хангагч байгууллага” нь УСУГ юм. Харин зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй, манай шугам сүлжээнээс салбарлан ус авч хэрэглэгчдэд түгээж байгаа, УСУГ-тай гэрээтэй Орон сууцны конторууд нь болохоор өөрсдийн хэрэглэгчдийн хувьд Усаар хангагч байгууллага юм. Улаанбаатар хотын хувьд үндсэн Усаар хангагч байгууллага гэдэг бол УСУГ юм. • Усны тухай хуулийн 28.7-д Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна гэж заасны дагуу жил бүр УСУГ нь “Усны газар”-аас “Ус ашиглуулах дүгнэлт” гаргуулж, “Туул голын сав газрын захиргаа”-аас “Ус ашиглах зөвшөөрөл” авдаг. Харин “Ус ашиглах гэрээ” байгуулдаггүй. • “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” тухайн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж байгууллага нь шугам сүлжээгээ угсарч бүх ажил дууссаны дараа буюу газар дээр нь хяналт, шалгалт хийж акт үйлдэж холболтын гэрээ байгуулан, улсын комисс хүлээн авсны дараа гэрээг байгуулна. • УСУГ нь техникийн нөхцөл олгох, далд ажлын акт гаргах, холболтын гэрээ хийсний дараа хамгийн сүүлд нь “Цэвэр усаар хангах,

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
			- Техникийн нөхцөл авах хүсэлтийг цаасан эсвэл цахим хэлбэрийн алинаар нь авдаг вэ? - Техникийн нөхцөл хүссэн өргөдөл ямар газар, хэлтэс, албан тушаалтанд очдог вэ? - Техникийн нөхцөлийн шийдвэр хэр хугацаанд гардаг вэ? - Шаардлага хангаагүй баримт бичгийн нөхөн бүрдүүлэлтийн талаар шууд мэдэгддэг үү эсвэл материал шалгах хугацаандаа зөвшөөрөл хүсэгчид өөр байдлаар мэдэгддэг үү?	хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г хийдэг. Бусад байгууллагууд ямар зөвшөөрөл, гэрээ шаарддаг талаар сайн мэдэхгүй байна. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрлийн талаар Усны газар, сав газрын захиргаанаас тодруулах хэрэгтэй. Усны газар Ус бохирдуулсны төлбөрийг татварын албатай хамтарч авдаг. - Техникийн нөхцөлийг ажил эхлэхээс өмнө зураг төсөл боловсруулах үе шатанд авна. - Техникийн нөхцөлийг авахад шаардлагатай баримт бичгийн жагсаалт нь 1.Шинээр барилга барих гэж байгаа, 2.Хуучин барилгын хувьд гэсэн ялгаатай байдаг. УСУГ-н www.usug.ub.gov.mn вэбсайтад бүрдүүлэх материалын жагсаалт нь байгаа. “Техникийн нөхцөл” хүссэн хэрэглэгч бүрдүүлсэн материалаа Нийслэлийнүйлчилгээний нэгдсэн төвүүд буюу Дүнжингарав, Мишээл экспо, Драгон, Сэлбэ төвүүдэд байрлах УСУГ-ын ажилтанд цаасаар буюу хэвлэмэл байдлаар, харин www.smartoffice.mn цахимаар илгээж болно. - Техникийн нөхцөл” хүссэн өргөдөл Инженерийн бодлогын хэлтэст хянагдах ба Техникийн нөхцөл олгох комисс батлагдсан хуваарийн дагуу 14 хоногт нэг удаа хуралдах бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг УСУГ-ын вебсайт: www.usug.ub.gov.mn мэдээлэл цэснээс, мөн Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар фэйсбүүк хуудасны чатбот холбоосоор орж харах боломжтой. - Хурлын шийдвэр гарсны дараа Газрын даргын 2024 оны 02-р сарын 29-ний өдрийн А/28 тоот дугаартай тушаалын хавсралтад

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				заасан үнэ тарифаар техникийн нөхцөл, болон сунгалтын төлбөрийг төлсний дараа анх хүсэлтээ өгсөн "Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн ажилтанд төлбөр төлсөн баримтаа үзүүлж, техникийн нөхцөл болон сунгалтыг авна.
Байгаль орчны сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А/719/189 дүгээр хамтарсан тушаал				
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Хишигдулам, Түүл голы сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн Д.Уранчимэг	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл	Зөвшөөрөл (өргөдлийг хянан үзэх) ямар яам өгөх вэ? (БОУАӨЯ/ХБОСЯ)	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг Сав газрын захиргаа болон харьяа дүүргийн Засаг дарга олгоно.
Барилгын тухай хууль (2016)				
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хот, суурины үс хангамжийн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч П.Ганбаатар	Цэвэрлэх байгууламжийг төлөвлөхөд тавигдах шаардлага (12.1.1 - 12.1.3-р зүйл)	- Эдгээр шаардлага нь урьдчилан цэвэрлэх байгууламжид хамаарах уу? Хэрэв тийм бол бизнесүүд яг юуг харуулах ёстой вэ? (Зөвхөн хуулийн эх бичвэрээс л ойлгоход бэрх). - Баримт бичиг, зураг төслийг аль байгууллага шалгах ёстой вэ? - Аж ахуйн нэгжүүд баримт бичиг/зураг төслийг хэзээ өгөх ёстой вэ? - Өргөдөл гаргах урьдчилсан нөхцөл бий юу ? (жишээ нь	- Барилгын зураг төслийг Барилгын тухай хуулийн 12.1.1-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх ёстой. - Урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төслийг “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр буюу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. - Зураг төслийн “Ажлын даалгавар”-г норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспортод үндэслэн боловсруулна.

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
			өргөдөл гаргахаас өмнө шаардлагатай журам/зөвшөөрөл) Өргөдөл гаргаснаас хойш зөвшөөрөл авахад хэр хугацаа шаардагдах вэ?	- Зураг төсөлд “Архитектур төлөвлөлтийн даалгавар”, “Эх зураг /эскиз зураг/”, “Ажлын зураг” хамаарна. - Зураг төслийг барилга байгууламж барихаас өмнө буюу төслийн хамгийн эхний үе шатанд хийлгэнэ. - Архитектур төлөвлөлтийн даалгаврын Улаанбаатар хотын ерөнхий архитектур батална. Хүсэлт хүлээн авснаас хойш 16 хоногийн хугацаанд шийдвэрлэж хариу өгнө. - Эх зургийг Хот байгуулалт, хотын стандарт газар батална. Хүсэлт хүлээн авснаас хойш 5 хоногийн хугацаанд шийдвэрлэж хариу өгнө. - Ажлын зургийг ХБОСЯ-ны харьяа Барилгын хөгжлийн төвд өгч Магадлалын дүгнэлт гаргуулна. Хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн хугацаанд шийдвэрлэж хариу өгнө.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2012)				
5	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар Т.Давааням	Хяналт тавих, тайлагнах бүртгэлийн систем (31-р зүйл)	- Бүртгэлийн систем гэж юу вэ? - БОУАӨЯ-ны аль нэгж бүртгэдэг вэ? - Аж ахуйн нэгжүүдэд тайлбар өгөх материал байна уу ?	- БОУАӨЯам экологийн паспорт хөтөлдөггүй. - Манайх бодлогын яам учраас бодлогоо барьдаг. Хэрэгжүүлдэг нь хэрэгжүүлэгч агентлаг буюу усны газар, сав газрын захиргаа хянаж байгаа. - Иргэн, аж ахуй нэгжтэй холбоотой мэдээлэл байвал гаргаж өгдөг. Тусгайлан хийдэггүй. Байгаль орчныг хамгаалах тухай хуультай холбоотой 2014, 2017 онд хийгдсэн тайлан байдаг. Асуулттай холбоотой судалсан нэмэлт хариулт: - Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.2-д “эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх” заасан

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж нь тус асуудлыг хариуцсан ажилтантай эсвэл байгаль орчин хариуцсан нэгжээр дамжуулан хяналтыг тавьдаг. Зарим үйлдвэрийн газрууд байгаль орчны мэргэжлийн байгууллагаар хяналтыг хэрэгжүүлүүлдэг. • Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.3-д “Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх;” гэж заасан нь тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ний өдрийн дотор, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 12-р сарын 31-ний өдрийн дотор хариуцсан мэргэжилтэн нь боловсруулан нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж ажлын хэсгээр дүгнэлт гаргуулан БОУАӨЯ-нд өгч хянаж батлуулна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны мэдээллийг төвийн https://eic.mn/envmng/login.php вэбсайтаар илгээнэ. • Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.6-д “Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөтлөх” гэж заасан боловч одоогоор мөрдөгдөж байгаа хүчин төгөлдөр журам байхгүй. Харин Байгаль орчны хамгааллын стандартын систем. “Аж ахуйн нэгжийн

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				экологийн паспорт” Үндсэн дүрэм MNS 4219:1994 стандартад Экологийн паспорт хөтлөх талаар тусгагдсан. - Аж ахуйн нэгжийн экологийн паспорт хөтөлсөн эсэхийг шалгах Засгийн газрын 1995 оны 209 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ”-ийг Засгийн газрын 2001 оны 153 дугаар тогтоолоор хүчингүйд тооцсон. - БОАЖ-н сайдын 2023 онд баталсан № 01.1.4 Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах, № 01.1.5 Төв болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шалгах хяналтын хуудаст “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 31.6 дах заалтын талаар тусгагдаагүй байна. - БОУАӨЯ-с “Экологийн паспорт” хөтөлсөн эсэхийг хянадаггүй.
		Дотоод хяналтын нэгж (31-р зүйл)	Энэ нэгжийг байгуулах, ажиллуулах нарийн дүрэм бий юу ? Хэрэв БОНБУ хийгээгүй бол энэ нэгж шаардлагатай юу?	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгж буюу байгаль орчин хариуцсан нэгжтэй байх ёстой. Үйлдвэрийн газрууд нь цар хүрээнээсээ хамаараад харилцан адилгүй байдаг. Жишээ нь байгаль орчин хариуцсан нэгжтэй байхад зарим нь зөвхөн байгаль орчин хариуцсан ажилтантай эсвэл бүр ажилтангүй ч байдаг.

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				- Дотоод хяналтын нэгж байгуулах тухай холбогдох хууль, дүрэм, журам байхгүй. ААНБ бүр өөрсдийн дотоод журмаараа зохицуулдаг байна. - Үйлдвэрийн газрууд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ажиллах ёстой.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)				
6	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн шинжээч С.Нямжав	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ (7, 8, 9, 10-р зүйл)	- БОНБУ шаардах ямар нэгэн шалгуур (жишээлбэл, бизнесийн төрөл, цар хүрээ) байна уу ? - Хэрэв одоо байгаа үйлдвэр нь урьдчилан цэвэрлэх байгууламжийг шинээр суурилуулсан бол (солих, өргөтгөх гэх мэт) үйлдвэр нь БОНБУ хийх шаардлагатай юу?	- Хөнгөн, хүнсний үйлдвэрийн төслүүд болох улсын чанартай том үйлдвэр, орон нутгийн чанартай жижиг, дунд үйлдвэр гэсэн жагсаалт байхгүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт заагдсан төслийн ангиллаар явдаг. Асуулттай холбоотой судалсан нэмэлт хариулт: - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллыг хуульчилсан байдаг. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллын 7 дугаарт: цэвэрлэх байгууламжийн асуудал тусгагдсан ба 10000-аас дээш хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгууламжийн төслийн үнэлгээг БОУАӨЯ, 10000-аас доош хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгууламжийн төслийн үнэлгээг нийслэлийн БОАЖГ хариуцан гүйцэтгэнэ гэж заасан. - Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх, нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай, татгалзах гэсэн 3 хариу гардаг. - Хүнс, хөнгөн гэх мэт бүх төрлийн үйлдвэрийн газрын төслийн “Байгаль орчны ерөнхий үнэлгээ”-ний дүгнэлтэд Байгаль орчны

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж гарсан байна. - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.4-д Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг дахин гаргуулна. - Байгаль орчны ерөнхий үнэлгээг дахин гаргуулсны үндсэн дээр Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг боловсруулна.
Усны тухай хууль				
7	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Хишигдулам, Туул голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн Д.Уранчимэг	Ус ашиглах гэрээ (28.11-р зүйл)	- Энэ гэрээ нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.2-т заасан “Цэвэр усаар хангах, бохир ус зайлуулах гэрээ”-тэй ижил үү? - Энэхүү гэрээнд "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл" (30.1-р зүйл) багтсан үү?	- Усны тухай хуулийн 28.11-д заасан “Ус ашиглах гэрээ”-г худаг болон гол, булаг шандаас ус ашиглах тохиолдолд, харин Хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 13.2-д заасан Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г төвлөрсөн шугамд холбогдсон тохиолдолд холбогдох байгууллагатай тус тус байгуулна. - Төвлөрсөн цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдсон иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь “Усаар хангагч байгууллага”-тай буюу “Ус сүвгийн удирдах газар”-тай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г байгуулна. - Харин газрын доорх ус буюу худгаас, мөн гол, булаг шандаас Ус ашиглах тохиолдолд хоногт 100 шоо метрээс их бол “Туул голын сав газрын захиргаа”-тай, хоногт 50-100 шоо метр бол “Нийслэлийн Байгаль орчны газар”-тай, хоногт 50 шоо метрээс доош бол харьяа

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				“Дүүргийн Засаг дарга”-тай “Ус ашиглах гэрээ”-г байгуулна. - Тухайн үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшил газар дээрээ худаг гарган ус ашигладаг бол “Ус ашиглах гэрээ”-г 1 жилийн хугацаатай байгуулах ба жил бүр ашиглах усны хэмжээнээсээ хамааран холбогдох байгууллагуудаар “Ус ашиглуулах дүгнэлт”-ээ гаргуулан гэрээг дахин байгуулна. - Жишээ нь Улаанбаатар хотод “АПУ” ХК төвийн төвлөрсөн шугам болон худгаас ус авч ашигладаг болохоор 2 гэрээг тус тусад нь байгуулдаг. “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г байгуулсан ч гэсэн үйлдвэрийн газрууд “Хаягдал усны дүгнэлт” гаргуулах шаардлагатай ба “Хаягдал ус хаях, зайлуулах” зөвшөөрлийг авна.
		Бохир ус зайлуулах, зайлуулах зөвшөөрөл (30.1-р зүйл)	- Өргөдлийн маягт байгаа юу? - Аж ахуйн нэгж хэзээ зөвшөөрөл авах ёстой вэ? - Зөвшөөрөл авахад урьдчилсан нөхцөл бий юу ? (жишээлбэл, зөвшөөрөл авахаас өмнө шаардлагатай журам/зөвшөөрөл) - Өргөдөл гаргаснаас хойш зөвшөөрөл авахад хэр хугацаа шаардагдах вэ? - Энэ зөвшөөрлийг “Ус ашиглах гэрээ”-нд (28.11-р зүйл) тусгасан уу?	- Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг авахын тулд Хаягдал усны дүгнэлтийг гаргуулах ёстой. - Хаягдал усны дүгнэлт гаргуулахад шаардагдах баримт бичгийн жагсаалт www.water.gov.mn вэбсайтад байгаа. “Хаягдал усны дүгнэлт”-ийг 50 шоо метрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид “Усны газар”-н www.ewater.mn вэбсайтаар, харин 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид Сав газрын захиргаанд цаасаар хүсэлтээ өгнө. “Хаягдал усны дүгнэлт”-ийг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ.

№	Б. Ярилцлага хийсэн албан хаагч	В. Хууль эрх зүйн шаардлага	Асуулт	Хариулт
				- Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоо метрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу “Усны газар”-ын хаягдал усны дүгнэлтийг үндэслэн “Сав газрын захиргаа”, хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид “Сав газрын захиргаа”-ны хаягдал усны дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг дарга олгоно. - Урьдчилан цэвэрлэх байгууламжтай болон байгууламжгүй үйлдвэрийн газар нь бохир усаа төвлөрсөн шугамд нийлүүлж байгаа бол “Хаягдал усны дүгнэлт”-ийг гаргуулан “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл”-ийг авна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012) Байгаль орчны сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал (2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/406/226)				
8	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Хишигдулам, Түүл голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн Д.Уранчимэг	Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ (4.2-р зүйл)	- Энэ гэрээ хэн, хэний хооронд байгаа юм бэ? - Өргөдлийн маягт байгаа юу? - Бизнес хэзээ гэрээ байгуулах ёстой вэ? - Гэрээ авах урьдчилсан нөхцөл бий юу? (жишээ нь гэрээг хэрэглэхээс өмнө шаардлагатай журам/зөвшөөрөл)	- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д заасны дагуу хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд буюу цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын асуудал хариуцсан байгууллага нь Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг даргатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулах ба хаягдал бохир усны шугам, сүлжээнд хаягдал бохир усаа нийлүүлж буй ус ашиглагчийн жагсаалт, хаягдал бохир усны хэмжээ, бохирдлын үзүүлэлт зэрэг мэдээллийг харьяалах татварын албанд гаргаж өгнө. Тус мэдээллийг үндэслэн татварын алба ус бохирдуулсны төлбөр төлөгчөөр бүртгэнэ. - Үйлдвэрлэл явуулж буй иргэн аж ахуй нэгж байгууллага нь хөрсөнд буюу байгальд нийлүүлэх тохиолдолд “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г байгуулна. Харин төвлөрсөн шугамд бохироо нийлүүлж байгаа тохиолдолд байгуулахгүй. - Гэрээ байгуулахад өргөдлийн маягт гэж байхгүй. - Гэрээг “Хаягдал усны дүгнэлт”, “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл” авсны дараа байгуулна. - Гэрээ байгуулах хүсэлтээ албан тоотоор өгөх ба албан тоотод “Хаягдал усны дүгнэлт”, “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл”, “Ус бохирдуулсны төлбөр төлсөн” баримт зэргийг хавсаргана. - Гэрээг барилга байгууламж барьж, ашиглалтад орсны дараа байгуулах шаардлагатай. “Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ” байгуулсан тохиолдолд “Ус

				бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г давхар байгуулах шаардлагагүй. Урьдчилан цэвэрлэх байгууламжтай, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг иргэн, ААН байгууллага нь төвлөрсөн шугамд бохироо нийлүүлж байгаа бол энэ гэрээг байгуулах шаардлагагүй.
		Мэдээлэл бэлтгэх, илгээх (4.4-р зүйл)	- Өргөдлийн маягт байгаа юу? - Бизнес хэзээ мэдээлэл өгөх ёстой вэ? - Мэдээлэл оруулах урьдчилсан нөхцөл бий юу ? (жишээ нь мэдээлэл өгөхөөс өмнө шаардлагатай журам/зөвшөөрөл)	Усаар хангагч байгууллага нь гэрээ байгуулсан иргэн аж ахуй нэгж байгууллагын мэдээллийг Татварын албанд өгч бүртгүүлнэ.
		Ус бохирдуулсны төлбөрийг тооцох үзүүлэлт (6.1-р зүйл)	- Хэрэв бизнес нь аналитик лабораторитой бол тухайн лабораторийн шинжилгээний үр дүнг ашиглаж болох уу? - Ус бохирдуулсны төлбөрийг тооцох хаягдал усанд дүн шинжилгээ хийх магадлан итгэмжлэгдсэн/зориулалтын лаборатори байдаг уу? (Итгэмжлэгдсэн/томилогдсон лабораториудын жагсаалтыг хуваалцана уу) - Бохир усны лабораторийн шинжилгээний үр дүнг тайлагнахдаа аж ахуйн нэгж лабораториос гаргасан баталгаажуулалтын баримт бичгийн хамт ирүүлэх шаардлагатай юу? Эсвэл бохирдуулагчийн утгыг мэдээлэх нь зүгээр үү?	- Бохир усны шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байх ёстой. - Итгэмжлэл авахдаа бохир усны чанарын ямар үзүүлэлт, ямар аргачлалаар шинжилгээ хийх боломжтой эсэхийг нягталж байж шинжилгээ хийлгэх шаардлагатай. Шаардлага хангахгүй бол хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг дахин хийлгэнэ. - Өрсөлдөөний тухай хуулиараа лабораторийн жагсаалт гаргаж, энэ лабораториор шинжилгээ хийлгэ гэж хэлж болохгүй. - Бохир усны лабораторийн шинжилгээний үр дүнг тайлагнахдаа шинжилгээний хариуг өгнө. - Ус бохирдуулсны төлбөрийг тооцохдоо бохир усны хэмжээ, чанарыг Усны газрын “Усны хяналт шинжилгээний хэлтэс” хянаж татварт мэдээлдэг.

			(Зөвхөн утгыг мэдээлэх нь зүгээр юм бол та хууран мэхлэхийг хэрхэн илрүүлэх вэ?) Ус бохирдуулсны төлбөрийг тооцохдоо бохир усны хэмжээ, чанарыг ямар нэгж хариуцах вэ?	
		Төлбөрөөс чөлөөлөх (8.1-р зүйл)	- Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт үзүүлэх тухай товхимол, танилцуулга материал байгаа бол бидэнтэй хуваалцаарай. - Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөлт, чөлөөлөх өргөдлийн маягт бий юу? - Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт үзүүлэх урьдчилсан нөхцөл бий юу ? (жишээлбэл, өргөдөл гаргахаас өмнө шаардлагатай журам/зөвшөөрөл)	- Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт үзүүлэх тухай товхимол, танилцуулга материал байхгүй. - Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөлт, чөлөөлөх тусгайлсан өргөдлийн маягт гэж байхгүй. “Хаягдал усны дүгнэлт” гаргах үед стандартад нийцэж буй эсэхийг хянаж үзэн ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийднэ. - Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3 заалтын дагуу чөлөөлнө.

10. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг барих, ашиглах үйл явцын замын зураг болон үйл явц бүрийн нарийвчилсан схем

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх (ҮХУУЦ) төлөвлөгөөнд үйлдвэр бүр хаягдал усны цэвэрлэгээний түвшнийг тодорхойлж, тохирох цэвэрлэх байгууламжаа сууриллуулах шаардлагыг тавьсан байдаг. Мөн үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх, технологийн хэрэглээндээ эргүүлэн ашиглана */Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, 18.5 заалт/* гэж заасан байдаг. Эдгээр эрхзүйн баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулах, үүргээ биелүүлэхэд нь энэхүү судалгааны тайланд тусгагдсан замын зураг, тайлбар бичиглэл дөхөм болно гэдэгт итгэлтэй байна.

7.1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, батлуулах үйл явц

Урьдчилан цэвэрлэх байгууламж барих, ашиглах этгээд нь дараах үе шатыг дамжин зураг төсөл боловсруулах, хянуулах, батлуулах, барилгын ажлыг эхлүүлэх, улсын коммист хүлээлгэн өгөх, барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

1. Архитектур төлөвлөлтийн даалгавар

Төсөл хэрэгжүүлэгч нь урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулахын өмнө нэн түрүүнд Архитектур төлөвлөлтийн даалгавар (А даалгавар) авна. Архитектур төлөвлөлтийн даалгавар нь Нийслэлийн ерөнхий архитектороос ерөнхий төлөвлөгөөтэй үялдуулан даалгавар гаргаж өгдөг ба уг даалгаварт барилгын байршил, давхрын өндөр, барилгын суурийн хэмжээ, барилгын зориулалт гэх мэт мэдээллийг тусгасан баримт бичиг гэж ойлгоно.

Иргэн, хуулийн этгээд барилга барих хүсэлтээ Нийслэлийн иргэдийг хүлээн авах төвөөр дамжуулан нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагад гаргана.

Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам, 3.3 заалт

Барилга байгууламжийн барих газарт архитектур төлөвлөлтийн даалгавар авах хүсэлтийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Хот байгуулалт, хотын стандартын газар болон E-mongolia.mn цахим системээр нэвтэрч тус тус өгөх боломжтой байна.



А даалгавар авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

1. Маягт бөглөх
2. Иргэний үнэмлэх/байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
3. Өргөдөл/албан бичиг
4. Газрын эрхийн гэрчилгээ
5. Газрын кадастрын зураг
6. Газрын гэрээ
7. Газрын одоогийн байдлын фото зураг
8. Газрын гэрээ дүгнэсэн акт

Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам, 3.4 заалт

№	Бүрдүүлэх материал	Хяналт бүрдүүлэх	Тайлбар	Хуудас
1	Иргэний үнэмлэх	Хүсэлт гаргагч	Хүснэгт	
2	Иргэний аргачлал	Хүсэлт гаргагч	Эх хуви	
3	Хувины эзэмшдэгчдийн дэглэм	Хүсэлт гаргагч	Эх хуви	
4	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Хүсэлт гаргагч	Хүснэгт	
5	Газрын эрхийн гэрчилгээ	Нийслэлийн Газрын адба хүсэлт гаргагч	Хүснэгт	
6	Газрын кадастрын зураг	Нийслэлийн Газрын адба хүсэлт гаргагч	Хүснэгт	
7	Газрын гэрээ	Хүсэлт гаргагч	Хүснэгт	
8	Газрын одоогийн байдлын фото зураг	Хүсэлт гаргагч	Хүснэгт	14 хувины байдал
9	Газрын гэрээ дүгнэсэн акт	Нийслэлийн Газрын адба, Нийслэлийн Хамгаалалтын тус хүсэлт гаргагч	Эх хуви	

Хүсэлт хүлээн авсан
Огноо: 2022 оны ... сарын ... өдөр
Нутаг захирал: _____
Хамгаалалтын ажилтан: _____

А даалгавар авахад шаардлагатай баримт бичгийн бүрдлийг ханган тусгай маягтын дагуу хүсэлтээ бөглөж өгнө. Хүсэлт гаргагчийн баримт бичгийн бүрдлийг хянан үзээд шаардлага хангаагүй бол ажлын 7 хоногт албан бичгээр хариуг өгнө, шаардлага хангасан бол хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн тохиолдолд А даалгаврыг ажлын 2 хоногт багтаан баталгаажуулж хүсэлт гаргагчид өгөх ба хүсэлт гаргагч нь Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвөөс баталгаажсан даалгаврыг хүлээн авах боломжтой. Архитектур төлөвлөлтийн даалгавар авахад шаардагдах нийт хугацаа 16 хоног байна.

Ерөнхий төлөвлөгөө, газрын зориулалт, барилгын норм, дүрмийг хангахгүй байгаа зэрэг тодорхой шалтгаанаар барилга барих хүсэлтийг хүлээн авах боломжгүй тохиолдолд нийслэлийн барилгын асуудал эрхэлсэн байгууллагаас үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргагчид ажлын 7 хоногт багтаан албан бичгээр хариу өгнө.

Барилга барих хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн шийдвэрийг үндэслэн “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-ыг ажлын 2 хоногт багтаан Улаанбаатар хотын Ерөнхий архитектороор баталгаажуулж, түүнийг хүсэлт гаргагчид өгнө.

Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам, 3.5, 3.6 заалт

2. Зургийн /ажлын/ даалгавар

Төсөл хэрэгжүүлэгч болон зураг төслийн мэргэжлийн байгууллага хамтран тухайн барилга байгууламжийн зориулалт, цэвэрлэгээний хүчин чадал, технологи, барилга бүтээцийн төрөл, инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр гэх мэтийг зургийн даалгаварт тусгана.

3. Зураг төсөл боловсруулах гэрээ

Барилгын ажлын зураг төслийг хуульд заасны дагуу зайлшгүй мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шаардлагатай. Иймд төсөл хэрэгжүүлэгч болон зураг төслийн мэргэжлийн байгууллага нь барилгын зураг төслийн жишиг үнийг баримтлан “Зураг төсөл боловсруулах гэрээ”-г байгуулж ажлыг эхлүүлнэ.

Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай “Зураг төсөл боловсруулах гэрээ”-г барилгын зураг төслийн жишиг үнийг баримтлан байгуулж, ажлыг эхлүүлнэ;
Зөвшөөрлийн тухай хууль, 3.1

Монгол Улсын эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан байх;

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм, 4.5.1

4. Загвар зураг

Загвар зураг нь барилгын байршил, ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, барилгын фасад, өнгөний шийдэл гэх мэтийг агуулсан ерөнхий зураг юм.

Барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон баримт бичиг

Барилгын тухай хууль, 4.1.27

Нийслэлийн Засаг дарга нь Барилгын тухай хуулинд барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах эрхтэй гэж тусгагдсан ба барилга байгууламжийн байршил, загвар зургийг баталгаажуулах эсэх асуудлыг ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

23.1.Барилга байгууламжийн байршил, загвар зургийг баталгаажуулах эсэх асуудлыг энэ хуулийн 35.1.3-т заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

Барилгын тухай хууль, 23.1

35.1.3.барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих;

Барилгын тухай хууль, 35.1.3

Барилга байгууламжийн байршил, загвар зураг баталгаажснаар эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулах боломж бүрдэнэ. Бодит нөхцөл байдал дээр загвар зургийн үе шатыг эх загвар зураг /эскиз/-тэй нэгтгэж хийж байна.

5. Дэвсгэр зураг, геодезийн судалгаа

Барилга баригдах газрын геодезийн судалгаа буюу газрын налуу, өндөр, координат, хэвгий, одоо байгаа зам, барилга, шугам сүлжээ гэх мэт зүйлүүдийн судалгааг хийж ерөнхий төлөвлөгөө, барилгын орц, зүг чиг, гадна шугамуудын зураг төсөл хийхэд ашиглана. Геодези, зураг зүйн ажлыг Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай. Геодезийн зураглалд магадлал хийснээр баталгаажна.

Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ. Геодезийн зураглалд магадлал хийлгэсэнээр баталгаажна

Барилгын тухай хууль, 25.1, 25.2

6. Инженер хайгуулын судалгаа

Инженер геологийн дүгнэлтийг барилгын суурь, бүтээц, гадна шугам сүлжээний зураг төсөл хийхэд ашиглана. Инженер геологийн судалгаагаар тухайн газрын хөрсний шилжилгээ, газар хөдлөлийн балл зэргийг тодорхойлох судалгаа юм. Төсөл хэрэгжүүлэгч нь инженер-геологийн судалгааны ажлын даалгаврыг зураг төсөл зохиогчтой хамтран боловсруулах бөгөөд инженер-геологийн дүгнэлт гаргах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ. Инженер геологийн дүгнэлтийг магадлал хийлгэсэнээр баталгаажна.

Барилгын ажил гүйцэтгэхээс өмнө тухайн газрын инженер-геологи, геотехник, гидрогеологи, газар хөдлөлт, байгаль, ус цаг уурын нөхцөл, газрын төлөв байдал, орчны архитектур төлөвлөлт, тохижилт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээгээр хангах боломжийг тогтоох мэргэжлийн үйл ажиллагаа

Барилгын тухай хууль, 4.1.34

7. Эскиз /эх зураг/

Архитектур төлөвлөлтийн даалгавар, зургийн даалгаврын шаардлага хангасан эскиз зургийг боловсруулж Нийслэлийн ерөнхий архитектороос зөвшөөрөл авна. Мөн дулаан, цахилгаан, усны хэрэглээ буюу ачааллыг тооцож техникийн нөхцөл авахад бэлдэнэ. Ажлын 5 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

Инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулсан барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тохижилт, гудамжны дэлгээсүүд, орчны барилгуудтай уялдсан байдал, эзлэхүүн төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн ерөнхий шийдэл, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, нарны тусгал, барилгын давхрын байгуулалт, огтлол, нүүр тал /фасад/, архитектур, өнгөний шийдэл, үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичиг

Барилгын тухай хууль, 4.1.43

8. Техникийн нөхцөл

Техникийн нөхцөл гэдэг нь барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргасан шийдвэр юм.

Техникийн нөхцөлийг хангагч болон холбогдох эрх бүхий байгууллагын төлөөлөл бүхий техникийн комисс олгоно.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны 84 тогтоол, 1.2

Эскиз зурагт тооцсон ачааллын дагуу ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөлийг Ус сувгийн удирдах газраас авах ба шинээр барилга барих болон хуучин барилгын хувьд техникийн нөхцөл гаргахад бүрдүүлэх баримт бичгийн хувьд ялгаатай.

 Техникийн нөхцөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт /шинээр барилга барих/	 Техникийн нөхцөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт /хуучин барилга/
1. Иргэн бол өргөдөл, иргэний үнэмлэх	1. Иргэн бол өргөдөл, иргэний үнэмлэх
2. Аж ахуйн нэгж бол албан бичиг	2. Аж ахуйн нэгж бол албан бичиг
3. Газрын гэрчилгээ, кадастрын зураг /эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ бол гэрээний хамт/	3. Газрын гэрчилгээ, кадастрын зураг /эзэмших, ашиглах гэрчилгээ бол гэрээний хамт/
4. Архитектур төлөвлөлтийн даалгавар, хавсралтын хамт	4. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ
5. Барилгын эскиз зураг /ХБХСГ-аас батлагдсан загвар зургийн нүүр, ерөнхий төлөвлөгөө, харагдах байдал-3 хуудас/	5. Усны хэрэглээний тооцоо, м³/хоног-оор
6. Дулааны техникийн нөхцөл /Шаардлагатай тохиолдолд/	
7. ОСНААУГ-ын техникийн тодруулга /Тухайн барилга нь орон сууцны хороолол дотор байрлалтай бол/	
8. Нэмэлт баримт-Баригдах барилгын усны хэрэглээг м³/хоног-оор тооцож тусгах, орон сууцны барилга бол айлын тоог бичих, мөн холбогдох гар утасны дугаар зэргийг албан бичиг болон өргөдөлд бичсэн байх	

www.usug.ub.gov.mn

Техникийн нөхцөл гаргуулах хүсэлтээ Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд болон төрийн үйлчилгээний цахим системээр өгөх боломжтой. Хүсэлт гаргагчийн материалын бүрдэл хангалтгүй тохиолдолд албан бичгээр хариуг нь өгдөг байна.

Техникийн нөхцөл олгох комисс батлагдсан хуваарийн дагуу 14 хоногт нэг удаа хуралдах бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг Ус сувгийн удирдах газрын вебсайт www.usug.ub.gov.mn мэдээлэл цэснээс, мөн Ус сувгийн удирдах газар фэйсбүүк хуудасны чатбот холбоосоор орж харах боломжтой. Хурлын шийдвэрийн дагуу техникийн нөхцөл болон албан бичгийг бичиж батлуулан Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд хүргүүлдэг.

Хурлын шийдвэр гарсны дараа Ус сувгийн удирдах газрын даргын 2024 оны 02-р сарын 29-ний өдрийн А/28 тоот дугаартай тушаалын хавсралтад заасан үнэ тарифаар техникийн нөхцөл, болон

сунгалтын төлбөрийг төлсний дараа анх хүсэлтээ өгсөн "Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн ажилтанд төлбөр төлсөн баримтаа үзүүлж, техникийн нөхцөл болон сунгалтыг авна. Техникийн нөхцөл болон сунгалтын төлбөрийг анх бичиг баримтаа бүрдүүлэн өгөхдөө комиссын хурлаар хэлэлцээгүй байхад урьдчилан төлж болохгүй.

№	Холболт хийх шугам	Үнэ, төг
1	Шинээр техникийн нөхцөл олгох (усны хэрэглээ 100 м ³ /хон хүртэлх)	165000
2	Шинээр техникийн нөхцөл олгох (усны хэрэглээ 100 м ³ /хон-оос дээш бол)	330000
3	Олгогдсон техникийн нөхцөлийн хугацааг нэг жилээр нэг удаа сунгах (усны хэрэглээ 100 м ³ /хон хүртэлх)	82500
4	Олгогдсон техникийн нөхцөлийн хугацааг нэг жилээр нэг удаа сунгах (усны хэрэглээ 100 м ³ /хон-оос дээш бол)	165000

Ус сүвгийн удирдах газраас техникийн нөхцөл цаасаар олгогдож байгаа бөгөөд хүчинтэй хугацаа 2 жилээр гарна. Хугацаа дууссан тохиолдолд 1 жилээр сунгах боломжтой. Хэрвээ сунгалтын хугацаа дууссан тохиолдолд материалаа дахин шинээр бүрдүүлж техникийн нөхцөл гаргуулна.

9. Зураг төсөл

Эскиз зургийг үндэслэн архитекторууд барилгын үндсэн зураг төслийг хийнэ. Архитектурын зургийн төлөвлөлтийн үндсэн хэсэг дууссаны дараа хоршиж ажилладаг барилга бүтээц, халаалт-агаар сэлгэлт, цэвэр бохир ус, цахилгааны инженерүүдэд даалгавар өгч ажлыг эхлүүлдэг. Хэсэг бүрийн инженерүүдийг зургаа хийж дууссаны дараа архитектор бүх төлөвлөлтүүдийг нэгтгэж барилгын зургаа эцэслэнэ. Барилгын болон гадна шугмуудын зураг төсөл бүрэн дууссаны дараа тухайн барилга баригдахад шаардлагатай төсөвт өртгийг тодорхойлдог.

Барилгын тухай хуулийн 10.1.5 -д заасан ангилалын болон цогцолбороор баригдах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг "техникийн зураг", "ажлын зураг" гэсэн хоёр үе шатаар хийх бол барилга байгууламжийн төвөгшлөөр барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж, бага төвөгшилтэй барилга байгууламж, дүнд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг "ажлын зураг" гэсэн нэг үе шатаар боловсруулна.

Барилгын тухай хууль, 23.3.1, 23.3.2

10. Зураг төсөл зөвшилцөх

Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу барилга байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлагыг хангуулах, инженер хайгуулын судалгаа хийх, зураг төслийг үе шатны дагуу боловсруулах, зөвшилцөх, батлах, магадлал хийх, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг. Эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зургийг дараах байгууллагаар хянуулж, зөвшилцөх шаардлагатай байна.

1. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гал түймэртэй тэмцэх нэгж;
2. Мэргэжлийн хяналтын байгууллагын эрүүл ахуйн хяналт хариуцсан нэгж;

3. Инженерийн хангамжийн байгууллага;
4. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж (шаардлагатай тохиолдолд).

Эдгээр байгууллагын эрх бүхий албан тушаалтан эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зургийг хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан нөхцөлд гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна. Ажлын цар хүрээ, хэмжээнээс хамаарч дээрх хугацааг нэг удаа сунгаж болно. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гал түймэртэй тэмцэх нэгж, Мэргэжлийн хяналтын байгууллагын эрүүл ахуйн хяналт хариуцсан нэгж нь зураг төслийн холбогдох хэсгийг хянаж, зөвшилцөхөд галын аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргана.

11. Магадлал буюу экспертиз

Зураг төсөл зохиогч нь Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын захирлын 2019 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ажлын зураг төсөлд тавигдах шаардлага, иж бүрдлийг хангуулах шалгах хуудас”-ны дагуу магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг ханган материалаа цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Барилга байгууламжийн зураг төсөл, технологи, өргөх байгууламжийн сонголт, хот болон архитектур төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бэхийн шийдэл барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлага, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагаа

Барилгын тухай хууль, 4.1.16

Тухайн барилгын зураг төслийг хэсэг бүрийн екпертүүд¹ хөндлөнгийн хяналт, шалгалт хийж ерөнхий дүгнэлт гаргах ба ингэсэнээр барилгын ажлын зургийн боловсруулах хэсэг дуусна.

Магадлалын дүгнэлт татгалзсан, зөвшөөрсөн гэсэн хоёр хэлбэртэй байна. Магадлалын татгалзсан дүгнэлт барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл болно. Магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглодог байна. Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ.

12. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам эсвэл нийслэлийн байгаль орчны газарт хандан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах бөгөөд дараах материалыг бүрдүүлж e-business.mn цахим системээр хүсэлтээ илгээнэ.

¹ Барилга байгууламжийн зураг төсөлд хийх магадлалыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 34.1.10-т заасны дагуу эрх олгосон иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ /Барилгын тухай хууль, 39.1 /.



**Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахад
шаардлагатай материалын жагсаалт**

1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл
3. Зураг төсөл
4. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тайлан
5. Тухайн дүүргийн Засаг даргын санал
6. Бусад баримт бичиг /газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг/

<https://e-business.mn/category/service/baiqali-orchny-nuluulliin-erunkhii-unelgeenii-dugneit>

Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дүгнэлт гаргадаг ба шаардлагатай тохиолдолд 1 удаа сунгаж болдог. Ерөнхий үнэлгээний дүгнэлт нь төслийн цар хүрээ, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамаарч 3 төрөл гардаг.

1. Техник, технологи, үйл ажиллагаа нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, стратегийн үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах;
2. Төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;
3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэх;

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 7.4

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжид хамаарах тохиолдолд мэргэжлийн байгууллагаар түс ажлыг гүйцэтгүүлнэ. Энэхүү үнэлгээ нь барилгын ажлын зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийн жагсаалтад хамаардаг байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ба нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 8.2, 8.6

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж нь ерөнхий үнэлгээнд заасан хугацаанд үнэлгээний ажлын тайланг боловсруулж, хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, албан ёсны санал, тэмдэглэлийг авч үнэлгээний тайланд хавсарган, холбогдох бусад бичиг баримтын хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ. Байгаль орчны

нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, төсөл хэрэгжих хорооны иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага нь батлагдсан үнэлгээний тайлан, төлөвлөгөөг www.eic.mn цахим сайтад байршуулснаар энэхүү ажил дуусгавар болно.

13. Барилгын ажлын зөвшөөрөл

Барилга байгууламжийн зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулсны дараа барилгын ажил гүйцэтгэх зөвшөөрөл авна. Тус зөвшөөрөл нь 3 төрлөөр олгогддог байна.

- Барилга байгууламжийг шинээр барих;
- Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих;
- Барилга байгууламжийг буулгах.

Онцгой төвөгшилтэй барилга байгууламж болон Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Бусад төрлийн барилга байгууламжийн зөвшөөрлийг нийслэлийн Засаг дарга олгоно.



Барилгын ажлын зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

1. Барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр;
2. Барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт;
3. Зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн болон түсгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
4. Байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан;
5. Гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан бол гэрчилгээг хавсаргах.
6. Зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн түсгай зөвшөөрөл
7. Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө

Барилгын тухай хууль, 28.2, 28.3, 28.4

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3-т барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх энгийн зөвшөөрлийг нийслэлийн Засаг дарга олгох ба энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгодог байна. Барилгын ажлын зөвшөөрөл авсаны дараа батлагдсан зураг төслийн дагуу ажлыг эхлүүлнэ.

Барилгын ажил гүйцэтгэгч нь зураг төсөл, стандарт, техникийн нөхцөлийн дагуу барилга байгууламжийг барих, барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлийг хөтлөх, барилгын ил, далд ажлын актыг баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.

14. Далд ажлын акт, холболтын гэрээ

Барилга байгууламжийн угсралтын ажлын үед УСУГ-аас олгосон техникийн нөхцлийн дагуу цэвэр, бохир усны шугамын угсралт, шавхалт туршилт, холболтын ажлын явцад УСУГ-ын хяналтын инженерийг байлцуулж, “Ил, далд ажлын акт” хөтөлнө. Үүний дараа гүйцэтгэлийн зураг хийлгэж, мэдээллийн санд оруулна. Шинээр ашиглалтад орж байгаа хэрэглэгчид цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдохдоо УСУГ-тай “Холболтын гэрээ” байгуулна. Гэрээ байгуулах хугацаа жил бүрийн 05 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 01-ний хооронд явагддаг байна.



Холболтын гэрээ байгуулахад бүрдүүлэх материалын жагсаалт

1. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байх
2. Цэвэр, бохир усанд холбогдох техникийн нөхцөл
3. Гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлын зургийг хянуулж баталгаажуулсан байх
4. Гадна цэвэр, бохир усны шугамын угсралтын явцад далд ажлын акт хөтөлж хяналт тавьсан инженерээр гарын үсэг зурүүлсан байх
5. Гүйцэтгэлийн зураг хийлгэж хотын мэдээллийн санд оруулсан байх /CD-нд бүүлгаж 1 хувь өгөх/
6. Шугам угаалга дүүргэлтийн төлбөр төлсөн байх
7. Урьдчилгаа төлбөр төлөх

<https://usug.ub.gov.mn/mn>

15. Барилга байгууламж ашиглалтад оруулах

Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан нийслэлийн Засаг даргад барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ.



Барилга байгууламж ашиглалтад оруулахад бүрдүүлэх материалын жагсаалт

1. Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл
2. Барилгын ажлын ил, далд ажлын акт
3. Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт
4. Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт
5. Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн эсхүл өөр эх үүсвэр ашигласныг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл
6. Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл
7. Тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт

Барилгын тухай хууль, 48.5

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай хүсэлт, баримт бичгийг хянаж, ажлын 10 өдрийн дотор ашиглалтад оруулах комисс ажиллуулах ба комиссын дүгнэлтийг үндэслэж, ажлын 7 өдрийн дотор ашиглалтын гэрчилгээ олгоно.

Барилгын тухай хууль, 48.6, 49.1

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж, урьдчилсан дүгнэлт гаргах үүрэг бүхий техникийн комисс нь барилгын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай инженерийн хангамжийн шугам сүлжээний туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдал, барилгын инженерийн хангамжийн эх үүсвэр, түүний дагалдах сүлжээ, туслах барилга байгууламжийн найдвартай байдал, барилгын зориулалтаас хамаарсан технологи, дамжлага түүний тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, тохирлын гэрчилгээ, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг дүгнэдэг.

Захиалагч, гүйцэтгэгч талууд комиссын үед илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;
- Энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, 8.2

Комиссын дарга барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүгнэлт гаргаж, баталгаажуулсан бол ажлын 5 өдөрт багтаан нийслэлийн Засаг даргад хүргүүлж, ашиглалтад оруулна. Нийслэлийн Засаг дарга нь тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш ажлын 10 өдөрт багтаан мэдээллийг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

7.2. Гэрээ, дүгнэлт, зөвшөөрөл авах үйл явц

16. Төвлөрсөн шугамаас цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ

Нийслэл хувьд усаар хангагч байгууллага нь Ус сүвгийн удирдах газар юм. Хангагч байгууллага нь Зохицуулах хорооны баталсан аж ахуйн харилцааны дүрмийн дагуу хэрэглэгчтэй гэрээ байгуулдаг.

Тус гэрээнд нийлүүлэх цэвэр ус болон татан зайлуулах бохир усны хэмжээ, чанар, найрлага, гэрээг дүгнэх хугацаа, төлбөр тооцооны арга, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хохирол тооцох журам болон шаардлагатай бусад зүйлийг тусгана.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, 13.3

Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ болон усны тоолуурын заалтыг үндэслэн тооцно. Усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн үнд, ахуйн ус, хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг байгаль орчин, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн тодорхойлдог байна.

Ус сувгийн удирдах газраас энэхүү гэрээг түр болон байнгын хэлбэрээр байгуулдаг ба гэрээ байгуулахаар бол гэрээний маягтыг бөглөж, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвүүд эсвэл УСУГ-ын төв байранд өгнө.

 Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ байгуулахад бүрдүүлэх материал /иргэн/	 Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ байгуулахад бүрдүүлэх материал /аж ахуй нэгж/
1. Цахим үнэмлэх 2. Газар эзэмших гэрчилгээ 3. Цэвэр, бохир усны шугамын гүйцэтгэлийн зураг CD-ний хамт /шинэ хэрэглэгч/ 4. Батлагдсан зураг, схемийн дагуу тоолуурын узель угсарч, баталгаажуулсан тоолуур суурилуулах 5. Шугам угаалга дүүргэлт, огтолгооны хөлс төлөх 6. Урьдчилсан төлөлт хийх /иргэн 50,000 төгрөг/ 7. Гэрээний маягтыг бөглөх https://usug.ub.gov.mn/content/files/2019-01-29/1548751638-305985050.pdf	1. Гэрээ хийх нэг загварын маягтыг бөглөсөн байх 2. Цэвэр бохир усны шугамын гүйцэтгэлийн зураг CD-ний хамт /шинэ хэрэглэгч/ 3. Газар эзэмших гэрчилгээ 4. Байгууллагын болон НӨАТ төлөгчийн гэрчилгээ 5. Шугам угаалга дүүргэлт, огтолгооны хөлс төлөх /шинэ хэрэглэгч/ 6. Урьдчилсан төлөлт хийх /иргэн 150,000 төгрөг/ 7. Гэрээний маягтыг бөглөх https://usug.ub.gov.mn/content/files/2019-01-29/1548751638-305985050.pdf

Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах түр гэрээг улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг, барилга угсралтын ажлын үед үнд ахуйн ус авах иргэн, аж ахуй нэгжтэй байгуулдаг бол байнгын гэрээг техникийн нөхцөл олгох комиссын шийдвэрээр төвлөрсөн шугам сүлжээнд холбох эрхээ авсан, шаардлага бүрэн хангасан хэрэглэгчтэй байгуулдаг байна. Энэ гэрээг 1 жилийн хугацаатай байгуулдаг ба гэрээнд заасны дагуу сар бүр төлбөрөө төлөх шаардлагатай байна.

17. Зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл

Урьдчилан цэвэрлэх цэвэрлэх байгууламж барьж байгуулж, ашиглах зөвшөөрөл авсан этгээд нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооноос дараах тусгай зөвшөөрлүүдийг авна.

- Бохир ус татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ
- Ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, 12.1

Хэрэв материалын бүрдэл хангагдаагүй тохиолдолд Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооноос цахимаар энэ талаарх мэдээллийг хүргэдэг. Шинээр зөвшөөрөл авахад тэмдэгтийн хураамж 400,000 төгрөг төлдөг бол сунгуулахад хураамж төлдөггүй байна.

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал <https://www.water.wsrc.mn/mn/license-documents>

1. Байгууллагын ерөнхий танилцуулга маягт 1
2. Орон тооны бүтцийн схем маягт 2
3. Удирдах болон ИТА-уудын товч тодорхойлолт маягт 3
4. Усны алдагдал тооцох хүснэгт бөглөх /Орон нутгийн болон орон сууцны ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйчилгээний байгууллагууд бөглөнө./
5. Үйл ажиллагааны чиглэл түс бүрээр:

12.2.9 Боир уус татан зайлуулах шугам сүхсийн ашигтлаг, засвар, үйлчилгэйн чиглэлээр:		12.2.10 Боир уус цэвэрлэх байгууламжийн ашигтлаг, засвар, үйлчилгэйн чиглэлээр:		12.2.11 Уус хангамж, өрцөгт татгуурын төгсгөлөөр түршигт, тусгааруу хий үйлчилгэйн чиглэлээр:	
Хүснэгт 12. Боир уус татан зайлуулах нийт шугамын судалгаа		1. Энэ чиглэлийн үйл ажиллагаа доторхуй тайлбарыг бичлээс гарцаа цэвэрлэсэн боир уус шинжилгээ мэдэгдэн өгөгдсөөрөө иргэдийн байгууллага хийлээс хамтарсан дүг, тууд хийсн дэлгэмт хягт суурийн байр байдал хавсаргах, 2. Боир уус цэвэрлэх байгууламж, цэвэрлэгэйн төлөвлөгөө татан боловцуу, моддодой мэдээллийг, 3. Боир уус цэвэрлэх байгууллагын төлөвлөгөө систем, байгууламж гарга болон бусад холбогдох зурванд хавсаргах, 4. Хавсаргуулахууд арга, тууд хягтлаг буй тогт төлөвлөгөөн танилцуула, 5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, зардлагын 3.7.3.1 заасан "Боир уусад нхмт хийг дотодын лабораторийн байр, лабораторийн төлөвлөгөө керэглэлийн байгууламж хягтмн ажилд гэрээ байгуулах байгаа" гэсэн заалтыг хавсаргах нхмтл баригт, тайлбар, танилцуулгыг оруулах.		1. Энэ чиглэлийн үйл ажиллагаа доторхуй тайлбар, бусад тусгай ажлаархуйн тасар моддод, байгууламжийн гарцаа тусгааруу ажилд татан доторхуй моддод, барилцуулах гарцаа зурвиг хавсаргах, 2. Цэвэрлэх нхмтл төлөвлөгөө нхмт, байгууламж гэрээ хавсаргах, 3. Цэвэр боир уус болонхуудын, цэвэрлэх байгууламж гарцаа болон тусгай байгууламж татан ашигтлаг, засвар, түршиг татгууламж татан доторхуй моддодой мэдээллийг оруулах, зурга хавсаргах, 4. Уус шинжилгээ мэдэгдэн өгөгдсөөрөө иргэдийн байгууллага хийлээс хамтарсан дүг, тууд хийсн дэлгэмт хягт суурийн байр байдал хавсаргах, 5. Үйл ажиллагаанд ашигтай буй тогт төлөвлөгөөн танилцуулах, фото зурга, тайлбарыг хавсаргах, 6. Ажил түршигт гэрээ түршигт татгууламж хийг буй баригт, байгууламж татан зурвиг хавсаргах, 7. ХАБАН-н хуудас, ажилууд ажиллагаа моддод болон үйл ажиллагаанд оролцогчид бичлээс оролцон, тогт төлөвлөгөөн зурвиг тайлбарыг хягт хавсаргах.	
Хүснэгт 14. Цэвэрлэх байгууламжийн судалгаа		Хүснэгт 15. Боир уус шинжилгээ /Шинжилгээний бичлэг хягт хавсаргах/		Хийг, гүйдлээс ажил, үйлчилгээ түршигт, татгуурын чиглэлээр тусгай зөвшөөрлээ нусам төлөвлөгөө бичлээ /	
Хүснэгт 14. Цэвэрлэх байгууламжийн судалгаа		Хүснэгт 15. Боир уус шинжилгээ /Шинжилгээний бичлэг хягт хавсаргах/		Хийг, гүйдлээс ажил, үйлчилгээ түршигт, татгуурын чиглэлээр тусгай зөвшөөрлээ нусам төлөвлөгөө бичлээ /	
Хүснэгт 14. Цэвэрлэх байгууламжийн судалгаа		Хүснэгт 15. Боир уус шинжилгээ /Шинжилгээний бичлэг хягт хавсаргах/		Хийг, гүйдлээс ажил, үйлчилгээ түршигт, татгуурын чиглэлээр тусгай зөвшөөрлээ нусам төлөвлөгөө бичлээ /	

6. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи - Байгууллага, компанийн санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад дотоодын зээл, өр, авлага, бэлэн мөнгөний нөөц зэргийн талаарх мэдээлэл, судалгаа

6.1 Тусгай зөвшөөрөл авах

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагын санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны чадамжийг тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор дараах маягаар тооцоо, судалгааг ирүүлэх шаардлагатай.

- 6.1.1. Тооцооны 1-9-р хүснэгтийг хэмжих нэгжийн алдаагүй, томъёо засахгүй байх
- 6.1.2. Тооцооны зардал тус бүрээр задаргаа тооцоог хавсаргах
- 6.1.3. Задаргаа тооцооны анхан шатны баримт -тушаал, гэрээ, тооцооны акт хавсаргах
- 6.1.4. Байгууллагын сүүлийн 3 жилийн Санхүүгийн балансын хуулбарыг хавсаргах

6.1.5. Нийт материалыг дарааллын дагуу үдэж, Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын материалын хамт ирүүлэх

1.1 Тусгай зөвшөөрөл авах (12.2.1, 12.2.2, 12.2.3, 12.2.4, 12.2.5, 12.2.6, 12.2.7, 12.2.8, 12.2.9, 12.2.10, 12.2.11, 12.2.12, 12.2.13) ангиллын Санхүү, эдийн засгийн [тооцооны маягт](#)

6.2 Тарифын санал ирүүлэх

Дараах ангиллын ТЗЭ-д энэхүү маягтаар үйлчилгээний тарифын санал ирүүлнэ (12.2.1, 12.2.2, 12.2.3, 12.2.4, 12.2.5, 12.2.6, 12.2.7, 12.2.8, 12.2.9, 12.2.10, 12.2.11, 12.2.12, 12.2.13)

6.2.1. Товьёг

6.2.2. Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

6.2.3. Ус хангамжийн Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

6.2.4 Компанийн товч танилцуулга, Тариф өөрчлөх талаар тайлбар

6.2.5. Судалгааны А,Б болон 1-9 хүснэгтийг хэмжих нэгжийн алдаагүй, томьёо засахгүй байх

6.2.6. Судалгаанд орсон зардлын задаргаа тооцоог тус бүрээр хавсаргах

6.2.7. Задаргаа тооцооны анхан шатны баримт -тушаал, гэрээ, тооцооны акт хавсаргах

6.2.8. Байгууллагын сүүлийн 5 жилийн Санхүүгийн балансын хуулбарыг хавсаргах

6.2.9. Нийт материалыг дарааллын дагуу үдэж, дугаарлан хавтаслаад Албан тоотын хамт ирүүлэх

2.1 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны [Тарифын санал ирүүлэх тооцооны маягт](#)

6.3. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны санхүү эдийн засгийн тайлан

Дараах ангиллын ТЗЭ-д энэхүү маягтаар хагас жил (7.20-8.10 нд), жилийн эцсийн (дараа оны 2.10-2.30-нд) тайланг ирүүлнэ. (12.2.1, 12.2.2, 12.2.3, 12.2.4, 12.2.5, 12.2.6, 12.2.7, 12.2.8, 12.2.9, 12.2.10, 12.2.11, 12.2.12, 12.2.13)

6.3.1. Товьёг

6.3.2. Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

6.3.3. Ус хангамжийн Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

6.3.4. Компанийн Санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн товч тайлбар

6.3.5. Тайлангийн 1-13 хүснэгтийг хэмжих нэгжийн алдаагүй, томьёо засахгүй байх

6.3.6. Байгууллагын тайлант хугацааны Санхүүгийн балансын хуулбарыг хавсаргах

6.3.7. Нийт материалыг дарааллын дагуу үдэж, дугаарлан хавтаслаад Албан тоотын хамт ирүүлэх

3.1 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны Тайлан ирүүлэх [тооцооны маягт](#)

Хот, суурины ус хангамж, ариутгах таттуургын ашиглалт, засвар, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах таттуургын ашиглалт, засвар, үйлчилгээний тусгай зөвшөөрөл нөхцөл шаардлага”-ын хүрээнд хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, хяналт тавих, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь санхүү эдийн засгийн чиглэлээр, ашиглалт үйлчилгээ, технологийн чиглэлээр, хүний нөөцийн чиглэлээр тавигдах шаардлагуудыг биелүүлэхээс гадна үйл ажиллагааны чиглэл тус бүрд тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг хангах ёстой.

18. Хаягдал усны дүгнэлт

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу хоногт 50 шоометрээс их эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид Усны газраар дүгнэлт гаргуулах ба www.ewater.mn цахим системээр нэвтэрч шаардлагатай баримт бичгийг хавсарган хүсэлтээ илгээнэ. Хоногт 50 шоометрээс бага хэмжээтэй хаягдал ус гаргадаг бол Туул голын сав газрын захиргаанд хүсэлтээ цаасан хэлбэрээр өгч, дүгнэлт гаргуулна.



Хаягдал усны дүгнэлт гаргуулахад шаардлагатай материалын жагсаалт

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дүгнэлт гаргуулах хүсэлт бүхий албан бичиг
2. Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эрхэлж буй чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх түсгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
3. Цэвэрлэх байгууламж, ус цэвэрлэх төхөөрөмжийн технологийн схем, танилцуулга
4. Хаягдал усны хэмжээг баталгаажуулсан акт
5. Ус ашиглуулах дүгнэлт
6. Хаягдал усанд хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн эх хувиар. /улирал бүр 2-оос доошгүй удаа Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандартад заагдсан үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн байна/

<https://water.gov.mn/service-8>

Ус бохирдуулагч бодисын төлбөрийн хэмжээг хоногт 50 шоометрээс дээш хаягдал ус хаядаг бол лабораторийн шинжилгээний хариунд үндэслэдэг бол хоногт 50 шоометрээс бага хэмжээтэй хаягдал ус хаядаг бол жишиг үнээр тооцдог.

Усны газар нь хаягдал усны дүгнэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор татварын алба болон ус бохирдуулагчид хүргүүлдэг.

Төлбөр төлөгч нь тухайн улиралд байгаль орчинд шууд хаясан болон ариутгах татуургын байгууламжид нийлүүлсэн хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 9.1

Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрлагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах үүрэгтэй. Хэрэв ус бохирдуулагч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг хоёроос тав дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж, бохирдуулах бодис бүрээр тогтоодог.

Хаягдал усны дүгнэлт гаргуулах үед цэвэрлэсэн ус нь стандартад нийцэж байгаа эсэхийг хянан үзээд хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах эсэхээ шийддэг, түүнээс хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулах хүсэлтийг түсгайлан хүлээн авч шийдвэрлэдэггүй, өргөдлийн маягт байдаггүй.

Ус бохирдуулагчийг дараах нөхцөлд төлбөрөөс чөлөөлнө.

- Хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр;
- Хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр;

- Хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдсон бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар.

19. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл

Хаягдал усны хэмжээ, бохирдуулагч бодисын агууламжаас хамааран дараах байгууллагуудаас Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авна. Тухайлбал;

- Хоногт 50 шоометрээс их, эсхүл Усны тухай хуулийн 10.1.12-д заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагч нь Туул сав газрын захиргаанаас;
- Хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагч нь дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна.

Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны А/719/189 дүгээр тушаалаар батлагдсан байдаг.




Хаягдал усны дүгнэлт болон зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуй нэгжийн албан бичгийг үндэслэн энэхүү зөвшөөрлийг олгодог. Өөрөөр ямар нэгэн материал бүрдүүлж өгөх шаардлагагүй. Урьдчилан цэвэрлэх байгууламж барьж дууссаны дараа ашиглалтын үед энэ зөвшөөрлийг авах хэрэгтэй.


Анх авсан хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөлд тусгагдсан хаях, зайлуулах усны хэмжээ ихэсвэл зөвшөөрлийг шинээр авах ёстой, харин энэ хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгуулах ёстой.

Ус бохирдуулагчийн гол үүрэг нь зөвшөөрөлд заасны дагуу MNS 6561:2024 стандартын шаардлагад нийцтэл хаягдал усаа цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх шаардлагатай юм. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг байгальд шууд нийлүүлж байгаа этгээдтэй байгуулдаг ба төвлөрсөн ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлж байгаа этгээдтэй байгуулдаггүй.

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх (ҮХУУЦ) байгууламж барих ажлын үе шатыг Зураг 23-т үзүүлэв.

Зураг 23. Үйлдвэрийн газрын урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, батлуулах, барих, ашиглах, холбогдох зөвшөөрөл авах үе шат





11. Хяналт шалгалтын хуудаст өгсөн санал

Захиалагчаас өгсөн даалгаврын хүрээнд дараах хяналт шалгалтын хуудсуудад холбогдох салбарын хяналтын улсын байцаагч нартай уулзалт, ярилцлага хийж, санал хүсэлтийг авсан.

№	Батлагдсан тушаал	Шалгах хяналтын хуудас	Албан хаагчдаас өгсөн санал
1		№01.1.4 Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас	Хяналтын байцаагч нар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд аж ахуй нэгжийн мэдээллийг шилэн хяналтын цахим хуудас khyanalt.gov.mn -д бөглөдөг ба байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй тохиолдолд цааш ямар ч мэдээллийг бөглөх боломжгүй болдог. Тиймээс төсөл хэрэгжүүлэгч нар байгаль орчны нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай. Эдгээр баримт бичгүүдэд үндэслэн хяналт шалгалтыг ном журмын дагуу явуулах нөхцөл боломж бүрдэнэ.
2	Байгаль орчны сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/95 дугаар тушаал	№01.1.5 Төв болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шалгах хяналтын хуудас	Цэвэрлэгээний түвшин, технологийн хувьд төв болон урьдчилан цэвэрлэх байгууламж нь ялгаатай байдаг учир нэг шалгах хуудсаар шалгах боломж хязгаарлагдмал байдаг. Тиймээс хамааралтай зүйлсийг нь бөглөх байдлаар хяналт шалгалтыг явуулж, эрсдэлийг нь үнэлдэг. Ариутгах татуургын суурилуулалт, ашиглалт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч буй аж ахуй нэгжүүд бүтээгдэхүүний чанарын баталгааг 1-2 жил хариуцах, зүгшрүүлэх, хэрэглэгчидээ зөвлөмж, мэдээллээр хангах, хариуцлагатай болох шаардлагатай. Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулаад орхичихдог, ашиглалт, засвар үйлчилгээ хэрхэн хийх, стандартын шаардлага хангасан ус гарч байгаа эсэхээ, хаанаас нь бохир усны дээж авахаа ч хэрэглэгчид нь мэддэггүй.

3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/131 дүгээр тушаал	№8.1.1. Мал төхөөрөх үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	Жил бүр шалгах хяналтын хуудаст саналаа тусгадаг ба Сайдын тушаалаар шинэчлэгдэн батлагддаг тул нэмэлт өгөх санал байхгүй. Хүнс үйлдвэрлэл, эрүүл ахуй, бүтээгдэхүүний чанарын чиглэлээр хяналт шалгалт явуулдаг учир цэвэрлэх байгууламжтай холбоотой зүйл заалт нэмэх хэрэгцээ шаардлага байхгүй. Чиг үүргийн дагуу бусад төрийн байгууллагууд нь энэ чиглэлийн хяналтаа тавиад явдаг.
4		№8.2.1 Мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг шалгах хяналтын хуудас	
5		№8.29.1. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас	
6	Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/25 дугаар тушаал	02.4.2.Ус хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламж төвлөрсөн ус, хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээний ашиглалтыг шалгах хяналтын хуудас	
7		02.4.3 Барилга байгууламжийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ашиглалтын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	

12. Усны мэдээллийн нэгдсэн сан

Усны мэдээллийн нэгдсэн сан (<https://ewater.mn/home> вэб сайт)-д хандаж усны нөөц, ус ашиглалт, бохир усны талаар мэдээ мэдээлэл, зөвшөөрөл авах, дүгнэлт гаргуулах үйлчилгээ авах болон холбогдох хууль журам, заавар, зөвлөмж, нээлттэй мэдээлэлтэй танилцах боломжтой. Энэ сан, вэб сайтыг БОАЖЯ-ны Усны газар АНУ-ын Мянганы Сорилын сангийн санхүүжилтээр бүтээж нэвтрүүлээд ажиллуулж байна (Зураг 23). Уг сайтад байгаа мэдээлэл, үйлчилгээний нийт агуулгыг Зураг 24-т үзүүлэв.

11.1. Мэдээллийн санд байгаа хууль эрх зүй, заавар зөвлөмж

Сайтын Таны сонорт хэсэгт мэдээ, хууль эрх зүй, заавар зөвлөмж байгаа бөгөөд үүнд дараах зүйлийг оруулсан байна:

Монгол улсын хууль

- Төрийн албаны тухай
